



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

ХУУЛЬ, ТОГТООЛ, ЗАРЛИГ,
ШИЙДВЭР, ХУУЛИЙН ТАЙЛБАР

Монгол Улсын Их Хурлын Тамгын газар

№

1996 оны 7-р сар

№7 /50/

ГАРЧИГ

I. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

- | | | |
|----|---|-----|
| 1. | Соёлын тухай | 349 |
| 2. | Татвар ногдуулалт, төлөлтөд хяналт тавих, татвар хураах тухай | 359 |
| 3. | Улс төрийн намуудын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | 374 |
| 4. | Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай | 375 |

II. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

- | | | |
|----|--|-----|
| 5. | Монгол Улсын төрөөс баримтлах соёлын бодлогыг батлах тухай №15 | 384 |
| 6. | Соёлын хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай №21 | 389 |
| 7. | Нийслэлийн нутаг дэвсгэрийн хэргийн цэснийг шинэчлэн тогтоох тухай №24 | 389 |

III. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

- | | | |
|-----|---|-----|
| 8. | Хутагаа сунгах тухай №114 | 394 |
| 9. | Ч. Нямдарьд Монгол Улсын хүний гавьяат эмч цол олгох тухай №115 | 394 |
| 10. | П. Шижээд Монгол Улсын хүний гавьяат эмч цол олгох тухай №116 | 395 |
| 11. | Зарим шүүхийн шүүгчийг томилох тухай №123 | 395 |

**МОНГОЛ УЛСЫН
ТӨРИЙН ӨМЧ**


12. Дээд офицерын албан тушаалын ангилал, цэргийн цолны зэрэглэлд нэмэлт оруулах тухай №126 35

IV. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

13. Биеийн тамир, спортыг хөгжүүлэх үндсэн чиглэл батлах тухай №16 35
14. "Улсын сайн малчин", "Улсын тэргүүний тариаланч" шалгаруулах тухай №26 40
15. Иргэний хамгаалалтын улсын хяналтын дүрэм батлах тухай №27 40
16. Журам батлах тухай №38 40

V. МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТОГТООЛ

17. Дээд шүүхийн хуралдааны дэг батлах тухай №06 41



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

996 оны 4 дүгээр
арын 11-ний өдөр

Улаанбаатар
хот

СОЁЛЫН ТУХАЙ НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

Энэ хуулийн зорилт нь Монгол Улсад соёлын үйл ажиллагаа эрхлэх эрх зүйн үндэс, соёлын үйл ажиллагаанд оролцогчдын эрх, үрэг, соёлын удирдлагын тогтолцоо, соёлын ажилтны нийгмийн аламж баталгаа, соёлын байгууллагын өмч, санхүүжилтийн зарчим, рга хэлбэрийг тогтоож, уг үйл ажиллагаанд оролцогчдын хооронд үсэх харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Монгол Улсын соёлын
хууль тогтоомж

1. Монгол Улсын соёлын хууль тогтоомж нь Монгол Улсын үндсэн хууль, иргэний хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2. Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөр үрам тогтоосон бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл. Хуулийн нэр томьёо

Энэ хуульд хэрэглэсэн дор дурдсан нэр томьёог дараахь утгаар х.гноно:

1/ "соёлын үйл ажиллагаа" гэдэгт соёлын үнэт зүйлийг глэх, эзэмших, ашиглах, хадгалж хамгаалах, судлах, түтээн өлг рүүлэхтэй холбоотой дараахь үйл ажиллагаа хамаарна:

а/ уран зохиол, хөгжим, дүрслэх урлаг, театр, цирк, киноны ллаг, уран барилга, дизайн зэрэг урлагийн бүх төрлийн бүтээл урвил, нийтийн хүртээл болгох;

б/ соёлын үнэт зүйлийг бүтээх, хадгалж хамгаалах, нийтийн ртээл болгоход чиглэсэн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх;

в/ монгол үндэстэн болон угсаатан, ястны хэл, аялгуу, аман олон би игийн соёлыг хадгалж хамгаалах, сэргээн хөгжүүлэх;

г/ ирээдийн соёлын ерөнхий төвшинг дээшлүүлэх, уран йхан-гос зүйл боловсрол, хүмүүжил олгох;

д/ олон нийтийн мэдээллийн хэрэгслээр соёлын үйл ажиллагаа г вуулах;

с/ соёл судлалыг хөгжүүлэх;

ж/ соёлын гадаад харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэх

2/ "соёлын үнэт зүйл" гэдэгт гоо сайхны үзэл баримтлал, хэл, бичиг үсэг, аман аялгуу, уламжлалт технологи, газар усны зан заншил, билгэ тэмдэг, ардын аман зохиол, ном, судар, шашаа угийн бичиг, им, тамга, хадны зураг, бичээс, гар урлал, урлаг бүх төрлийн болон соёл судлалын бүтээл, судалгааны арга ба хамаарна;

3/ "соёлын байгууллага" гэдэгт энэ хуулийн дагуу соёлын ажиллагаа эрхэлж байгаа байгууллага, аж ахуйн нэгж хамаарна;

4/ "соёлын ажилтан" гэж бүх төрлийн уран бүтээлийг бүтээх, соёлын үнэт зүйлийг гүтээн дэлгэрүүдэх, хадгалан хамгаалах, сэргээн засварлах үйл ажиллагааг мэргэжлийн түвшинд дагд эрхэлж байгаа иргэнийг хэлнэ.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Соёлын талаархи иргэний эрх, үүрэг

4 дүгээр зүйл. Соёлын талаархи иргэний эрх

1. Монгол Улсын иргэн соёлын талаар дараахь эрх эдэлнэ:

1/ үндэсний болон дэлхий нийтийн соёлын үнэт зүйл танилцаах, соёлын үйл ажиллагаа явуулах, тэдгээрийн үр шимийг хүртэх;

2/ уран бүтээлийн сэдэв, төрөл зүйл, арга барил, дэг сургуу; урсгал чиглэлийг чөлөөтэй сонгон авах, үүдэл санаа, ур чадварынх нууцыг хамгаалуулах;

3/ Монгол Улсын болон тухайн орны хууль тогтоомжоо хориглосноос бусад соёлын үйл ажиллагааг гадаадад явуулах;

4/ эх хэл, бичиг үсэг, ёс заншил, түүх соёлын уламжлал өвлөн хөгжүүлэх;

5/ соёлын үйл ажиллагаа явуулах эрх, ашиг сонирхлоо хангалуулж мөрийгөө уран бүтээлийн зөвлөл, холбоо, нийгэмлэг байгуулах, тэдгээрт эвлэлдэн нэгдэх.

5 дугаар зүйл. Соёлын талаархи иргэний

журамт үүрэг

Монгол Улсын иргэн соёлын талаар дараахь журамт үүрэг хүлээнэ:

1/ түүх, соёлын уламжлалыг хамгаалж хөгжүүлэх;

2/ эх хэл, бичиг үсгээ судлах, өвлөх, өвлүүлэх;

3/ гэр бүлийн соёл, хүмүүжлийн уламжлалыг дээдэн хонжүүлж, удам угсаагаа мэдэх, угийн бичиг хөглөх;

4/ соёлын үнэт зүйлийг элдэв халдлагаас сөрөмжлэн хамгаалах.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Соёлын байгууллага

6 дугаар зүйл. Соёлын байгууллагын ангилал

1. Соёлын байгууллага нь өмчийн хэлбэрээс үл хамааран улс болон орон нутгийн чанартай гэсэн ангилалтай байна.

2. Улсын чанартай соёлын байгууллагыг тэргүүлэх болон төв байгууллага гэж ангилна. Соёлын байгууллагыг ажиллагчдын мэргэжлийн түвшин, ур чадвар, ажил үйлчилгээний чанар, шар хүрээг харгалзан соёлын тэргүүлэх болон төв байгууллагад хамааруулах журам жагсаалтыг Засгийн газар батална.

3. Хэд хэдэн аймгийн хүн амд соёл урлагаар үйлчлэх үүрэг бүхий бүс нутгийн соёлын байгууллага байгуулж болно.

4. Аймаг, нийслэл, сум, дүүргийн болон бүс нутгийн хүн амд соёл урлагаар үйлчлэх зорилго бүхий байгууллага нь орон нутгийн соёлын байгууллагад хамаарна.

7 дугаар зүйл. Соёлын байгууллагыг үүсгэн байгуулах

1. Аж ахуйн нэгж, байгууллага, иргэн хууль тогтоомжийн дагуу ашгийн төлөө болон ашгийн төлөө бус соёлын байгууллага байгуулан ажиллуулж болно.

2. Төрийн өмчийн соёлын тэргүүлэх, төв болон бүс нутгийн байгууллагыг байгуулах шийдвэрийг Засгийн газар гаргана.

3. Төрийн өмчийн бүс нутгийнхаас бусад орон нутгийн соёлын байгууллагыг байгуулах шийдвэрийг аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга гаргана. Шийдвэр гаргахдаа аймаг, нийслэлийн Засаг дарга соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай, сум, дүүргийн Засаг дарга аймаг, нийслэлийн Засаг даргатай тус тус зөвшилцөнө.

4. Соёлын байгууллагыг улсын бүртгэлд бүртгүүлж, гэрчилгээ авсан өдрөөс эхлэн байгуулагдсанд тооцно.

8 дугаар зүйл. Тусгай зөвшөөрөл олгох

1. Төрийн өмчийнхөөс бусад соёлын тэргүүлэх, төв болон бүс нутгийн байгууллагыг байгуулахад соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, орон нутгийн соёлын байгууллагыг байгуулахад аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга соёлын үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл /даашид "тусгай зөвшөөрөл" гэх/ олгоно.

2. Соёлын байгууллагыг үүсгэн байгуулагч нь тусгай зөвшөөрөл авахдаа дараахь баримт бичгийг бүрдүүлнэ:

1/ өргөдөл, үүсгэн байгуулах гэрээ, аж ахуйн нэгж, байгуулагын шийдвэрийн аль нэг;

2/ байгууллагын дүрэм;

3/ мэргэжлийн ажилтны болон авьяастны тодорхойлолт;

4/ санхүүгийн эх үүсвэр, хүчин чадал, түүний баталгаа.

3. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан эрх бүхий байгууллага, алба тушаалтан үүсгэн байгуулагчийн ирүүлсэн баримт бичгийг хүлээ авсан өдрөөс хойш 30 хоногийн дотор тусгай зөвшөөрөл олгосныг шийдвэрлэнэ.

9 дүгээр зүйл. Улсын бүртгэлд бүртгэх

1. Ашгийн төлөө бус соёлын тэргүүлэх болон төв байгууллага хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага орон нутгийн байгууллагыг аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар, ашгийн төлөө соёлын байгууллагыг тухайн нутаг дэвсгэрийг татварын алба улсын бүртгэлд бүртгэж гэрчилгээ олгоно.

2. Үүсгэн байгуулагч буюу тухайн соёлын байгууллагын дарга тусгай зөвшөөрлийг авснаас хойш 30 хоногийн дотор энэ хуулийн дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан баримт бичгийг эсхүл төрийн өмчийн соёлын байгууллага байгуулах тухай шийдвэрийг байгууллагын дүрмийн хамт бүртгэх байгууллагад ирүүлнэ.

3. Тусгай зөвшөөрөл аваагүй, эсхүл хуульд заасан журам зөрчиж авсан, баримт бичгийн бүрдэл дутуу бол бүртгэх байгууллага улсын бүртгэлд бүртгэхээс татгалзаж холбогдох баримт бичгийг 30 хоногийн дотор үүсгэн байгуулагчид буцаана.

10 дугаар зүйл. Тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох

1. Тусгай зөвшөөрөл олгосон байгууллага, албан тушаалта дараахь тохиолдолд олгосон зөвшөөрлөө хүчингүй болгоно:

1/ хууль тогтоомжоор хориглосон соёлын үйл ажиллагаа явуулсан ;

2/ улсын бүртгэлд бүртгүүлснээс хойш 1 жилийн дотор соёлын үйл ажиллагаа явуулаагүй;

3/ соёлын байгууллагыг татан буулгах, өөрчлөн байгуулах эсхүл тухайн байгууллагыг өөр ангилалд хамааруулж шинээр зөвшөөрөл олгох болсон;

4/ хуульд заасан бусад үндэслэл.

11 дүгээр зүйл. Соёлын байгууллага татан буулгах

1. Соёлын байгууллага дор дурдсан нөхцөлд татан буугдана:

1/ Тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон;

2/ татан буулгах тухай үүсгэн байгуулагчийн, эсхүл иүүхий шийдвэр гарсан.

2. Соёлын байгууллага татан буугдсанаас хойш 45 хоногийн ютор энэ тухай бүртгэх байгууллагад мэдэгдэнэ.

3. Хууль тогтоомжид заасны дагуу татан буулгах ажиллагаа хийгэж, бүртгэх байгууллага бүртгэлээс хассанаар соёлын байгууллагыг татан буугдсанд тооцно.

4. Соёлын байгууллага татан буугдсантай холбогдож үүссэн марзаныг шүүх шийдвэрлэнэ.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Соёлын удирдлага, зохицуулалт

12 дугаар зүйл. Соёлын удирдлагын тогтолцоо

Соёлын удирдлагын тогтолцоо нь соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн төвжлийн болон соёлын байгууллагын удирдлагаас бүрдэнэ.

13 дугаар зүйл. Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх

1. Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага араахь бүрэн эрхтэй байна:

1/ төрөөс баримтлах соёлын бодлого, соёлын хууль тогтоомсийг хэрэгжүүлэх ажлыг улсын хэмжээнд зохион байгуулах;

2/ хууль тогтоомжийн хүрээнд түүнийг хэрэгжүүлэх зорилгоор соёлын үйл ажиллагаанд дагаж мөрдөх дүрэм, журмыг батлан гаргах;

3/ өмчийн хэлбэрийг харгалзахгүйгээр соёлын байгууллагын үйл ажиллагаанд мэргэжлийн хяналт тавих, мэргэжлийн түвшин өгтоох;

4/ улсын чанартай болон орон нутгийн төрийн өмчийн соёлын байгууллагын оновчтой сүлжээ, бүтцийг бий болгож мөрдүүлэх;

5/ соёлын байгууллагыг санхүүжүүлэх асуудлыг холбогдох байгууллагатай хамтран шийдвэрлэх;

6/ түүх, соёлын дурсгалт зүйлийг хадгалах, хамгаалах ажлыг зохицуулах үндэсний соёл, дизайны уламжлалыг дэмжин хөгжүүлэх;

7/ эх хэл, бичиг үсэг, түүх, соёлын мэдлэгийг гүнзгийрүүлэх, ман сайхан-гоо зүйн хүмүүжил олгох бодлого боловсруулж хэрэгжүүлэх;

8/ олон улсын болон улсын чанартай соёлын арга хэмжээ зохион байгуулах, соёлын гадаад харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх;

9/ гадаадын байгууллага, иргэнд соёлын үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл олгох;

10/ дайн түрэмгийлэл, хүчирхийлэл, садар самууныг сурталчилсан соёлын үйл ажиллагааг явуулахыг хориглох;

11/ соёлын тоо бүртгэл гаргаж, дүн шинжилгээ хийх;

12/ соёлын мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх, соёлыг ажилтны нийгмийн баталгааг хангах асуудлыг холбогдох байгууллагатай хамтран шийдвэрлэх;

13/ олон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгслэлээр соёлыг үйл ажиллагаа явуулахад оролцох;

14/ ном, хэвлэл, кино үйлдвэрлэлийг хөгжүүлэх;

15/ соёл судлалыг хөгжүүлэн дэмжих.

2. Энэ зүйлийн 1 дэх хэсгийн 10-г зааснаар соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан шийдвэрийг талаар гарсан маргааныг шүүх шийдвэрлэнэ.

14 дүгээр зүйл. Иргэдийн Төлөөлөгчдийн хурал,
Засаг даргын бүрэн эрх

1. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурал тухайн нутаг дэвсгэрийн хэмжээнд соёлын талаар дэвшүүлсэн зорилтын биелэлтийг дүгнэж, түүний хөгжлийн хэтийн төлөвийг тодорхойлж, соёлын үйл ажиллагааны зардлын төсвийг хэлэлцэж баталж, гүйцэтгэлд нь хяналт тавина.

2. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга тухайн нутаг дэвсгэрт соёлын асуудлаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1/ төрийн соёлын бодлого, соёлын хууль тогтоомжийн дагуу соёл урлагийг хөгжүүлэх, иргэдийн соёлын эрэлт хэрэгцээг хангах түүх, соёлын дурсгалт зүйлийг хамгаалахад чиглэсэн арга хэмжээг хөтөлбөртөө тусгаж, хэрэгжүүлэх;

2/ соёлын байгууллагуудын үйл ажиллагааг зохицуулж, хууль тогтоомжид заасны дагуу санхүүжүүлэх тэдэнд дэмжлэг тусалцаа үзүүлэх, ажиллагчдын нийгмийн баталгааг хангах арга хэмжээг авах;

3/ Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан соёлын зорилтыг хэрэгжүүлэх ажлыг соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулах;

4/ угийн бичиг хөтлөх ажлыг Засгийн газраас баталсан журмын дагуу зохион байгуулах.

3. Баг, хорооны Засаг дарга харьяалах нутаг дэвсгэрийн хүамын соёлын үйлчилгээг сайжруулах ажлыг холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулах, соёлын талаархи иргэний журам дүүргийн биелэлтийг хангуулах арга хэмжээг хэрэгжүүлнэ.

15 дугаар зүйл. Соёлын байгууллагын удирдлага

1. Соёлын байгууллагыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажлыг соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага,

усгайлан эрх олгосон соёлын тэргүүлэх болон төв байгууллага эрэгжүүлнэ.

2. Төрийн өмчийн соёлын тэргүүлэх, төв болон бүс нутгийн байгууллагыг соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас томилсон дарга удирдана. Орон нутгийн төрийн өмчийн соёлын байгууллагыг тухайн аймаг, нийслэлийн Засаг дарга соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай, сум, дүүргийн Засаг дарга аймаг, нийслэлийн Засаг даргатай тус тус зөвлөцөн томилсон дарга, захирал удирдана.

3. Төрийн өмчийнхөөс бусад соёлын байгууллагыг үүсгэн байгуулгчийн томилсон дарга удирдана.

ТАВДУГААР БҮЛЭГ

Соёлын харилцаанд оролцогчдын эрх, үүрэг

16 дугаар зүйл. Төрийн захиргааны төв байгууллагуудын
үүрэг

1. Төрийн захиргааны төв байгууллагууд соёлын талаар дараахь нийтлэг үүрэг хүлээнэ:

1/ төрөөс баримтлах соёлын бодлого, соёлын хууль тогтоомж, эсгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан соёлын зорилгыг хэрэгжүүлэх ажлыг соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран зохион байгуулах;

2/ үйлдвэрлэл, үйлчилгээ, бизнес, эрх зүй, экологи, ахуйн хэргийг хөгжүүлэх ажлыг соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран буюу дангаар зохион байгуулах.

17 дугаар зүйл. Соёлын байгууллагын нийтлэг
үүрэг

Соёлын байгууллагууд дараахь нийтлэг үүрэгтэй байна:

1/ соёлын үйл ажиллагааг хууль тогтоомжийн хүрээнд мэргэжлийн ур чадвар, үйлчилгээний өндөр түвшинд явуулах;

2/ төсөв, төслийн болон хандивын хөрөнгийг зориулалтаар нь ашигтай зарцуулах;

3/ соёлын ажилтны мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, ийгмийн баталгааг нь хангах.

18 дугаар зүйл. Аж ахуйн нэгж, байгууллагын
эрх, үүрэг

1. Аж ахуйн нэгж, байгууллага соёлын талаар дараахь үүрэгтэй байна:

1/ түүх, соёлын дурсгалт болон соёлын үнэт зүйлсийг хадгалх, хамгаалах;

2/ үйлдвэрлэл, үйлчилгээний соёл, гоо зүй үндэсний дизайны орчин бүрдүүлж хөгжүүлэх;

3/ ажиллагчдын ерөнхий соёлын түвшинг дээшлүүлэх, уран уран сайхны мэдрэмж, авьяас чадварыг хөгжүүлэх, соёлын үйлчлэлгээг сайжруулах.

2. Аж ахуйн нэгж, байгууллага соёлын талаар дараахь эрх эзээн

1/ соёлын салбарт тусламж дэмжлэг үзүүлэх зорилгоор хөрөнгө оруулалт хийх, хандив өргөх;

2/ жил бүрийн орлогын тодорхой хувийг соёлын зориулалта зарцуулах;

3/ ажиллагчдын оюуны хэрэгцээг хангах зорилгоор соёл үйл ажиллагаа эрхлэх нэгж байгуулан ажиллуулах.

19 дүгээр зүйл. Соёлын хүрээнд төрийн болон бусад

байгууллага, иргэнээс явуулах үйл ажиллагаанд тавих хязгаарлалт

1. Хууль тогтоомжоор хориглоогүй соёлын үйл ажиллагаа явуулахад төрийн болон бусад байгууллага, улс төрийн нэм, зэвсэглэл, холбоо, гэдгээрийн албан тушаалтан хөндлөнгөөс оролцох, дараа шахалт үзүүлэхийг хориглоно.

2. Угсаатан ястны соёлыг ялгаварлан гадуурхах, хявчин хязгаалахыг хориглоно.

3. Дайн түрэмгийтэл, хүчирхийлэл, садар самууныг сурталчла Монгол Улсын тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдал, соёл хохирол учруулах соёлын үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

4. Уран бүтээлчийн үүдэл санаа, ур чадварын нууцыг түүн зөвшөөрөлгүйгээр задруулахыг хориглоно.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ

Соёлын байгууллагын өмч, санхүүжилт,
соёлын ажилтайд үзүүлэх өмчийн
баталгаа

20 дугаар зүйл. Өмч

1. Соёлын байгууллага өмчийн хэлбэрийн хувьд төрийн болон төрийн бус хэлбэртэй байна.

2. Соёлын зориулалтаар ашиглаж байгаа төрийн өмчийн барилд байгууламж, эзэмшил газрыг өөр зориулалтаар ашиглах, бусад түрээслүүлэх, эзэмшүүлэх асуудлыг хууль тогтоомжийн дагуу шийдвэртэнэ.

21 дүгээр зүйл. Соёлын байгууллагын
санхүүжилт

1. Соёлын байгууллага нь улсын төвлөрсөн, орон нутгийн төсвийн болон бусад хөрөнгө оруулалт, дотоод, гадаадын аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн хандив, хөнгөлөлттэй зээл, тусгай сангийн хөрөнгө, соёлын байгууллагын өөрийн орлого зэрэг санхүүгийн эх үүсвэртэй байна.

2. Ашгийн төлөө бус төрийн өмчийн соёлын тэргүүлэх, төв болон орон нутгийн байгууллага үйл ажиллагаагаа улсын төвлөрсөн болон орон нутгийн төсвийн хөрөнгө, өөрийн үйл ажиллагааны орлогоор санхүүжүүлнэ.

3. Төрийн өмчийнхөөс бусад ашгийн төлөө бус соёлын байгууллагад тодорхой төслийг үндэслэн төрөөс санхүүгийн дэмжлэг туслалцаа үзүүлж болно. Төсөл шалгаруулах журмыг Засгийн газар тогтооно.

4. Соёлын зардыг улсын төвлөрсөн болон орон нутгийн төсөвт бие даасан зүйл болгож батална.

5. Соёлыг хөгжүүлэх зорилгоор тусгай зориулалт бүхий санг байгуулан ажиллуулж болно. Уг сангийн ажиллах журмыг Засгийн газар тогтооно.

6. Соёлыг хөгжүүлэх, түүх, соёлын дурсгалт зүйлийг хамгаалах зориулалт бүхий төрийн санд байгууллага, иргэнээс оруулсан хандив, хөрөнгө оруулалтад албан татварын хөнгөлөлт үзүүлэх журмыг хуулиар тогтооно.

7. Соёлын байгууллагыг санхүүжүүлэх нэмэгдэл эх үүсвэр бий болгох зорилгоор Үндэсний хонжворт сугалааг зохион байгуулж болно. Үндэсний хонжворт сугалаа гаргах журмыг Засгийн газар тогтооно.

8. Соёлын үйл ажиллагаанд зориулсан төсвийн болон сангийн хөрөнгийг өөр зориулалтаар зарцуулахыг хориглоно.

22 дугаар зүйл. Соёлын ажилтны нийгмийн
баталгаа

1. Соёлын ажилтан нь дараахь нийгмийн баталгаагаар хангагдана:

1/ тэтгэвэрт гарах үед ажиллаж байсан байгууллага нь тэтгэвэр тогтооход баримталсан хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах эрлогын нэг жилийн дундажтай тэнцэх хэмжээний тэтгэлгийг тэтгэвэрт гарахад нь нэг удаа олгоно;

2/ хөдөлмөрийн нөхцөл, мэргэжлийн онцлогийг харгалзан нэмэгдэл цалин, урамшил, эрдмийн зэрэг, цолны болон урдварын нэмэгдэл хөлс олгоно;

3/ нийгмийн даатгалын хуулийн 20 дугаар зүйлд заасан соёлын ажилтан ажлын онцлогоос хамаарч мэргэжлийн хөдөлмөрийн

чадвараа эрт алдсан тохиолдолд түүний хүсэлтийг нь үндэслэл дотоодын сургууль, курсээр тусгай мэргэжил эзэмших сургалтын зардлыг төр хариуцна;

4/ хуульд заасан бусад баталгаа.

2. Энэ зүйлийн 1 дэх хэсгийн 2, 3 дахь заалтад хамраах мэргэжлийн жагсаалт, нэмэгдэл хөлс, сургалтын зардал олгох журмыг Засгийн газар батална.

ДОЛДУГААР БҮЛЭГ

Бусад зүйл

23 дугаар зүйл. Соёлын хууль тогтоомж зөрчигчдэд хүлээлгэх хариуцлага

1. Соёлын хууль тогтоомж зөрчигчдэд эрүүгийн хариуцлагыг хүлээлгэхээргүй бол дор дурдсан захиргааны хариуцлага хүлээлгэнэ:

1/ зөвшөөрөлгүйгээр соёлын үйл ажиллагаа эрхэлсэн гэм буруутай иргэнийг 10000-50000 төгрөгөөр, байгууллагыг 80000-250000 төгрөгөөр торгох;

2/ дайн, хүчирхийллийг сурталчилсан бүтээлийг түгээн дэлгэрүүлэх соёлын үйл ажиллагаа явуулсан нь эрүүгийн хариуцлагыг хүлээлгэхээргүй бол гэм буруутай иргэнийг 25000-50000 төгрөгөөр байгууллагыг 70000-250000 төгрөгөөр торгох.

2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан захиргааны хариуцлагыг шүүгч ногдуулна.

24 дүгээр зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

Энэ хуулийг 1996 оны 6 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн дагал мөрдөнө.

Монгол Улсын Их Хурлын дарга

Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1996 оны 4 дүгээр
сарын 18-ны өдөр

Улаанбаатар
хот

ТАТВАР НОГДУУЛАЛТ, ТӨЛӨЛТӨД ХЯНАЛТ ТАВИХ, ТАТВАР ХУРААХ ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

Энэ хуулийн зорилт нь татвар ногдуулалт, төлөлтөд хяналт тавих, татвар хураахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Татвар ногдуулалт, төлөлтөд хяналт тавих, татвар хураах тухай хууль тогтоомж

Татвар ногдуулалт, төлөлтөд хяналт тавих, татвар хураах тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль, Татварын ерөнхий хууль, татварын хуулиуд, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

3 дугаар зүйл. Татварын алба, байцаагчийн хууль дээдлэх, бусдын нөлөөнд үл явгах зөрчмөг хангах

1. Улсын татварын алба /цаашид "Татварын алба" гэх/, байцлагч бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ бусдын нөлөөнд үл явган галцруу хууль, түүнд нийцүүлэн гаргасан эрх зүйн бусад актыг удирдлага болгоно.

2. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтан нь татварын алба, байцаагчаас бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд хөндлөнгөөс ирцож дарамт, шахалт үзүүлэхийг хориглоно.

3. Татварын алба, байцаагчийн бүрэн эрхэд хамраах асуудлаар ууль тогтоомжоор эрх олгосноос бусад иргэн, албан тушаалтан, уулийн этгээд шийдвэр гаргахыг хориглоно.

4. Хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол аливаа этгээд татвар ногдуулах, хөнгөлөх, чөлөөлөхтэй холбогдсон асуудлаар бусдын мнө үүрэг хүлээж болохгүй.

5. Татварын хууль тогтоомжийг улсын хэмжээнд нэг мөр дагаж нөрдөх нөхцөлийг бүрдүүлэх, түүний биелэлтийг хангахтай холбогдуулан Татварын албаны удирдах дээд байгууллагаас хууль тогтоомгод нийцүүлэн гаргасан журам, заавар, аргачлалыг байгууллага, аж ахуйн нэгж, иргэн дагаж мөрдөнө.

4 дүгээр зүйл. Татвар төлөгчийн эрх, хууль ёсны
ашиг сонирхлыг хүндэтгэх
зарчмыг хангах

1. Татварын алба байцаагч нь бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ татвар төлөгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэж тэдэнд итгэл үзүүлэн ажиллана.

2. Татварын алба, байцаагч хуульд заасны дагуу татварын ногдлыг тодорхойлох, татвар төлөлтөд хяналт тавих, хураахтай холбоотойгоос бусад асуудлаар татвар төлөгчийн үйл ажиллагаанд үү оролцоно.

3. Татварын алба болон байцаагч, татварын албаны бусад албан тушаалтан нь албан үүргээ гүйцэтгэх явцад олж мэдсэн Хувь хүний нууцын тухай хууль болон Байгууллагын нууцын тухай хуулиа тодорхойлсон татвар төлөгчийн нууцыг хаагалах үүрэгтэй бөгөөд зөвхөн төрийн байгууллагын дор дурдсан албан тушаалтанд Татварын албаны даргын шийдвэрээр танилцуулж болно:

1/ татварын хууль тогтоомжийн дагуу албан үүргээ гүйцэтгэж байгаа татварын албаны бусад байцаагч, албан тушаалтан;

2/ татварын хууль тогтоомжийг зөрчсөнтэй холбогдуулан хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, шүүн таслах ажиллагаа явуулж байгаа болон прокурорын байгууллагын эрх бүхий албан тушаалтанд үү зөрчилд нь холбогдох асуудлаар;

3/ Монгол Улсын олон улсын гэрээгээр хүлээсэн үүргийн дагуу бусад орны татварын байгууллагын эрх бүхий албан тушаалтан.

4. Энэ зүйлийн 3 дахь хэсэгт зааснаас бусад тохиолдолд татвар төлөгчийн зөвхөн бичгээр өгсөн зөвшөөрлийг үндэслэн түүний тухай мэдээ, баримтыг бусад танилцуулж болно.

5. Татварын алба татварын хууль тогтоомжийг зөрчсөн нь нотлогдсон, эсхүл татварын үйл ажиллагааг нь сурталчлахыг татвар төлөгч зөвшөөрснөөс бусад тохиолдолд татвар төлөгчийн тухай нийтэд мэдээлэх эрхгүй.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Татварын албанаас татвар төлөгчтэй
харилцах

5 дугаар зүйл. Татвар төлөгчийг бүртгэх

1. Татвар ногдох орлого бүхий иргэн, аж ахуйн нэгж, байгууллаг болон бусад олгосон орлогод ногдох татварыг суутган авагч этгээ нь хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол үйл ажиллагаагаа эрхэлд эхлэхээс ажлын 10 хоногийн өмнө Татварын албанд бүртгүүлнэ.

2. Орлогоос бусад татвар ногдох зүйл бүхий иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол уг зүйлийг эзэмшиж эхэлснээсээ хойш нэг сарын дотор Татварын албанд бүртгүүлнэ.

3. Татвар төлөгч иргэний бүртгэлд түүний овог нэр, хаяг, иргэний бүртгэлийн болон эрхлэх үйл ажиллагааны нэр төрлийг тусгасан байна.

4. Татвар төлөгч аж ахуйн нэгж, байгууллагын бүртгэлд тэдгээрийн нэр, хаяг, эрхлэх үндсэн үйл ажиллагааны болон төлөх татаарын нэр төрөл, удирдлагын овог нэр, банкын дахь дансны дугаарыг тусгана.

5. Татвар төлөгч нь бүртгэлд тусгагдсан зүйл өөрчлөгдөх тухай бүрт хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол өөрчлөлт орсноос хойш нэг сарын дотор Татварын албанд мэдэгдэж бүртгэлдээ өөрчлөлт хийлгэх үүрэгтэй.

6. Татварын алба татвар төлөгч, татвар суутган авагч тус бүрт бүртгэлийн байнгын дугаар олгож, энэ дугаарыг тухайн татвар төлөгчөөс төлбөл зохих бүх төрлийн татварт болон татвар төлөгчид өгч байгаа мэдээ баримтад хэрэглэнэ.

7. Татвар төлөгч, татвар суутган авагч нь татварын хууль тогтоомжийн дагуу гаргаж байгаа тайлан мэдээ, гаалийн мэдүүлэг, төлбөрийн болон бусад шаардлагатай баримтад бүртгэлийн дугаараа тусгаж байх үүрэгтэй.

Өөрт нь орлого олгож байгаа аливаа этгээдэд татвар төлөгч бүртгэлийн дугаараа мэдээлж байх үүрэгтэй.

8. Татвар төлөгч, татвар суутган авагчийг бүртгэх, бүртгэлийн дугаар олгох журмыг Татварын албаны удирдах дээд байгууллагаас тогтооно.

6 дугаар зүйл. Татвар төлөгчдөд үйлчлэх

Татварын алба, байцаагч хууль тогтоомжоор тодорхойлогдсон татвар төлөх үүргээ биелүүлэхэд нь татвар төлөгчдөд туслах зорилгоор дараахь үйлчилгээг үзүүлнэ:

1/ татварын хууль тогтоомжийг тайлбарлан таниулах;

2/ татварын хууль тогтоомжийг нэг мөр дагаж мөрдөх, татварын үүргийг тодорхойлох, тайлан мэдээ гаргахтай холбогдсон заавар, аргачлал, гарын авлага, маягтаар хангах;

3/ татварын үүргээ биелүүлэхтэй холбогдсон асуудлаар татвар төлөгч хэсгээрээ буюу ганцаарчлан зөвлөгөө авах боломжийг бүрдүүлэх.

7 дугаар зүйл. Татварын алба, байцаагчаас татвар

төлөгчтэй харилцахад үйлдэх

баримт бичиг

1. Татварын алба, байцаагчаас татвар ногдуулалт, төлөлтөд хяналт тавих, татвар хураахтай холбогдсон бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ мэдэгдэл, акт, шаардлага, мэдэгдэх хуудас, төлбөрийн хуудас үйлдэнэ. Татварын алба, байцаагчийн хууль ёсны мэдэгдэл, акт, шаардлага, мэдэгдэх хуудас, төлбөрийн хуудсанд тавигдсан шаардлагыг татвар төлөгч биелүүлэх үүрэгтэй.

2. Татварын алба, байцаагч нь Татварын ерөнхий хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 1-4-т заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэх, татвар төлөгч болон бусад этгээдийг дуудан ирүүлэхэд мэдэгдэл бичнэ. Мэдэгдэлд түүнийг бичсэн он, сар, өдөр, Татварын алба, байцаагчийн нэр, шаардлага биелүүлэх хутагаа, гардуулсан он, сар, өдрийг тусгана.

3. Татварын алба, байцаагч нь татвар төлөгчид татварын хууль тогтоомжийн дагуу ногдох татварыг тодорхойлох, Татварын ерөнхий хуулийн 13 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан хариуцлага хүлээлгэхэд акт үйлдэнэ. Актд түүнийг бичсэн он, сар, өдөр, Татварын алба, байцаагчийн нэр, зөрчлийн тухай тэмдэглэл, шийдвэрлэсэн үндэстэл, гардуулсан он, сар, өдрийг тусгана.

4. Татварын алба, байцаагч нь татварын хууль тогтоомжийг зөрчихөд нөлөөлсөн шалтгаан нөхцөлийг арилгуулах зорилгоор шаардлага бичнэ. Шаардлагад түүнийг бичсэн он, сар, өдөр, Татварын алба, байцаагчийн нэр зөрчлийн тухай тэмдэглэл, зөрчил гарахад нөлөөлсөн нөхцөл, шалтгааныг арилгаж хариу өгөх хутагаа, гардуулсан он, сар, өдрийг тусгана.

5. Татвар төлөгчийн хутагаандаа төлөөгүй болон жишгээр ногдуулсан татварын ногдлыг төлүүлдэхээр мэдэгдэх хуудас бичнэ. Мэдэгдэх хуудсыг татвар төлөгчид гардуулах бол энэ хуулийн 18 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, татвар төлөгчийн харилцагч банкнд өгөх бол энэ хуулийн 23 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу уг хуудсыг үйлдэнэ.

6. Цалин хөлс, бусад орлогоос татварын төлбөр гаргуулах бол татвар төлөгчид орлого олгож аж ахуйн нэгж, байгууллагад төлбөрийн хуудас бичнэ. Төлбөрийн хуудсанд татварын төлбөрийг хүлээн авах газрын нэр, хаяг, бичсэн он, сар, өдөр, Татварын алба, байцаагчийн нэр, татвар төлөгчийн хаяг, төлөх татварын хэмжээ, гардуулсан он, сар, өдөр хариу мэдэгдэх хутагааг тусгана.

7. Татварын алба байцаагчийн мэдэгдэл, акт, шаардлага, мэдэгдэх болон төлбөрийн хуудсыг татвар төлөгчид биечлэн гардуулсан буюу тэдгээрийн оршин байгаа эсхүл ажиллаж байгаа газрын хаягаар шуудангаар хүргүүлснийг дээрхи мэдэгдэл, акт, шаардлага, мэдэгдэх болон төлбөрийн хуудсыг зохих татвар төлөгчид өгсөнд тооцно. Оршин байгаа буюу ажиллаж байгаа газрын хаяг нь

суулийн этгээд буюу иргэний бүртгэлийг хөглөх байгууллагад самгийн сүүлд бүртгүүлсэн хаяг байна.

8 дугаар зүйл. Татвартай холбогдсон баримт бүрдүүлэх,
бүртгэл хөглөх, хадгалах

1. Татвар төлөгч нь хууль тогтоомжийн дагуу татвар ногдох зүйл, гөлөх татварын хэмжээг тодорхойлохтой холбогдсон баримтыг бүрдүүлж, аж ахуйн нэгж, байгууллагын тухайд нягтлан бодох бүртгэл, иргэний тухайд энгийн бүртгэл хөглөнө.

2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан баримт бичгийг гадаад хэл дээр үйлдсэн бол татвар төлөгч түүнийг монгол хэл дээр орчуулж өгөх үүрэг хүлээнэ. Ийнхүү орчуулахтай холбогдсон зардлыг татвар төлөгч хариушина.

3. Татвар төлөгч болон түүний баримтыг бүрдүүлэх, бүртгэл хөглөх үүрэг хүлээсэн этгээд нь уг баримт, бүртгэлийг татвар төлөх мөн хэлэлцэх хугацаа дуустал Монгол Улсын нутаг дэвсгэрт хадгална.

9 дүгээр зүйл. Татварын тайлан, орлого, татвар
тодорхойлох хуудсыг бөглөх,
тушаах

1. Татвар төлөгч татварын тайлан, орлого, татвар тодорхойлох уудас /цаашид "татварын тайлан" гэх/-ыг хуулиар тогтоосон хугацаанд, батлагдсан загвар, зааврын дагуу бөглөж, хөрвөөлсөн Татварын албанд тушаана.

2. Хууль тогтоомжийн дагуу татварын чөлөөлөлт, хөнгөлөлтөд амаарагдах татвар төлөгч нь татварын тайлан тушаах үүргээс өлөөлөгдөхгүй бөгөөд түүнд татварын хөнгөлөлт үзүүлэх, татвараас өлөөлөх эсэхийг татварын энэхүү тайланг үндэслэн шийдвэрлэнэ.

3. Татварын тайланд аж ахуйн нэгж, байгууллагын эрх баригч олон татвар төлөгч иргэн, эсхүл түүний хууль ёсны төлөөлөгч арын үсэг зурна.

4. Татвар төлөгчийн татварын тайланг гаргасан буюу гаргахад оролцсон этгээд татварын тайланд мөн гарын үсэг зурна. Хариуцсан үргийнхээ дагуу татварын тайланг гаргахад хэд хэдэн албан ушаалтан оролцдог бол татварын тайланд ерөнхий, ахлах нягтлан одогч, татварын итгэмжлэгдсэн нягтлан бодогч гарын үсэг зурна.

5. Татварын итгэмжлэгдсэн нягтлан бодогч Татварын албанд үртгүүлэн, шалгалт өгсөн байна. Татварын нэг итгэмжлэгдсэн нягтлан бодогч хэд хэдэн аж ахуйн нэгж, байгууллагын татварын ооцоог хийхэд оролцож болно.

6. Татвар ногдох зүйлийг бусдад шилжүүлсэн аливаа этгээд нь нэ тухай баримтыг уг зүйлийг шилжүүлэн авсан этгээдэд тухай бүр, татварын албанд шаардсан үед гаргаж өгөх үүрэг хүлээнэ.

10 дугаар зүйл. Татварын алба мэдээ, баримт цуглуулах

1. Татварын байцаагч нь Татварын ерөнхий хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 1, 2, 3-г заасан үйл ажиллагааг явуулж татвар төлөгчийн татварын үүргийг тодорхойлох, татвар хураахтай холбогдсон мэдээ, баримт цуглуулахдаа дараахь журмыг баримтална:

1/ Татварын байцаагчийн үнэмлэхээ үзүүлж, үйл ажиллагааныхаа зорилгыг тайлбарлах;

2/ аливаа баримт, мэдээ, материалыг түр хугацаагаар хураан авах, хуулбарлахдаа хөндлөнгийн гэрчийг байлцуулан тэмдэглэл үйлдэж, гэднээр гарын үсгийг зуруулах;

3/ нотолгооны чанартай бичиг баримтын гэрэл зургийг авах, дүрс бичлэг хийх;

4/ тайлбар, лавлагааг бичгээр гаргуулах, эсхүл тэмдэглэл үйлдэж, холбогдох этгээдээр гарын үсэг зуруулах;

5/ татвар төлөгчийн татварын үүргийг тодорхойлох, татвар хураахтай холбогдсон мэдээ, баримтыг татвар төлөгч болон холбогдох этгээдээс шаардах.

2. Татварын байцаагч шаардлагатай мэдээ баримтыг хуулбарлан авахдаа бусдын техник хэрэгслийг ашигласан бол ашигласны хөлсийг зах зээлийн үнээр, эсхүл харилцан тохиролцсон үнээр төлнө.

11 дүгээр зүйл. Байр, агуулахад нэвтрэн орох журам

1. Татварын байцаагч Татварын ерөнхий хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 4-г заасан орлого олох зориулалтаар ашиглаж байгаа, эсхүл татвар ногдох зүйл болон татварын үйл ажиллагаа явуулахад шаардлагатай мэдээ, судалгаа, бусад холбогдох баримт бичгийг хадгалж байгаа татвар төлөгчийн нэвтрэн орохыг хуулиар хориглоогүй аливаа үйлдвэрлэл, үйлчилгээний болон албан байр, агуулах, зооринд урьдчилан мэдэгдэхгүйгээр нэвтрэн орж шаардлагатай ажиллагааг явуулна.

2. Энэ зүйлийн 1 дэх хэсгийн заалт нь гадаад орны дипломат болон консулын газар, олон улсын байгууллагын төлөөлөгчийн газрын дипломат эрх бүхий албан тушаалтны ажлын байр, агуулахад хамаарахгүй.

12 дугаар зүйл. Үзлэг хийх журам

1. Татварын байцаагч нь татвар төлөгчийн татварын үүргийг тодорхойлох, татвар хураах зорилгоор Татварын ерөнхий хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 4-г заасны дагуу үзлэг хийхдээ дараахь журмыг баримтална:

1/ үзлэг хийхдээ хөндлөнгийн гэрч байлцуулна;

2/ үзлэг хийх ажиллагаанд үзлэгт хамрагдаж байгаа байр, агуулах, хадгалах, тээвэрлэх, зөөвөрлөх сав хэрэгсэл эзэмшигч, эсхүл түүний

хууль ёсны төлөөлөгч, хэрэв боломжгүй бол зохих нутгийн захиргааны төлөөлөгчийг байлцуулна. Үзлэг хийхэд шаардлагатай бол хувийн сонирхолгүй, холбогдох мэргэжилтэнг урьж оролцуулж болно;

3/ үзлэг явуулсан тухай тэмдэглэл үйлдэнэ. Үзлэг хийхэд оролцсон, байлцсан бүх хүмүүс тэмдэглэлд гарын үсэг зурна. Үзлэгт оролцогчид, байлцсан хүмүүс гарын үсэг зурахаас татгалзвал энэ тухай шалтгааныг тайлбарлах бололцоо олгож тайлбарыг тэмдэглэлд бичнэ.

2. Үзлэгт хамрагдах зүйл нь хэний эзэмшилд байгаагаас үл хамаарч үзлэгийг хийнэ.

13 дугаар зүйл. Тооллого явуулах
журам

Татварын байцаагч татвар төлөгчийн татварын үүргийг тодорхойлох зорилгоор Татварын ерөнхий хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 4-т заасны дагуу тооллого хийхдээ дараахь журмыг баримтална:

1/ бараа, эд хөрөнгө, бэлэн мөнгө, үнэт цаасны тооллогыг татвар төлөгч буюу түүний хууль ёсны төлөөлөгч, хэрэв боломжгүй бол тухайн нутгийн захиргааны байгууллагын төлөөлөгчийг байлцуулан хийж тооллогын бүртгэл, тэмдэглэл үйлдэнэ;

2/ тооллогын бүртгэл, тэмдэглэлд тооллого явуулсан татварын байцаагч, татвар төлөгч, эсхүл түүний хууль ёсны төлөөлөгч гарын үсэг зурна. Татвар төлөгч, эсхүл түүний хууль ёсны төлөөлөгч тооллогын бүртгэлд гарын үсэг зурахаас татгалзвал энэ тухай шалтгааныг тайлбарлах бололцоо олгож тэмдэглэл үйлдэн тооллогын бүртгэлд хавсаргана.

14 дүгээр зүйл. Ажлын зураг авалт хийх журам

Татварын байцаагч Татварын ерөнхий хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 4-т заасны дагуу ажлын зураг авалт хийхдээ дараахь журмыг баримтална:

1/ татвар төлөгчийн зөвхөн төлбөл зохих татварын хэмжээг гадархойлох, үйлдвэрлэл, үйлчилгээний хэмжээ зардлыг тогтоох зорилгоор ажлын зураг авалт хийнэ;

2/ ажлын зураг авалтыг татвар төлөгчид урьдчилан мэдэгдэх буюу мэдэгдэхгүйгээр хийж болно. Ажлын зураг авалт хийх тухай /урьдчилан мэдэгдсэн тохиолдолд уг үйл ажиллагаанд татвар төлөгчийг, урьдчилан мэдэгдээгүй тохиолдолд хөндлөнгийн гэрчийг оролцуулж болно;

3/ ажлын зураг авалтад төрөл бүрийн хэмжих хэрэгсэл шиглаж холбогдох мэргэжилтэн оролцуулж болно;

4/ татварын байцаагч ажлын зураг авалтын тэмдэглэл, тооцоог хөгөлж, оролцсон этгээдүүд гарын үсэг зурна. Ажлын зураг авалтад оролцсон аливаа этгээд тэмдэглэлд гарын үсэг зурахаас татгалзвал энэ тухай тайлбарыг тэмдэглэлд бичнэ.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Төлбөл зохих татварын ногдлыг тодорхойлох, бүртгэх, барагдуулах

15 дугаар зүйл. Татварын ногдлыг тодорхойлох,
хянан шалгах

1. Татвар төлөгч холбогдох баримт, бүртгэлд үндэслэн татварын ногдлоо өөрөө тодорхойлон татварын тайланд тусгана. Татвар төлөгч татварын ногдлыг буруу тодорхойлсон гэж үзвэл Татварын алба, байцаагч шалган тогтооно.

2. Татвар төлөгч хуульд заасан хугацаанд татварын тайланг гушаагаагүй буюу гушаасан боловч түүнд татварын ногдлыг тусгаагүй бол Татварын алба, байцаагч өөрт байгаа мэдээ, баримтад тулгуурлан тодорхойлох, шалгах, жишгээр ногдуулах үндсэн дээр татварын ногдлыг тодорхойлно.

3. Татварын алба, байцаагчийн татварын ногдлыг тодорхойлох, хянан шалгах бүрэн эрх нь татвар төлөх хөөн хэлэлцэх хугацаа дуустал хүчин төгөлдөр байна.

16 дугаар зүйл. Татварын ногдлыг бүртгэх

Хууль тогтоомжийн дагуу төлөхөөр тогтоогдсон татварын ногдол, төлөлтийн бүртгэлийг Татварын алба татвар төлөгч бүрээр хөтөлнө.

17 дугаар зүйл. Татварын ногдлыг жишгээр
тодорхойлох

1. Үйлдвэрлэл, үйлчилгээ явуулж байгаа болон явуулж байсан нь нотлогдож байгаа боловч үйл ажиллагааныхаа баримтыг бүрдүүдлээгүй, бүртгэл хөглөөгүй буюу дутуу хөгөлсөн, эсхүл баримт бүртгэл татварын тайланг гаргаж өгөөгүй тохиолдолд тухайн татвар төлөгчийн татварын ногдлыг Татварын алба жишгээр тодорхойлно.

2. Татвар төлөгчтэй ойролцоо хүчин чадал, нөхцөл бүхий адилтгах үйлдвэртэл, үйлчилгээг тухайн орон нутагт эрхэлж буй татвар төлөгч байгаа бол түүний, байхгүй бол ойролцоо орон нутагт оршдог хэд хэдэн татвар төлөгчийн үйлдвэртэл, үйлчилгээний хэмжээ орлого зарлагын буюу бусад бодит тооцоонд үндэслэн татварын хэмжээг тогтоохыг татварын ногдлыг жишгээр тодорхойлох гэнэ. У татвар төлөгч нь тухайн үйлдвэрлэл, үйлчилгээг татвар ногдуулах хугацаанаас өмнөх дараалсан хоёр жилд явуулж байсан бол түүний

тийнхүү үйлдвэрлэл үйлчилгээ явуулж байсантай холбогдох баримт, бүртгэл тооцоонд үндэслэн татварын ногдлыг тодорхойлж болно.

3. Татварын ногдлыг жишгээр тодорхойлох татварын байцаагчийг томилж, уг татварын хэмжээг тогтоох асуудлыг тухайн Татварын албаны даргын тушаалаар шийлвэрлэнэ.

18 дугаар зүйл. Мэдэгдэх хуудас гардуулах

1. Татвар төлөгчийн хугацаандаа төлөөгүй татвар болон энэ хуудлийн 15 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэгт заасан журмаар Татварын албанаас тодорхойлон тогтоосон татварыг төлүүдэхээр дараахь агуулам бүхий мэдэгдэх хуудсыг татвар төлөгчид гардуулна:

- 1/ татвар төлөгчийн овог, нэр;
- 2/ татвар төлөгчийн бүртгэлийн дугаар;
- 3/ мэдэгдэх хуудас бичсэн он, сар, өдөр;
- 4/ татвар ногдох зүйл;
- 5/ төлбөл зохих татварын хэмжээ;
- 6/ мэдэгдэх хуудас гардуулснаас хойш ажлын 10 хоногт багтаан татварыг төлөх шаардлага;
- 7/ татвар төлөх газар, хэлбэр;
- 8/ татварын ногдлыг тоолсон үндэстэл;
- 9/ татварын албанаас зайлшгүй гэж үзсэн бусад шаардлага.

2. Татварын ногдлыг төлөхгүйд хүрч байхынхгүй тохиолдолд Татварын албаны дарга энэ зүйлийн 1 дэх хэсгийн 6-д зааснаас Согноно хугацаанд татварыг төлүүдэхээр шийлэж болно.

19 дүгээр зүйл. Татварын өрийг барагдуулах дараалал

1. Хууль тогтоомжоор тогтоосон хугацаанд төлөөгүй татвар, хүү, торгуулийн өрийг дараахь дарааллаар барагдуулна:

- 1/ тухайн татварт ногдох хүү;
- 2/ торгууль;
- 3/ татварын үндсэн өр.

2. Дараахь тохиолдолд татварын төлбөрийн дарааллыг Татварын алба тусгайлан тогтооно:

- 1/ хэрэв татвар төлөгч тухайн төлбөрийг аль хугацааны ямар атварт хамраахыг заагаагүй ;
- 2/ эл хөрөнгө хураах замлар татварыг төлүүлж байгаа.

20 дугаар зүйл. Татвар төлөх хугацааг сунгах

1. Бодит шалтгааны улмаас татвар төлөх төлбөрийн чадваргүй олж татвар төлөх хугацааг сунгуулах тухай татвар төлөгч бичгээр үсэлт гэрэгж, сунгасан хугацаанд татвараа бүрэн төлөхөө нотолсон охиолдолд Татварын албаны даргын тушаалаар татвар төлөх хугацааг 60 хүртэл хоногоор нэг удаа сунгаж болно.

2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу татвар төлөх хугацааг сунгахаар бол хожимдуулсан татварыг төлөх хумаарь, хөрөнгийн эх үүсвэрийн тооцоо, үйл ажиллагааны төлөвлөгөөг татвар төлөгчөөс гаргуулан авна.

3. Татвар төлөх хугацааг сунгасан тохиолдолд хугацаа сунгасныг үл харгалзан хуульд заасан хугацаа хэтэрсний хүү ногдуулна.

21 дүгээр зүйл. Татварыг суутган тооцох, эгүүлэн олгох

1. Татварын ерөнхий хуулийн 12 дугаар зүйлийн 5-д заасан татвар төлөгчийн эрхийг хэрэгжүүлэхийн тулд Татварын алба татвар төлөгчийн илүү төлсөн татварыг дараахь журмаар шийдвэрлэнэ:

1/ төлбөл зохих бусад татварт суутган тооцох;

2/ татвар төлөгч ээлдөөрөөл дараагийн хугацаанд төлөх татварт суутган тооцох;

3/ эгүүлэн олгох.

2. Илүү төлсөн татварыг суутган тооцох бол энэ тухай Татварын алба татвар төлөгчид мэдэгдэнэ.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Татвар хураах

22 дугаар зүйл. Төлөөгүй татварыг хураах

1. Татвар төлөгч татвар, хүү, торгууль /цагшид "татварын галбэр" гэх/-ийг хууль тогтоомжилд заасан хугацаанд төлөөгүй бол Татварын алба түүнийг төлүүлэх татвар дараахь ажиллагаа явуулна:

1/ үл маргах журмаар төлүүлэх;

2/ эд хөрөнгө, цалин хөлс, бусад орлогоос гаргуулах;

3/ шүүхэд нэхэмжлэл гаргах.

2. Татвар төлөгчийн төлөх ёстой татварын галбэрийг бүрэн гаргуулах зорилгоор энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан үйл ажиллагааг давхар явуулж болно.

23 дугаар зүйл. Татварын галбэрийг үл маргах журмаар төлүүлэх

1. Татварын галбэрийг энэ хуулийн 18 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 6 дахь заалт болон 2 дахь хэсэг, 20 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан хугацаанд төлөөгүй тохиолдолд татвар төлөгчийн харилцагч банкин дахь дансанд байгаа мөнгөн хөрөнгөнөөс татварын галбэрийг үл маргах журмаар гаргуулна. Хэрэв татвар төлөгчийн харилцагч банканд байгаа дансан дахь мөнгөн хөрөнгө нь татварын галбэрийг төлөхөд хуралцэхгүй байвал уг дансаас төлөх шүүхийн шийдвэртэйгээс бусад зарлагын гүйлгээг бүрэн буюу хэсэгчлэн зогсоож дансны орлогоос галбэрийг гаргуулан авна.

2. Татварын төлбөрийг үл маргах журмаар гаргуулах тухай татварын байцаагчийн мэдэгдэх хуудсыг тухайн Татварын албаны дарга багатж, банкны байгууллагад өгнө. Мэдэгдэх хуудсанд татварын төлбөр гаргуулах үндэслэл, түүний хэмжээ, зарлагын гүйлтгээг бүрэн буюу хэсэгчлэн зогсоох хугацааны тухай заасан байна.

24 дүгээр зүйл. Татварын төлбөрийг татвар төлөгчийн эд хөрөнгө, цалин хөлс, бусад орлогоос гаргуулах

1. Татаар төлөгч энэ хуулийн 18 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 6 дахь заалт, 2 дахь хэсэг болон 20 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан хугацаанд татвараа төлөөгүй, энэ хуулийн 23 дугаар зүйлд заасны дагуу татварын төлбөрийг үл маргалдах журмаар талүүлэх боломжгүй гохиолдолд Татварын алба татаар төлөгчтэй тохиролцож эд хөрөнгө, цалин хөлс, бусад орлогоос татварын төлбөрийг гаргуулна.

2. Татварын төлбөрийг эд хөрөнгө, цалин хөлс, бусад орлогоос төлөх тухай татвар төлөгчийн бичгээр өгсөн зөвшөөрлийн үндсэн дээр Татварын алба холбогдох шийдвэр гаргана.

25 дугаар зүйл. Татвар төлөгчийн цалин хөлс, бусад орлогоос татварын төлбөр гаргуулах

Энэ хуулийн 24 дүгээр зүйлд заасны дагуу татвар төлөгчийн цалин хөлс, бусад орлогоос татварын төлбөр гаргуулахдаа дараахь сурмыг баримтална:

1/ цалин хөлс, бусад орлогоос татварын төлбөрт суутгал нийлгүүлэхээр татвар төлөгчид орлого олгож байгаа буюу түүний жилдаж байгаа үндсэн аж ахуйн нэгж, байгууллагад төлбөрийн уудас хургүүлнэ;

2/ аж ахуйн нэгж, байгууллага төлбөрийн хуудсыг хүтээн ямагц татвар төлөгчийн орлогоос зохих суутгалыг сэр тутам хийж уутгал хийснээс хойш 3 хоногийн дотор уг мөнгийг төлбөрийн уудсанд заасан дансанд шилжүүлнэ;

3/ татварын төлбөрийг шүүхийн шийдвэрийн дагуу цалин, орлогоос нь суутгал хийж байгаагаас бусад төлбөрийн өмнө уутгана;

4/ татвар төлөгч ажлаас халагдавал аж ахуйн нэгж, байгууллага нь түүний халагдсан өдрөөс хойш 7 хоногийн дотор татварын төлбөрт суутгасан мөнгөний хэмжээ, халин шилжсэнийг тэмдэглэж төлбөрийн хуудсыг Татварын албанд буцаана.

26 дугаар зүйл. Татвар төлөгчийн эд хөрөнгөөс татварын төлбөр гаргуулах

1. Энэ хуулийн 24 дүгээр зүйлд заасны дагуу татвар төлөгчийн эд хөрөнгөөс татварын төлбөр гаргуулахдаа Татварын албаны даргын шийдвэрээр комисс томилно.

2. Эд хөрөнгөөс татварын төлбөр гаргуулах комисс дараахь үйл ажиллагаа явуулна:

1/ татварын төлбөрт өгөх эд хөрөнгийн чанар, хэрэгцээ, элэгдсэн байдал, татвар төлөгчийн санал, орон нутгийн тухайн үеийн ханшигт харгалзан дуудлагын худалдаанд оруулах анхны үнийг тогтоож тэмдэглэл үйлдэнэ. Хөрөнгийн бүртгэлийг тэмдэглэлд хавсаргана;

2/ татварын төлбөрт өгсөн эд хөрөнгийг дуудлагын худалдаагаар худалдана. Татвар төлөгч хүсвэл түүнийг буюу түүний хууль ёсны төлөөлөгчийг дуудлагын худалдаанд байшуулна;

3/ дуудлагын худалдаагаар борлогдоогүй эд хөрөнгийг татвар төлөгчид буцаан олгоно;

4/ дуудлагын худалдаагаар борлуулсан эд хөрөнгийн үнэ нь татварын төлбөр, дуудлагын худалдааны зарлаас давбал энэ хуулийн 21 дүгээр зүйлд заасны дагуу шийдвэрлэж, тэмдэглэл үйлдэнэ;

5/ дуудлагын худалдаагаар борлуулсан эд хөрөнгийн үнэ нь татварын төлбөрт хүрэлцэхгүй бол татаар төлөгч уг төлбөрийн үлдсэн хэсгийг барагдуулах үүргээс чөлөөлөгдөхгүй.

3. Эд хөрөнгийн дуудлагын худалдаанд оруулах анхны үнийг тогтооход мэргэжлийн байгууллага, хүмүүсийн туслалцаа авч болно.

27 дугаар зүйл. Татварын төлбөрийг гаргуулах тухай шүүхэд нэхэмжлэл гаргах

1. Энэ хуулийн 18 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 6 дахь заалт, 2 дахь хэсэг болон 20 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан хугацаанд татварын төлбөрийг татвар төлөгч төлөөгүй, уг төлбөрийг энэ хуулийн 24, 25 дугаар зүйлд заасан журмын дагуу барагдуулах боломжгүй тохиолдолд Татварын алба татварын төлбөр гаргуулах тухай нэхэмжлэлийг шүүхэд гаргана.

Шүүх нэхэмжлэлийг хүлээн авч зохих хуулийн дагуу шийдвэрлэнэ.

2. Хэрэв татвар төлөгч татвараа төлөхөөс санаатайгаар зайлсхийсэн, энэ хуулийн 24 дүгээр зүйлд заасны дагуу тохиролцсон боловч татварын төлбөрт эд хөрөнгө гаргах ажиллагааг хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр саатуулсан, татгалзсан бол Татварын алба татварын хэрэг бүртгэх ажиллагаа явуулж, хэргийг зохих журмын дагуу шийдвэрлүүнэ.

ТАВДУГААР БҮЛЭГ

Татварын байцаагчийн тусгай хэрэгсэл

28 дугаар зүйл. Нэг бүрийн тусгай хэрэгсэл

1. Татварын байцаагч албан үүргээ гүйцэтгэж байх үедээ алиа довтолгоо, халдлагаас биеэ хамгаалах зориулалтаар нэг хүнд нөлөөлөх цахилгаан бороохой, нулимс аспирүүлэгч болон амьсгал боогдуулагчаар цэнэглэсэн буу /цаашид "нэг бүрийн тусгай хэрэгсэл" гэх/ хэрэглэж болно.

2. Нэг бүрийн тусгай хэрэгсэл хэрэглэх зааврыг Улсын ерөнхий прокурортой зөвшилцөн Улсын татварын албаны удирдах төв байгууллагын дарга батална.

29 дүгээр зүйл. Нэг бүрийн тусгай хэрэгслийг хэрэглэх үндэслэл

1. Албан үүргээ гүйцэтгэхтэй нь холбогдуулан хүч хэрэглэхээр завдсан, довтолсон, хүч хэрэглэсэн тохиолдолд татварын байцаагч өөрийн эрүүл мэнд, амь нас хохирч болох үйдлээс сэргийлэх, таслан зогсоох зорилгоор нэг бүрийн тусгай хэрэгслийг хэрэглэнэ.

2. Татварын байцаагч нэг бүрийн тусгай хэрэгслийг буруу буюу үндэслэлгүй хэрэглэсэн гэж татвар төлөгч үзвэл энэ тухай гомдлоо Татварын албаны удирдлага буюу шүүхэд гаргах эрхтэй.

30 дугаар зүйл. Нэг бүрийн тусгай хэрэгсэл хэрэглэхийг хориглох тохиолдлууд

Хүүхэд болон жирэмсэн болох нь илг мэдэгдэж байгаа хүмүүст дор дурдсанаас бусад тохиолдолд нэг бүрийн тусгай хэрэгсэл хэрэглэхийг хориглоно:

1/ галт буюу хүйтэн зэвсэг, зэвсгийн чанартай зүйл хэрэглэсэн;

2/ амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулж болзошгүй байдлаар довтолсон;

3/ бүлэглэн довтолсон хүмүүсийг дотор нь ялгах боломжгүй байсан.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ

Бусад этгээдийн үүрэг

31 дүгээр зүйл. Татварын үйл ажиллагааны талаар банкны хүлээх үүрэг

Банк, санхүүгийн бусад байгууллага татварын үйл ажиллагаатай холбогдох асуудлаар дараахь үүрэг хүлээнэ:

1/ татвар төлөгчийн тооцооны болон бусад данс /цаашид "данс" гэх/-ыг Мөнгөн халгаламж, төлбөр тооцоо, банкны зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн 12 дугаар зүйлд заасан журмын дагуу нээсэн тухайгаа ажлын 10 хоногийн дотор Татварын албанд мэдэгдэх;

2/ дансан дахь мөнгөн хөрөнгөөсөө татварын төлбөр хийх тухай татвар төлөгчийн болон, үл маргалдах журмаар татвар, хүү, торгууль төлүүлэх тухай Татварын албаны шийдвэрийг хуульд заасны дагуу эхний ээлжинд шилжүүлэх ёстой төлбөрөөс бусад тохиолдолд банк, санхүүгийн байгууллага, түүнчлэн бусад эзэлдэгч, нэхэмжлэгчид төлөх төлбөрөөс өмнө биелүүлэх.

Энд заасны дагуу татварын төлбөрийг гүйцэтгэхэд Мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, банкны зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 2 дахь хэсэг хамаарахгүй;

3/ Татварын ерөнхий хуулийн 24 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалтад заасны дагуу тогтоосон хугацаанд татвар төлөөгүй аж ахуйн нэгж, байгууллагын банкин дахь харилцах дансны зарлагын гүйлгээг татвараа төлж дуустал түр зогсоох тухай Татварын албаны шийдвэрийг хэрэгжүүлэх.

32 дугаар зүйл. Цагдаагийн байгууллагын үүрэг

1. Татварын алба байцаагчаас татвар төлөгчийн байр, агуулахад нэвтрэн орох болон шалгалт, тооллого, үзлэг явуулах үйл ажиллагааг хүч хэрэглэх буюу зохион байгуулалттайгаар саатуулсан, эсэргүүцсэн тохиолдолд цагдаагийн байгууллага шаардлагатай туслалцаа үзүүлж, уг үйл ажиллагааг явуулах бололцоог хангана.

2. Цагдаагийн байгууллага нь Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүмүүсийг татвар төлөгчөөр бүртгэх, хаягийг нь тодруулахтай холбогдсон хувь хүний нууцад үл хамаарах өөрт байгаа мэдээ, судалгааг Татварын албаны хүсэлтээр гаргаж өгнө.

33 дугаар зүйл. Бусад этгээдийн үүрэг

1. Хэрэг бүртгэх, мөрдлөн байцаах болон төрийн байгууллага, албан тушаалтан үйл ажиллагааныхаа явцад илрүүлсэн татварын хууль тогтоомжийг зөрчсөн тухай мэдээллийг Татварын албанд шилжүүлж өгөх үүрэгтэй.

2. Гаалийн байгууллага нь гаалийн мэдүүдэлт татвар төлөгчийн бүртгэлийн дугаарыг тусгаж байгаа эсэхийг ямааж, татвар төлөгчийн экспорт, импортын үйл ажиллагаатай холбогдсон мэдээллийг Татварын албаны хүсэлтээр гарган өгч байна.

ДОЛДУГААР БҮЛЭГ

Бусад зүйл

34 дүгээр зүйл. Хүү, торгууль ногдуулах, төлүүлэх журам

1. Татварыг хугацаанд нь төлөөгүй тохиолдолд татвар төлөхөөр хуульд заасан өдрөөс татвар төлсөн өдрийг хүртэлх хугацаанд хүү ногдуулна.

2. Татварын албаны буруутгаар илүү төлөгдсөн татварыг буцаан олгох бол татварыг төсөвт төлсөн өдрөөс эгүүлэн олгосон өдрийг хүртэлх хугацаанд буцаасан татварын дүнгээс бодож өдөр тутам 0,3 хувийн хүү төлнө. Энэ хүүг төсвөөс гаргана.

35 дугаар зүйл. Гомдлыг захиргааны журмаар шийдвэрлэх

1. Татварын үйл ажиллагаатай холбоотой татвар төлөгчийн гомдлыг захиргааны журмаар шийдвэрлэхэд энэ хууль болон татварын хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийг дагаж мөрднө.

2. Татварын үйл ажиллагаатай холбоотой татварын байцаагчийн шийдвэрийн талаархи татвар төлөгчийн гомдлыг дараахь журмаар хүлээн авч шийдвэрлэнэ:

1/ татварын байцаагчийн шийдвэртэй холбоотой гомдлыг тухайн байцаагчийн ажилладаг буюу шууд харьцдаг Татварын албанд;

2/ татварын албаны шийдвэрийн талаархи гомдлыг түүний дээд шатны Татварын албанд;

3/ татвар төлөгч шаардлагатай гэж үзвэл гомдлоо Татварын дээд шатны аль ч албанд;

4/ доод шатны Татварын албанаас татварын үйл ажиллагаатай холбоотой гаргасан шийдвэрийн талаархи гомдлыг Татварын албаны удирдах дээд байгууллагын эрх олгосон ажилтан хүлээн авч шийдвэрлэнэ. Энэ нь гомдлыг захиргааны журмаар шийдвэрлэх эцсийн шийдвэр болно.

36 дугаар зүйл. Шүүхэд гомдол гаргах

Татвар төлөгч Татварын албанаас гаргасан аливаа шийдвэрийн талаархи гомдлоо шүүхэд гаргах эрхтэй.

37 дугаар зүйл. Хүлээлгэх хариуцлага

1. Татвар ногдуулалт, төлөлтөд хяналт тавих, татвар хураах тухай хууль зөрчсөн дараахь иргэн, албан тушаалтанд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол татварын байцаагч дор дурдсан захиргааны шийтгэл ногдуулна:

1/ энэ хуулийн 5 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэгт заасны дагуу тогтоосон хугацаанд Татварын албанд бүртгүүлээгүй иргэнийг 3000-5000, албан тушаалтныг 60000-150000 төгрөгөөр торгох;

2/ энэ хуулийн 9 дүгээр зүйлийн 1, 6; 25 дугаар зүйлийн 4; 31 дүгээр зүйлийн 1 дэх заалт, 32 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 33 дугаар зүйлд заасан татварын тайлан. Татварын албанд гаргаж өгөх бусад мэдээ баримтыг хугацаанд нь гаргаж өгөөгүй холбогдох албан тушаалтан, иргэнийг 1000-20000 төгрөгөөр торгох;

3/ энэ хуулийн 3 дугаар зүйлийн 5; 5 дугаар зүйлийн 5, 6, 7

дахь хэсэг, 25 дугаар зүйлийн 2; 31 дүгээр зүйлийн 2, 3 дахь заалтад заасныг зөрчсөн албан тушаалтныг 30000-150000 төгрөгөөр торгох;

4/ татварын хяналт шалгалтад саад учруулсан аливаа иргэн, албан тушаалтныг 10000-150000 төгрөгөөр торгох.

Татварын хяналт шалгалтад саад учруулсан гэдэг ойлголтгод дараахь үйлдлийг хамруулна:

а/ татварын алба байцаагчаас өгсөн мэдэгдэл, акт, мэдэгдэх болон гөлбөрийн хуудас, шаардлагыг хугацаанд нь биелүүлээгүй;

б/ Татварын алба, байцаагчаас шаардсан өөрт байгаа мэдээ, баримтыг гаргаж өгөөгүй;

в/ татварын байцаагч эрх олгогдсон албан тушаалтныг байр, агуулахад нэвтрэн ороход саад учруулсан;

г/ татварын байцаагч, эрх олгогдсон албан тушаалтнаас баримт, бүртгэлд шалгалт хийх, эд хөрөнгө, мөнгө тоолох, ажлын зураг авалт, үзлэг хийхэд саад учруулсан;

д/ эрх бүхий албан тушаалтнаас Татварын алба байцаагчид албан үүргээ биелүүлэхэд нь дарамт, шахалт үзүүлсэн;

5/ энэ хуулийн 8 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан журмыг зөрчсөн албан тушаалтан, иргэнийг 50000-100000 төгрөгөөр торгох.

38 дугаар зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

Энэ хуулийг 1996 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Монгол Улсын Их Хурлын дарга

Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1996 оны 4 дүгээр
сарын 26-ны өдөр

Улаанбаатар
хот

УЛС ТӨРИЙН НАМУУДЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Улс төрийн намуудын тухай хуульд дор дурдсан агуулгатай гуравдугаар бүлэг, 8, 9 дүгээр зүйл, мөн хуулийн "Намын санхүү, хөрөнгийн тухай" гэсэн бүлэгт 12 дугаар зүйлийг тус тус нэмсүгэй.

"Гуравдугаар бүлэг. Парламентын намын тухай

8 дугаар зүйл. Нам Улсын Их Хурлын гишүүнд, парламентад суудалтай нам Ерөнхийлөгчид өөрийн гишүүд, дэмжигчдээсээ нэр дэвшүүлэх эрхтэй. Тухайн нам өөр намын гишүүнийг Улсын Их Хурлын гишүүн, Ерөнхийлөгчид нэр дэвшүүлэхийг хориглоно.

9 дүгээр зүйл. Улсын Их Хурлын гишүүн намыг төлөөлөх боломжгүй гэж үзвэл Улсын Их Хурлын гишүүнээс түүнийг эгүүлэн татах тухай саналаа тухайн нам Улсын Их Хурал дахь өөрийн намын бүлэг болон хууль санаачлах эрх бүхий этгээдээр уламжлан Улсын Их Хуралд тавих эрхтэй."

"12 дугаар зүйл. Улсын Их Хуралд суудал бүхий намд авсан суудлын тоог баримтлан Улсын Их Хурлын гишүүний нэг суудлыг жилд нэг сая төгрөгөөр тооцож Улсын Их Хурлын тухайн бүрэн эрхийн хугацаанд улирал тутам санхүүжилт олгоно. Энэхүү хэмжээг мөнгөний ханшийн өөрчлөлтийг харгалзан өөрлөн тогтоож байна."

2 дугаар зүйл. Улс төрийн намуудын тухай хуулийн "Гуравдугаар бүлэг" гэснийг "Дөрөвдүгээр бүлэг", "8, 9 дүгээр зүйл" гэснийг "10, 11 дүгээр зүйл", "Дөрөвдүгээр бүлэг" гэснийг "Таадугаар бүлэг", "10, 11, 12 дугаар зүйл" гэснийг "13, 14, 15 дугаар зүйл" гэж тус тус өөрчилсүгэй.

3 дугаар зүйл. Энэ хуулийг буцаан хэрэглэхгүй.

Монгол Улсын Их Хурлын дарга

Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1996 оны 4 дүгээр
сарын 30-ны өдөр

Улаанбаатар
хот

ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын нутаг дэвсгэр дээр замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахтай холбогдсон хэрмэцээг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Хуулийн нэр томъёо

Энэ хуульд заасан дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

1/ "зам" гэдэгт-гээврийн хэрэгслээр зорчиход зориулсан зурвас газрыг, Цардмал замын хоёр талын шороон зурвас, ялган хүний зам, тусгаарлах зурвас замд хамаарна;

2/ "замын хөдөлгөөн" гэдэгт-нийтийн хэрэгцээний зам ашиглан ачаа ба зорчигчдыг тээврийн хэрэгслээр шилжүүлэн зөөх, явганаар болон дугуй, ердийн хөсгөөр зорчих үйл ажиллагааг.

Үйлдвэрийн байран дотор болон нийтийн хэрэгцээний бус замд тогтоосон маршрутын дагуу тээвэр хийж байгаа авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн хөдөлгөөнийг замын хөдөлгөөнд тооцохгүй;

3/ "тээврийн хэрэгсэл" гэдэгт-хүн, ачаа тээвэрлэхэд зориулсан бүх төрлийн автомашин, чиргүүд, мотоцикл, цахилгаан тээврийн хэрэгсэл, түүнчлэн трактор, өөрөө явагч бусад хэрэгслийг;

4/ "тээврийн хэрэгслийн жолооч" гэдэгт-тээврийн хэрэгслийг жолоодож яваа үндэсний буюу олон улсын жолоодох эрхийн үнэмлэхтэй хүнийг;

5/ "явган зорчигч" гэдэгт-явганаар яваа, хүүхдийн тэрэг түрсэн, чарга чирсэн, мөн жагсаалаар яваа хүмүүс, тахир дутуу хүний дугуй /тэргэнцэр/-тай болон унадаг дугуй, мопед, мотоциклийг хөтөлж, замаар яваа хүнийг.

Зам засах, нэвэрлэх зэргээр зам дээр ажиллагчид явган зорчигчид хамаарахгүй;

6/ "тээврийн хэрэгслээр зорчигч" гэдэгт-тээврийн хэрэгслийн бүхээг дотор, эсхүл тэвшин дээр сууж яваа хүнийг;

7/ "замын хөдөлгөөнд оролцогчид" гэдэгт-замын хөдөлгөөнд явганаар болон дугуй, ердийн хөсгөөр оролцож яваа, тээврийн хэрэгсэл жолоодож буюу тээврийн хэрэгслээр зорчиж яваа хүмүүсийг;

8/ "Замын хөдөлгөөнийг аюулгүй байдлыг хангах" гэдэгт-зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх, ослоос унтрч болох хохирлыг багасгахад чиглэгдсэн үйл ажиллагааг.

3 дугаар зүйл. Хөдөлгөөний чиглэл

Монгол Улсад тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг замын зорчих хэсгийн баруун гар талаар явуулна.

4 дүгээр зүйл. Замын хөдөлгөөний дүрэм

1. Замын хөдөлгөөний дүрмийг Засгийн газар батална.

2. Замын хөдөлгөөний дүрэмд тээврийн хэрэгслийг жолоодох эрхийн ангилал, тухайн ангилал эзэмших насны хязгаар, замын хөдөлгөөнд оролцогчдын үүрэг, гудамж, замаар зорчих хөдөлгөөний журам, замын хөдөлгөөн зохицуулах дохио, тэмдэг, тэмдэглэлийн загвар, тодорхойлолт, тээврийн хэрэгсэлд техникийн талаар тавих шаардлага, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах талаар иргэд, байгууллага, аж ахуйн нэгжийн хүлээх үүргийг тусгана.

3. Замын хөдөлгөөний дүрмийг Монгол Улсын нутаг дэвсгэр дээр бүх нийтээр дагаж мөрдөнө.

5 дугаар зүйл. Тээврийн хэрэгслийн жолооч бэлтгэх

1. Эрүүл мэндийн хувьд тогтоосон шаардлагад тэнцэх, мэргэжлийн зохих бэлтгэл, сургалт хийсэн, 18 нас хүрсэн хүн тээврийн хэрэгсэл жолоодох эрх авч болно.

2. Тээврийн хэрэгсэл жолоодох эрх авах мэргэжлийн шалгалтад орж тэнцсэн хүнд зохих ангиллын үнэмлэх олгоно.

3. Тээврийн хэрэгслийн жолооч бэлтгэх журмыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны болон цагдаагийн төв байгууллага, жолоочийн сургалтын хөтөлбөрийг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, жолоочийн мэргэжлийн шалгалт авах, үнэмлэх олгох журам, үнэмлэхийн загварыг цагдаагийн төв байгууллага тус тус батална.

6 дугаар зүйл. Тээврийн хэрэгслийн улсын бүртгэл

1. Монгол Улсад оршиж буй аж ахуйн нэгж, байгууллага, хүмүүс тээврийн хэрэгсэл өмчилж авснаас хойш 72 цагийн дотор, ашигдалтаас хассанаас хойш нэг сарын дотор бүртгүүлднэ.

2. Тээврийн хэрэгслийн тооллого явуулах, бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох журмыг цагдаагийн төв байгууллага тогтооно.

7 дугаар зүйл. Тээврийн хэрэгслийн тооллого, техникийн улсын үзлэг

1. Монгол Улсын нутаг дэвсгэрт ашиглагдаж байгаа тээврийн хэрэгслийн тооллого, техникийн үзлэгийг тогтоосон хугацаанд хийнэ.

2. Тээврийн хэрэгслийн техникийн улсын үзлэг, тооллого явуулах журмыг тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны болон цагдаагийн төв байгууллага хамтарч тогтооно.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах

8 дугаар зүйл. Авто зам, гүүр, түүний хиймэл байгууламжийг төлөвлөх, шинээр барих, өргөтгөх, засварлах, ашиглахад замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах

1. Авто зам, гүүр, түүний хиймэл байгууламжийг төлөвлөх, шинээр барих, өргөтгөх, засварлахад замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахтай холбогдсон улсын стандартыг стандартчиллын төв байгууллага тогтооно.

2. Авто зам, гүүр, түүний хиймэл байгууламжийг төлөвлөх, шинээр барих, өргөтгөх, засварлах ажлыг Монгол Улсад мөрдөж буй замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахтай холбогдсон техникийн дүрэм, стандартын шаардлагад нийцүүлж гүйцэтгэнэ.

3. Авто зам, гүүр, түүний хиймэл байгууламжийг холбогдох стандарт, хөдөлгөөний аюулгүй байдлын шаардлагын дагуу тоноглож, гэрэлтүүлэг тэмдэг, техник хэрэгсэл тавьсан байна.

4. Монгол Улсын авто замын тэмдэг, тэмдэглэлийн улсын стандартыг стандартчиллын төв байгууллага батална.

5. Замын байгууламж, зорчих хэсгийн гадаргуу, замын гэрэлтүүлэг, хөдөлгөөн зохицуулах техник хэрэгслийг бүрэн бүтэн байлгаж, эвдэрч гэмтсэн, хэвийн байдал нь алдагдсан тухай бүр тэдгээрийг засаж сэлбэх үүргийг тухайн орон нутгийн хот тохижилт, зам ашиглалтын байгууллага эрхлэн гүйцэтгэнэ.

6. Гал команд, түргэн тусламж, эмнэлэг, авто аж ахуйгаас цэцэрлэг, сургууль, үзэврийн газар, орон сууцны хороолол тал руу автомашины шууд гарц гаргахыг хориглоно.

9 дүгээр зүйл. Тээврийн хэрэгсэл, түүний эд анги, сэлбэг хэрэгсэл үйлдвэрлэхэд замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах

1. Монгол Улсад үйлдвэрлэх, угсрах тээврийн хэрэгсэл, түүний эд анги, сэлбэг хэрэгсэл, нэмэлт төхөөрөмж нь замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахад баримтлах стандартын шаардлагыг хангасан байна.

2. Монгол Улсад шинээр үйлдвэрлэх тээврийн хэрэгслийн улсын стандартыг стандартчиллын төв байгууллага тогтооно.

10 дугаар зүйл. Тээврийн хэрэгслийг ашиглахад замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах

1. Улсын стандартын шаардлагыг хангасан үзүүлэлт бүхий тээврийн хэрэгслийг Монгол Улсад ашиглахыг зөвшөөрнө.

2. Тээврийн хэрэгслийн марк, зориулалтыг холбогдох байгууллагын зөвшөөрөлгүйгээр өөрчлөхийг хориглоно.

3. Замын хөдөлгөөнд оролцох тээврийн хэрэгслийг техникийн хувьд бүрэн бүтэн байлгах үүргийг тухайн тээврийн хэрэгслийг өмчлөгч буюу эзэмшигч, эсхүл хууль тогтоомжийн дагуу түүнийг ашиглаж байгаа этгээд хариуцна.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Замын хөдөлгөөнд оролцогчид, иргэн,
аж ахуйн нэгж, байгууллагын үүрэг

11 дүгээр зүйл. Тээврийн хэрэгслийн жолоочийн
нийтлэг үүрэг

Тээврийн хэрэгслийн жолооч дараахь үүрэг хүлээнэ:

1/ зөвхөн жолоодох эрхийн үнэмлэхэд зөвшөөрөгдсөн ангиллын тээврийн хэрэгслийг жолоодох;

2/ тээврийн хэрэгсэл жолоодож явах үедээ жолоодох эрхийн үнэмлэх, тээврийн хэрэгслийн гэрчилгээг биедээ авч явах;

3/ хөдөлгөөнд оролцоходоо замын хөдөлгөөний дүрмийн заалт, шаардлагыг чанд сахин биелүүлж, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж явах;

4/ хөдөлгөөнд аюул учруулж болзошгүй саяд замд тохиолдсон үед түүнийг арилгах, өөрөө арилгах бололцоогүй бол холбогдох байгууллагад нэн даруй мэдэгдэх;

5/ цагдаагийн алба хаагчийн дохиогоор зогсож жолоодох эрхийн үнэмлэх, тээврийн хэрэгслийн гэрчилгээг шалгуулах.

Жолооч нь захиргааны хяналтын улсын байцаагчийн шаардлагаар холбогдох баримт бичгийг шалгуулна;

6/ зам, тээврийн осол гарсан үед осолд нэрвэгдсэн хүнд тусламж үзүүлэх арга хэмжээ авч цагдаагийн байгууллагад нэн даруй мэдэгдэх;

7/ замын хөдөлгөөн бүрэн хаагдсан, осолд нэрвэгдсэн хүнд яаралтай тусламж үзүүлэх зайлшгүй шаардлагатайгаас бусад тохиолдолд осол хэргийн газраас тээврийн хэрэгслийг хөдөлгөхгүй байх.

12 дугаар зүйл. Тээврийн хэрэгслийн жолоочид хориглох зүйл

Тээврийн хэрэгслийн жолоочид дараахь зүйлийг хориглоно:

1/ согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэсэн болон хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж чадахааргүй өвчтэй болон ядарсан үедээ тээврийн хэрэгсэл жолоодох;

2/ тээврийн хэрэгслээ гарааш, хоноглох зогсоолд тавиагүй бол замын хөдөлгөөнд оролцохыг түр завсарлах үедээ ч согтууруулах ундаа хэрэглэх;

3/ стандартын шаардлага хангаагүй, хөдөлгөөнд аюул учруулж болзошгүй бүрэн бус, эсхүл тогтоосон журмын дагуу улсын бүртгэл, гооллого, техникийн үлэгт ороогүй, улсын дугааргүй тээврийн зэрэгслээр хөдөлгөөнд оролцох;

4/ тээврийн хэрэгсэл жолоодох эрхгүй буюу эрхтэй боловч согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэсэн хүнд тээврийн зэрэгслээ шилжүүлэн жолоодуулах;

5/ тээврийн хэрэгслээр замын хашлага давах, батлагдсан замаас гарч шинэ зам гаргах, газрын хөрс, хадлан тариалангийн албай, ой модыг гэмтгэх, гол мөрөн, нуур, булгийн усанд тээврийн зэрэгслээ угаах, бохирдуулах;

6/ тээврийн хэрэгслийн хурдыг тогтоосон хэмжээнээс хэтрүүлэх буюу шалтгаангүйгээр хэт удаан явах, эсхүл option зогсох зэргээр хөдөлгөөн саатуулах;

7/ тээврийн хэрэгсэлд тусгай дуут болон гэрэл дохио дур мэдэн тавих.

Тээврийн хэрэгсэлд тусгай дуут болон гэрэл дохио хэрэглэх журмыг цагдаагийн төв байгууллагын дарга батална;

8/ энэ хууль болон замын хөдөлгөөний дүрмийг зөрчих.

13 дугаар зүйл. Янганаар болон дугуй, ердийн хөсөг, тээврийн хэрэгслээр зорчигчдын нийтлэг үүрэг

1. Янганаар болон дугуй, ердийн хөсөг, тээврийн хэрэгслээр зорчигчид нь замын хөдөлгөөний дүрмийг биелүүлж, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үүрэгтэй.

2. Янганаар болон дугуй, ердийн хөсөг, тээврийн хэрэгслээр зорчигчид дор дурдсан зүйлийг хориглоно:

1/ замын хөдөлгөөнд саад хийх;

2/ согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэж өөрийн үйлдлийг хянаж жолоодох чадвараа мэдэгдэхүйц алдсан үед хөдөлгөөнд оролцох;

3/ ойртон ирж яваа тээврийн хэрэгслийн урдуур гүйх, зам дээр тоглох, гаршгүй газраар явах, бага насны хүүхдийг харгалзах хүнгүйгээр хөдөлгөөнд оролцуулах, тээврийн хэрэгслээс зүтгэх;

4/ тээврийн хэрэгслийн хүн суухад зориулагддаггүй хөсөг, тэвшнээс дээш гарсан ачаан дээр суух, тэвшин дээр зогсох, хаалга халх нээхэд саад хийх, бүрэн зогсоогүй байхад хаалга онгойлгох, буух;

5/ замын хөдөлгөөний дүрмийг зөрчих.

14 дүгээр зүйл. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын үүрэг

Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах талаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллага дарсаах үүргийг хүлээнэ:

1/ техникийн шаардлага хангаагүй, хөдөлгөөнд аюул учруулахаар бүрэн бус, тогтоосон журмын дагуу улсын бүртгэл, техникийн үзлэг тооллогод ороогүй, улсын дутааргүй тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд оролцуулахгүй байх;

2/ согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэсэн, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж чадахааргүй өнгөтэй буюу ядарсан тээврийн хэрэгсэл жолоодох эрхийн ангилал нь тохирохгүй, эсхүр жолоодох эрхийн үнэмлэхгүй хүнээр тээврийн хэрэгсэл жолоодуулахгүй байх;

3/ тээврийн хэрэгсэл эзэмшингч аж ахуйн нэгж, байгууллагын нэр, хаяг, эзэмшингч буй тээврийн хэрэгслийн марк, хөдөлгүүрийн

Болон арлын дугаар өөрчлөгдөх бүрд замын хөдөлгөөний аюулгүй байдлын улсын албанд ийнхүү өөрчлөгдсөнөөс хойш долоо хоногийн дотор бүртгүүлэх;

4/ аж ахуйн нэгж, байгууллага нь замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахтай холбогдсон хууль тогтоомжийг ажиллагсад болон суралцагсад судлуулж, ослоос урьдчилан сэргийлэх ажил зохиож байх;

5/ замын хөдөлгөөнтэй холбоотой аливаа үйл ажиллагаа явуулахдаа зам, тээврийн осол гаргах, замын хөдөлгөөний дүрэм зөрчигдөх нөхцөл бүрдүүлэхгүй байх арга хэмжээ авах;

6/ хотын доторхи болон хот хоорондын гол замын зорчих сэгсэгт мал, тэжээвэр амьтдыг хариулаагүйгээр оруулахгүй байх;

7/ иргэний амьдарч байгаа болон аж ахуйн нэгж, байгууллагын оршин байгаа газарт хамаарах замын гадаргуут бүрэн бүтэн байлгах талаар зохих байгууллагад шаардлага тавих, хөдөлгөөнд цоул учруулж болзошгүйгээр зам элдэрсэн, мөстсөн зэргийг нэн даруй засаж, цэвэрлүүлэх;

8/ зам, тээврийн осолд нэрвэгдсэн хүнд тусламж үзүүлэх;

9/ зам дээр засвар, үйлчилгээ хийж байгаа бол уг хэсгийг ашиж тусгаарлах, тойрч гарах чигийг заах;

10/ замын хөдөлгөөний аюулгүй байдлын хяналтын улсын алба, байцаагчаас тавьсан хууль ёсны шаардлагыг биелүүлж хариу гэдэгдэх.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахад орон нутгийн захиргаа, замын хөдөлгөөний аюулгүй байдлын хяналтын улсын албаны бүрэн эрх

15 дугаар зүйл. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын бүрэн эрх

Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах талаар аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1/ нутаг дэвсгэрийн замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахыг төлөвлөн хэрэгжүүлэх;

2/ иргэдэд замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль тогтоомжийг сурталчлах ажлыг зохион байгуулах;

3/ тээврийн хэрэгслийн тооллого, техникийн үзлэг явуулахыг зохион байгуулах;

4/ авто зам, гүүр, түүний хиймэл байгууламжийг шинээр барих, өргөтгөх, засварлах, тоноглох, гэрэлтүүлэг, тэмдэг, тэмдэглэл хийх ажил нь холбогдох стандарт, хөдөлгөөний аюулгүй байдлын шаардлагад нийцэж байгаа эсэхэд хяналт тавих, зохион байгуулах;

5/ нутаг дэвсгэр дээрээ байгаа улсын батлагдсан замын уулзвар бүрт мэдээлэх тэмдэг, замын хөдөлгөөнд аюул учруулж болзошгүй газарт анхааруулах тэмдэг тавих, тэдгээрийг бүрэн бүтэн байлгах.

16 дугаар зүйл. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын хяналтын улсын алба, байцаагчийн бүрэн эрх

1. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын хяналтын улсын алба Монгол Улсын цагдаагийн байгууллагын бүтцэд ажиллах бөгөөд зөвсөгт хүчин болон хилийн цэргийн техникийн шалгах албыг мэрэгжлийн чиг үүргээр харьяална.

2. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын улсын хяналтыг ерөнхий байцаагч, ахлах байцаагч, байцаагч гүйцэтгэнэ.

Замын хөдөлгөөнд хяналт тавих, зохицуулах үүрэгтэйгээр цагдаа ажиллуулж болно.

3. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын хяналтын улсын алба дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1/ Монгол Улсын нутаг дэвсгэрт оршиж байгаа аж ахуйн нэгж, байгууллага, иргэдээс замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахтай холбогдсон хууль, дүрэм, журам, стандартыг хэрхэн хэрэгжүүлж байгаад хяналт тавих;

2/ энэ хууль, замын хөдөлгөөний дүрмийг сурталчлах, осол, хэргээс урьдчилан сэргийлэх ажил зохиох;

3/ тээврийн хэрэгслийн тоо бүртгэлийг хөтлөх;

4/ тээврийн хэрэгслийн улсын дугаар олгох;

5/ тээврийн хэрэгслийн улсын дугаарын үйлдвэрлэлд хяналт тавих.

Тээврийн хэрэгслийн улсын дугаар үйлдвэрлэх зөвшөөрлийг цагдаагийн төв байгууллага олгоно;

6/ тээврийн хэрэгслийн жолоочийн мэргэжлийн шалгалт авч жолоодох эрхийн үнэмлэх олгох;

7/ зам, тээврийн осол, түүнээс учирсан хохирол, замын хөдөлгөөний дүрмийн зөрчлийн тоо бүртгэлийг хөтлөх.

4. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын хяналтын улсын байцаагч дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1/ замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахтай холбогдсон хууль, дүрэм, журам, стандартыг аж ахуйн нэгж, байгууллага, иргэд

хэрхэн хэрэгжүүлж байгааг шалгаж, илэрсэн зөрчлийг арилгах талаар сануулах, амаар болон бичгээр албан шаардлага тавих;

2/ стандартын шаардлага хангаагүй, хөдөлгөөнд аюул учруулж болзошгүй бүрэн бус тээврийн хэрэгслийг замын хөдөлгөөнд оролцуулахыг хориглох, хөдөлгөөнд аюул учруулж болохоор эвдэрч гэмтсэн замын хэсгийг түр хаах, зайлшгүй шаардлагатай тохиолдолд хөдөлгөөний чиглэл, урсгалыг түр өөрчилж, энэ тухай мэдээлэх;

3/ зам, тээврийн осол гаргасан, согтуугаар болон хөдөлгөөнд аюул учруулж болзошгүй бүрэн бус, улсын дугааргүй, шилжилт хөдөлгөөн хийгдээгүй тээврийн хэрэгсэл жолоодсон жолоочийн үнэмлэх, талон, техникийн бичиг баримтыг түр хурааж, зөрчлийг шийдвэрлэж дуустал тээврийн хэрэгслийг тусгай хашаа /талбай/-нд байлгах.

Тээврийн хэрэгслийг тусгай хашаа /талбай/-нд байлгасан хутагааны зардлыг буруутай этгээдээр төлүүлнэ.

Тээврийн хэрэгслийг тусгай хашаа /талбай/-нд түр байлгах журмыг Монгол Улсын Ерөнхий прокурортой зөвшилцөн цагдаагийн төв байгууллагын дарга батална;

4/ жолооч бэлтгэх сургалтыг хангалтгүй зохион байгуулсан, шаардлага хангаагүй сургууль, курсын сургалт явуулах зөвшөөрөл /лиценз/-ийг хураах, багшлах эрхийг хасах санал тавих, жолоочоос шалгалт авах, шалгалтын хутагааг хойшлуулах;

5/ замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахтай холбогдсон хууль, дүрэм, стандарт, журам зөрчсөн албан тушаалтан, иргэдэд хууль тогтоомжид заасан журмын дагуу захиргааны шийтгэл ногдуулах.

5. Замын хөдөлгөөний хяналтын улсын байцаагчаас замын хөдөлгөөн зохицуулах, хянаж шалгах журмыг цагдаагийн төв байгууллагын дарга батална.

17 дугаар зүйл. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын хяналтын улсын байцаагчид хориглох зүйл.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын хяналтын улсын байцаагчид дараахь зүйлийг хориглоно:

1/ тээврийн хэрэгслийн жолооч болон хөдөлгөөнд оролцогч бусад этгээдийг үндэслэлгүйгээр саатуулах;

2/ хууль бус шаардлага тавих, хувийн ажилд тээврийн хэрэгсэл ашиглах, элдэв болзол тавих зэргээр албан тушаалын байдлаа хэтрүүлэн ашиглах.

18 дугаар зүйл. Замын хөдөлгөөний хяналтын улсын албаны зөвшөөрөл заавал авах

Дор дурдсан тохиолдолд замын хөдөлгөөний аюулгүй байдлын хяналтын улсын албаны зөвшөөрлийг заавал урьдчилан авна:

1/ замын хөдөлгөөний чиглэл, урсгалыг өөрчлөх, зам, зорчих хэсгийг нарийсгах болон хөдөлгөөнд саад учруулахаар үйл ажиллагаа явуулах;

2/ замын тэмдэг, тэмдэглэл, хөдөлгөөн зохицуулах техник хэрэгсэл шинээр тавих, хурааж авах, өөрчлөх;

3/ төмөр замын гарам байгуулах, өөрчлөх, хөдөлгөөн зогсоож засварлах;

4/ нийтийн болон тусгай үйлчилгээний тээврийн хэрэгслийн явах чиглэл, зогсох буудлыг шинээр тогтоох буюу өөрчлөх;

5/ замын хөдөлгөөнд саад болох биений тамирын уралдаан тэмцээн, жагсаал, тоглолт зэрэг үйл ажиллагаа явуулах.

ТАВДУГААР БҮЛЭГ

Бусад зүйл

19 дүгээр зүйл. Хууль тогтоомж зөрчигчдэд
хүлээлтэй харигцлага

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдэд зохих хууль тогтоомжийн дагуу эрүүгийн, захиргааны болон сахилгын шийтгэл ногдуулна.

20 дугаар зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

Энэ хуулийг 1996 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Монгол Улсын Их Хурлын дарга

Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1996 оны 4 дүгээр
сарын 8-ны өдөр

Дугаар15

Улаанбаатар
хот

Монгол Улсын төрөөс баримтлах
соёлын бодлогыг батлах тухай

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

"Монгол Улсын төрөөс баримтлах соёлын бодлого"-ыг хавсралтын ёсоор баталсугай.

Дарга

Н. БАГАБАНДИ

Улсын Их Хурлын 1996 оны
15 дугаар тогтоолын хавсралт

МОНГОЛ УЛСЫН ТӨРӨӨС БАРИМТЛАХ СОЁЛЫН БОДЛОГО

Монгол Улсын төр:

-улс орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэхэд соёлын гүйцэтгэх үүргийг эрхэмд үзэж;

-монголын соёл нь тус улсын тусгаар тогтнол, аюулгүй байдлын нэгэн баталгаа, монголчуудын үндэсний бахархал, эв нэгдлийн уг сурвалж, хөгжил дэвшлийн чухал хөшүүрэг мөн болохыг онцлон анхаарч;

-хүн амд үзүүлэх соёлын үйлчилгээг өргөтгөх, урлагийн бүх төрлийг хөгжүүлэх, үндэсний соёлоо үр удамдаа өвлүүлэх, соёлыг өргөн утгаар ойлгож, түүнийг нийгэм, эдийн засгийн бусад салбартай нягт холбох зорилгоор төрөөс тогтвортой баримтлах соёлын бодлогыг тодорхойлж байна.

Нэг. Соёлын бодлогын зарчим

Монгол Улсын төр соёлын бодлогодоо дараахь зарчмыг баримтална:

1/ нийгмийн хямрал, элдэв нөхцөл шалтгааны улмаас монголын соёл устах, бусад үндэстний соёлд уусан замрах, өв уламжлал, ёс заншил алдрах, оюун санааны амьдрал ядууран доройтохоос бүх талаар сэрэмжлэх;

2/ үндэсний соёлыг дэлхийн соёлын ололттой хослуулан хөгжүүлэх;

3/ монголын эрт эдүгээгийн түүх, соёлын дурсгалт зүйлс, сан хөмрөгийг үндэсний эрхэм баялаг гэж үзэж төрийн хамгаалалтад байлгах;

4/ монголын угсаатан, ястны өв соёл, түүх, ёс заншлыг адил гэгш хүндэтгэн үзэж, хадгалан хамгаалах харилцан баяжуулж хөгжүүлэх нөхцөл бололцоог хангах;

5/ иргэдийн сэтгэлгээний болон бүтээн туурвих, үр шимийг нь хүртэх эрх, эрх чөлөөг баталгатай хангах, авьяас чадвараа илрүүлж, хөгжүүлэхэд бүх талын дэмжлэг үзүүлэх;

6/ соёлын үнэт зүйлийг бүтээн туурвигч, өвлөн хадгалагчийг төрийн ивээл халамжид байлгах;

7/ уран бүтээлчид үзэл бодол, арга барил, урсгал чиглэл, дэг сургуулиа чөлөөтэй сонгож хэрэглэхийг дэмжих;

8/ уран бүтээлчид сайн дураар мэргэжлийн эвтэл, холбоо, нийгэмлэг байгуулж, үр өгөөжтэй соёлын үйл ажиллагаа явуулахыг дэмжих;

9/ соёлын салбарт өмчийн олон хэлбэр, зах зээлийн шударга, чөлөөт өрсөлдөөнийг бий болгон үр ашигтай гадаад харилцааг хөгжүүлэх.

Хоёр. Соёлын бодлогын үндсэн чиглэл

Монгол Улсын төрөөс баримтлах соёлын бодлого нь дараахь үндсэн чиглэлтэй байна:

1/ нүүдэлчдийн соёлыг хадгалан хамгаалж түүнийг суурин соёл иргэншилтэй зөв хослуулан хөгжүүлэх;

2/ он цагийн хувьсал өөрчлөлтөд монголын соёл устаж арилахаас хамгаалах дархлаа бий болгох;

3/ үндэсний соёлоо эрхэмлэн дээдэлж түүнийг хөгжүүлэх асуудлыг зүйл бүрээр дэмжих.

Гурав. Соёлын бодлогыг хэрэгжүүлэх арга зам

Монгол Улсын төрөөс баримтлах соёлын бодлогыг дараахь арга замаар хэрэгжүүлнэ:

1/ иргэнийг багаас нь үндэсний соёлын мэдрэмж, мэдлэг, хүмүүжилтэй болгох эрэмбэ дараатай ажлыг бүх шатны боловсролын бүрэлдэхүүн хэсэг болгох;

2/ байгууллага, аж ахуйн нэгж, иргэдээс соёлын үнэт зүйлсийг бүтээх, түүх соёлын дурсгалт зүйлийг судалж сурталчлах, хадгалж хамгаалах үйл ажиллагааг бүх талаар дэмжих;

3/ үйлдвэрлэл, үйлчилгээнд үндэсний уламжлалт болон орчин үеийн технологи нэвтрүүлж, үйлдвэрлэлийн гоо зүй, бизнесийн болон аж байдлын соёл, дизайныг хөгжүүлэхэд байгууллага аж ахуйн нэгж, иргэдийн гүйцэтгэх үүргийг нэмэгдүүлэх;

4/ уламжлалт аж төрөх ёсны хөгжлийн өвөрмөц зүй тогтлыг хадгалж, үндэсний уламжлал, онцлогийг шингээсэн уран барилга, хот байгуулалтын бодлогыг боловсруулж хэрэгжүүлэх;

5/ урлагийн бүх төрөл, зүйлийг анхааран хөгжүүлж, үндэсний уламжлалт, сонгодог болон хүүхдэд зориулсан урлаг, баримтаг киног төрийн ивээлд байлгах;

6/ ард түмний оюуны эрэлт хэрэгцээг хангахад зайлшгүй шаардлагатай шилдэг уран бүтээл болон төслийг шалгаруулж санхүүжүүлэх;

7/ дайн гүрэмгийлэл, хүчирхийлэл, садар самууныг сурталчилсан бүтээл дэлгэрүүлэхэд төрөөс хяналт тавьж, тодорхой үйл ажиллагааг хориглох хүртэл арга хэмжээ авах;

8/ хүн амын соёлын хэрэгцээг хангахад хэвлэл, мэдээллийн хэрэгслийн үүргийг өндөржүүлж, хэвлэлийн чөлөөт байдлыг хангах, ном, кино, хэвлэлийн үйлдвэрлэлийн техник технологийг боловсронгуй болгох, хөгжүүлэх талаар цогцолбор арга хэмжээ авч хэрэгжүүлэх;

9/ хүүхдэд зориулсан ном, хэвлэл, уран бүтээлийг олшруулж, анарыг нь сайжруулах;

10/ эх хэл, бичиг үсэг, түүхээ үндэс язгуураар нь хадгалан сөгжүүлэх;

11/ соёлын суурь болон хавсарга судалгааг эрчимтэй хөгжүүлж, түүний үр дүнг нийтийн болон мэргэжлийн сургалтад өргөн шингэх;

12/ соёлыг түтээн дэлгэрүүлэхэд чиглэсэн иргэдийн аливаа анаачлага, бүтээлч үйл ажиллагааг дэмжих;

13/ соёлын байгууллагын эрх зүйн байдлыг хуульчлан баталгаажуулах;

14/ байгууллага, аж ахуйн нэгж, иргэн ашгийн төлөө болон шгийн төлөө бус соёлын байгууллага байгуулж, үйл ажиллагаа вуулахыг бүх талаар дэмжих;

15/ соёл урлагийн байгууллагын сүлжээг боловсронгуй болгож, дэлхийн жишиг, монгол орны онцлогийг харгалзан соёлын йлчилгээний чанарын үзүүлэлтийг тогтоож мөрдүүлэх;

16/ хөдөөгийн хүн амд соёл, урлагаар үйлчлэх, тэдний ерөний соёлын түвшинг дээшлүүлэх, ахуй нөхцөлийг сайжруулах ажлыг эс дараатай шийдвэрлэх;

17/ соёлын хүрээнд менежмент, маркетингийг хөгжүүлэхэд нхаарах;

18/ соёлын мэргэжлийн боловсон хүчин, багш, судлаач элтгэх сургалтын бүх хэлбэр, түүний дотор гэрийн болон шавь ургалтыг дэмжих;

19/ соёлын ажилтны нийгмийн хамгаалалтыг хуулиар баталгаажуулж, нийгмийн асуудлаа шийдвэрлэхэд нь бодитой туслалцаа эмжлэг үзүүлэх;

20/ соёлын үнэт зүйлийг бүтээн туурвигч, соёл, урлагийн ирамгай зүтгэлтэн, авьяас билэгтнүүдийг төрийн ивээл, халамжид

байлгаж, бүтээн туурвих, өвөрмөц дэг сургуулиа өвлөн үлдээх боломжоор хангах;

21/ соёлын гадаад харилцаа, хамтын ажиллагааг сонирхогч бүх улс орон, олон улсын байгууллагатай чөлөөтэй хөгжүүлж, энэ харилцаанд Засгийн газрын бус байгууллага, иргэд бие даан оролцох бололцоог өргөтгөх;

22/ соёлын үнэт зүйлийг хамтран бүтээх, оюуны ололтыг харилцан дэлгэрүүлэх, мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх, шинэ техник, технологи нэвтрүүлэх, соёлын үйл ажиллагааны туршлага солилцох, соёлын салбарт хамтарсан төсөл, хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэхийг соёлын гадаад харилцааны чухал чиглэл болгох;

23/ соёл, шинжлэх ухааны байгууллага, уран бүтээлийн мэргэжлийн эвлэл, холбоо, нийгэмлэг болон хувь хүмүүс үндэсний соёлын уламжлал, зан заншлыг сурталчлан дэлгэрүүлэхэд чиглэсэн аливаа үйл ажиллагаа явуулах, монголын соёлын төвийг гадаадад байгуулах, монголыг сонирхогч, дэмжигч, гадаадын иргэд, байгууллагатай соёлын ажил хэрэгч холбоо тогтоохыг бүх талаар дэмжих;

24/ хууль бусаар гадаадад гаргасан монголын түүх, соёлын дурсгалт зүйлсийг эргүүлэн авчрах ажлыг зохион байгуулах;

25/ төрөөс соёлын үйл ажиллагааг дэмжих зориулалтын сан байгуулж, ажиллуулах;

26/ соёлын үйл ажиллагааг дэмжих хөрөнгө оруулалт, гааль, санхүү, зээл, татварын таатай бодлого явуулж, соёлын хүрээнд гадаадын хөрөнгө оруулалт хийх нөхцөл бүрдүүлэх;

27/ соёлын үйл ажиллагаа эрхлэх хувийн хэвцлийн аж ахуйн нэгж, байгууллага үүсч хөгжихийг дэмжих;

28/ соёлын үйл ажиллагааг санхүүжүүлэх баталгаатай эх үүсвэрийг бүрдүүлэх зорилгоор улсын төвлөрсөн болон орон нутгийн төсвийн зохих хэсгийг жил бүр хуваарилан зарцуулах;

29/ төрийн соёлын бодлогын зарчим, чиглэл, хэрэгжүүлэх арга замыг холбогдох хууль тогтоомжоор баталгаажуулах.

Дөрөв. Бусад зүйл

1. Соёлын хууль тогтоомж, эрхийн актыг боловсруулах, тэдгээрийг боловсронгуй болгохдоо энэхүү бодлогыг үндэс болгоно.

2. Төрөөс баримтлах соёлын бодлогыг Монгол Улсын Засгийн газар, төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагын чиг үүрэг, эрхлэх асуудалд хамааруулж тэдгээрийн үйл ажиллагаагаар дэмжуулан хэрэгжүүлнэ.

3. Соёлын бодлогын хэрэгжилтэд Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хяналт тавина.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТОГТООЛ**

1996 оны 4 дүгээр
сарын 11-ний өдөр

Дугаар 21

Улаанбаатар
хот

Соёлын хуулийг хэрэгжүүлэх зарим
арга хэмжээний тухай

Монгол Улсын Их Хурлаас **ТОГТООХ** нь:

Соёлын хууль батлагдсантай холбогдуулж хууль хүчин төгөлдөр болохоос өмнө соёлын үйл ажиллагаа эрхэлж байсан байгууллага, аж ахуйн нэгжүүдийг 1996 оны 8 дугаар сарын 1-ний дотор нөхөн бүртгэх арга хэмжээ авахыг Засгийн газарт даалгасугай.

Дарга

Н. БАГАБАНДИ

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТОГТООЛ**

1996 оны 4 дүгээр
сарын 25-ны өдөр

Дугаар 24

Улаанбаатар
хот

Нийслэлийн нутаг дэвсгэрийн хилийн
цэсийг шинэчлэн тогтоох тухай

Монгол Улсын Их Хурлаас **ТОГТООХ** нь:

1. Монгол Улсын Нийслэлийн нутаг дэвсгэрийн хилийн цэсийг 1 дүгээр хавсралтын ёсоор, түүний дүүргүүдийн нутаг дэвсгэрийн хилийн цэсийг 2 дугаар хавсралтын ёсоор тус тус баталсугай.

2. Нийслэлийн хилийн цэсийг баталсантай холбогдуулан Төв аймгийн Алтанбулаг, Аргалант, Эрдэнэ, Сэргэлэн, Баяндэлгэр, Баян, Баянчандмань сумдын хилийн цэсийг шинэчлэн боловсруулж Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг Засгийн газарт даалгасугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан Ардын Их Хурлын Тэргүүтэргүүдийн 1982 оны 131 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд гооцсугай.

Дарга

Н. БАГАБАНДИ

Монгол Улсын Их Хурлын
1996 оны 24-р тогтоолын
I дүгээр хавсралт

НИЙСЛЭЛИЙН НУТАГ ДЭВСГЭРИЙН ХИЛИЙН ЦЭС

Согоот уул /1758.2/, 1626.0 тоот, Цагаан даваа, Тарвагатайн даваа, 1599.4 тоот, Шар хөтөлийн даваа /1371.5/, Бага өлийн даваа /1378.0/, 1587.0, 1305.0, 1327.0, 1638.0 тоотууд, Цохиот уул /1706.2/, 2033.3, 1946.0, 2091.0, 2101.0 тоотууд, Цангын даваа, 2045.6 тоот, Улаанхаргайн даваа /1948.0/, 2076.0 тоот, Шавартын даваа, /2068.0/, Бэрх даваа /2034.0/, Даваатын даваа /1899.0/, 2234.0 тоот, Ётгын даваа /2001.0/, Бугатын даваа /1976.0/, Шилжирэнгийн даваа /1842.0/, зүүн тийш эргэж Ганц модны жалгын гозгор, Тэрэлж голын шон №12, голоо уруудан шон №13, Тэрэлж голоо уруудан Туул Тэрэлж голын бэлчир, Туул голын баруун эргээр уруудан шон №14, 1627.6, 1671.4, 1662.0, 1591.0 тоотууд, Улаан овооны даваа /1784.1/, 1851.3 тоот, Багабаян уул /1893.7/, 1626.0, 1681.0 тоотууд, Баянгийн бүрд нуур, Баян уул /1717.0/, 1697.3 тоот, Шаварт уул /2002.5/, 1813.3 тоот өндөрлөг, Мандахын гозгор, Номт уул /1793.0/, Баруундэлгэр уул /1893.0/, 1822.5 тоот, Намдаваа, Шархөвийн хяр, Ханан уул /1689.0/, 1663.0, 1601.1, 1655.9 тоотууд, Тоорой шандын уул, Богины хөтөл /1419.0/, Сүүл даваа /1494.0/, Ташгайн даваа /1347.0/, шон №6, №7, №8, №9, №10, №11, Хөндлөн уул, Салхит уул /1417.0/, 1348.0 тоот, Сайр худаг, 1474.6, 1463.0 тоотууд, Баянцогт овоо, 1497.0, 1353.0, 1552.0, тоотууд, Их булаг /1483.0/, 1473.4 тоот, Бөөр толгой, Замтын горхи, Дэлгэр булгийн уулзвар, 1661.9 тоот, Хар модотын даваа, 1725.4, 1753.0, 1764.0 тоотуудыг дамжин Согоот уул /1758.2/-нд хүрнэ.

1811.0 тоот, шон №1, Дунд Байдлаг гол, Холохын голын уулзвар, Хэрлэн гол Дунд Байдлаг голын бэлчир, Хэрлэн голын баруун эргээр уруудан Хэрлэн голын гүүр, Хэрлэнгийн товчоо, Багануур-Аягын амны төмөр замын гарц, Улаанбаатараас Багануур хүрлэг засмал зам, Хэнтий аймаг яадаг шороон замын уулзвар (шон №2), 1689.3 тоот, 1811.0 тоот хүрнэ.

1614.2 тоот, Бөөгийн толгой, Өндөр дэл /1610.8/, Гэр овоо /1537.0/, Улаанбаатар-Чойрын авто замаар явж, Багахангай Багануурын чиглэлийн төмөр замыг огтлон Гурван толгой /1461.5/, 1504.2 тоот, Алтганы овоо, Хуурай худаг, 1614.2 тоотод хүрнэ.

Монгол Улсын Их Хурлын
1996 оны 24-р тогтоолын
2-р хавсралт

НИЙСЛЭЛИЙН ДҮҮРГҮҮДИЙН НУТАГ ДЭВСГЭРИЙН ХИЛИЙН ЦЭС

1. Баянзүрх дүүрэг

Духын даваа, 2033.3, 1946.0, 2091.0, 2101.0 тоотууд, Цангын даваа, 2045.6, Улаан харгайн даваа /1948.0/, 2076.0, Шавартын даваа /2068.0/, Бэрх даваа /2034.0/, Даваатын даваа /1899.0/, 2234.0, Ёлтын даваа /2001.0/, Бугатын даваа /1976/, Шилжирэнгийн даваа /1842.2/, 1962.6, Оргих уул /2197.0/, Дүнхэн уул /2120.2/, Номт уул /2096.0/, 2011.0, 1684.0, 1552.0 тоотууд, Майхан уул, 1552.0, 1564.0 тоотууд, Баян уул /1717.0/, 1697.3, Шаварт уул /2002.5/, 1813.3, Мандахын гозгор, Номт уул /1793.0/, Баруундэлгэр уул /1893.0/, Зүрх уул, Улаан асгат /1855.0/, Их ёл уул, Сэнж цохио, Их тэнгэр уул /1731.3/, Бага тэнгэр уул, Их тэнгэрийн амны Туул голын гүүр, Марксын гудамж, Сэлбэ гол, Сэлбийн рашаан, 1582.3, 1713.2, 1891.0 тоотууд, Сэрвэнгийн уулыг хярлан 2042.7 тоот, Гүнтийн хадан уул /2122.0/, Духын даваанд хүрнэ.

2. Сонгинохайрхан дүүрэг

Баянцогт овоо, 1497.0, 1353.0, 1552.0 тоотууд, Их булаг /1483.0/, 1473.4 тоот, Бөөр толгой, Замтын горхи Дэлгэр булгийн уулзвар, 1661.9 тоот, Хар модотын даваа, 1725.4, 1753.0, 1764.0 тоотууд, Согоот уул /1758.2/, 1626.0 тоот, Цагаан даваа, Тарвагатайн даваа, 1599.4 тоот, Шар хөтлийн даваа /1371.5/, Бага өлийн даваа /1378.0/, 1587.0, 1305.0, 1327.0, 1638.0 тоот Цохиот уул /1706.2/, Мухарын даваа /1638.0/, Хадлангийн даваа, 1702.0, 1760.9 тоотууд, Хужиртын даваа, Гүнтийн даваа, Чингэлтэй уул, Байшинтын гозгор уул /1600.9/, Хамба толгой /1686.0/-гоос Мааньтын хөтөл, Баянхошууны сойд замаар явж Зурагтын эцсийн буудлын хойт талын гүүр хүрч жалгаар баруун тийш эргэн 1525.7 тоот, Шон №1, №2-оос Нэгдсэн 3-р эмнэлгийн баруун талын аюулгүйн тойргоос Энхтайваны өргөн төлөөны засмалаар баруун тийш Сонсголонгийн замын уулзвар гүрч, урагшаа замаараа Сонсголонгийн гүүр, Туул голын хойд эргээр Сонгины булан, Жаал толгой, Залаа уул /1562.0/, Сонгинохайрхан уул /1652.3/, 1474.6, 1463.0 тоотоор дамжин Баянцогт овоо хүрнэ.

3. Баангол дүүрэг

Энхтайваны гүүр, гүүрнээс баруун тийш Дундголын хойд эргээр уруудаж Туул гол хүрч, Туул голын хойд эргийг даган Сонсголонгийн гүүр хүрч хойшоо засмал замаар эргэн Энхтайваны өргөн чөлөөтэй нийлж зүүн тийш Энхтайваны өргөн чөлөөгөөр явж аюулгүйн тойргоор хойш эргэн Нэгдсэн 3-р эмнэлгийн баруун талын засмал замаар дээш Шон №1, №2, 1527.7 тоот хүрч зүүн тийш эргэн жалгаар Зурагтын эцсийн буудлын хойт талын гүүр хүрч засмал замын зүүн талаар урагш эргэн Их тойруугаар Тээвэрчдийн гудамж хүрч зүүн тийш эргэн Энхтайваны гүүр хүрнэ.

4. Чингэлтэй дүүрэг

Чингэлтэй уул /1949.7/, Гүнтийн даваа, Хужиртын даваа, 1760.9, 1702.0 тоотууд, Хадлангийн даваа, Сэлбийн гол, голын баруун эргээр уруудан Дамбаларжаагийн гүүр хүрч, засмал замд орж, засмал замын баруун талаар урагшаа явж дэнжийн 1000-н урд талын засмалаар баруун тийш эргэн баруун Сэлбэ хороололын баруун талын засмалаар их тойруу хүрнэ. Үүнээс зүүн тийш явж Сүхбаатарын гудамжаар урагш эргэн Энхтайваны өргөн чөлөөгөөр баруун тийш баруун дөрвөн зам хүрч Их тойруугаар Гэсэр сүм, Хувьсгалчдын замаар хойшоо эргэн Зурагтын эцсийн буудлын хойд гүүр, Мааньтын хөтөл, Хамба толгой /1686.0/, Байшинтын гэлгэр уул /1800.9/, Чингэлтэй уул хүрнэ.

5. Сүхбаатар дүүрэг

Ганц худгийн толгой /1582.3/, Сэлбийн рашаан, Сэлбэ гол хүрч голоор уруудан Тээвэрчдийн гудамжны гүүр хүрч баруун тийш эргэн Тээвэрчдийн гудамжаар явж, Их тойруугаар хойш эргэн баруун дөрвөн зам хүрч зүүн тийш эргэн Энхтайваны өргөн чөлөөгөөр явж Сүхбаатарын гудамж хүрч хойшоо эргэн Их тойруугаар баруун тийш эргэн Дэнжийн 1000-н урд талын засмалаар Сэлбийн гүүр хүрч Сэлбэ голоор өгсөн Хадлангийн даваа, Мухарын даваа /1638.0/ Цохног уул /1706.2/, 2033.5 тоот, Духын даваа, Гүнтийн хадан уул /2122.0/, 2042.7 тоот, Сэрвэн уулыг хярган уруудан 1891.0, 1713.2 1582.3 тоот өндөрлөг хүрнэ.

6. Налайх дүүрэг

Шилжирэнгийн даваа /1842.0/, Ганц модны голгор, Тэрэлж голын шон №12, №13, Туул Тэрэлж голын бэлчир, Туул голын үлдсэн гальдрилоор уруудан шон №14, 1627.6, 1671.4, 1662.0, 1591.0 тоотууд, Улаан овооны даваа /1784.1/, 1851.3 тоот, Бага Бали уул /1893.7/, 1626.0, 1681.0 тоот, Баянбүрд нуур, Баян уул /1717.0/, 1564.0, 1552.0, Майхан уул /1756.0/, 1552.0, 1684.0, 2011.0 тоотууд, Номт уул /2096.0/, Дүнхэн уул /2120.2/, Оргих уул /2197.0/, 1962.6 тоот, Шилжирэнгийн даваа хүрнэ.

7. Хаа-уул дүүрэг

Сонгинохайрхан уул /1652.3/, Сонгино уулын хойд толгой, Залаа уул /1562.0/, Жаал толгой, Сонгины булан, Туул голыг өгсөж Сонсгалонгийн гүүр, Туул-Дунд голын бэлчир, Дунд голын хойд далангаар нь өгсөж Дунд гол Марксын гудамжны машин замын огтлолцол, Марксын гудамжны хар замыг баруун талаар нь уруудаж Их тэнгэрийн амны Туул голын гүүр, Бага тэнгэр уул, Их тэнгэр уул /1731.3/, Сэнж цохио, Их ёл уул, Улаан асгат /1355.0/, Зүрх уул /1683.8/, Баруундэлгэр уул /1893.0/, Төв уул /1822.5/, Нам даваа, Шар хөвийн хяр, Ханан уул /1683.8/, 1601.1, 1685.9 тоот Тоорой шандын уул, Богино хөтөл /1419.0/, Сүүл даваа /1494.0/, Талгайн даваа /1347.0/, шон №6, №7, №8, №9, №10, №11, Хөндлөн уул /1402.0/, Салхит уул /1417.0/, 1348.0 тоот, Сайр хулаг, 1474.0 тоот Сонгинохайрхан уул хүрнэ.

8. Багануур дүүргийн хилийн нэс

1811.0 тоот, шон №1, Дунд Байдлаг гол, Хөлсхын голын уулзвар, Хэрлэн гол Дунд Байдлаг голын бэлчир, Хэрлэн голын баруун эргээр уруудан Хэрлэн голын гүүр, Хэрлэнгийн товчоо, Багануур-Аягын амны төмөр замын гарц, Улаанбаатаралс Багануур хурдаг засмал зам, Хэнтий аймаг явдаг шороон замын уулзвар (шон №2), 1689.3 тоот, 1811.0 тоот хүрнэ.

9. Багахангай дүүргийн хилийн нэс

1614.2 тоот, Бөөгийн толгой, Өндөр дэл /1610.8/, Гэр овоо/1537.0/, Улаанбаатар-Чойрын авто замаар явж, Багахангай Багануурын чиглэлийн төмөр замыг огтлон Гурлан толгой /1461.5/, 1504.2 тоот, Алтганы овоо, Хуурай худаг, 1614.2 тоотод хүрнэ.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН
ЗАРЛИГ**

1996 оны 5 дугаар
сарын 24-ний өдөр

Дугаар 114

Улаанбаатар
хот

Хугацаа сунгах тухай

1995 оны 6 дугаар сард цэргийн албанд татагдсан зарим цэргийн албан хаагчдыг төрийн цэргийн ёслолын ажиллагаанд оролцуулах зорилгоор Монгол Улсын Иргэний цэргийн үүргийн болон Цэргийн албан хаагчдын эрх зүйн байдлын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 2 дугаар заалтыг үндэслэн Зэвсэгт хүчний ОЗД дугаар ангийн хүндэт харуулын тусгай ротын 85 байлдагч, түрүүчийн цэргийн алба хаах хугацааг 1996 оны 7 дугаар сарын 20-ныг хүртэл сунгасугай.

Монгол Улсын Ерөнхийлөгч

П. ОЧИРБАТ

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН
ЗАРЛИГ**

1996 оны 5 дугаар
сарын 25-ны өдөр

Дугаар 115

Улаанбаатар
хот

**Ч. Нямдарал Монгол Улсын
хүний гавьяат эмч цол
олгох тухай**

Аймгийн эрүүлийг хамгаалах байгууллагын бүтэц, зохион байгуулалтыг оновчтой болгон хүүхдийн болон бөөрний сувилал, Монгол эмнэлгийн тасаг шинээр байгуулан ажиллуулж, дотрын өвчний оношлогоо, эмчилгээний чанарыг сайжруулан нарийн мэргэжлийн тусламжийн хүрээг өргөтгөхөд тодорхой хувь нэмэр оруулж, өөрийн мэдлэг, туршлагаа залуу эмч нарт өвлүүлэн тэднийг сургаж далагаажуулахад идэвхи зүтгэл гарган ажиллаж байгааг нь үнэлж Говь-Алтай аймгийн нэгдсэн эмнэлгийн зөвлөх эмч Чогдонгийн Нямдарал Монгол Улсын хүний гавьяат эмч цол олгосугай.

Монгол Улсын Ерөнхийлөгч

П. Очирбат

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН
ЗАРЛИГ**

1996 оны 5 дугаар
сарын 25-ны өдөр

Дугаар 116

Улаанбаатар
хот

**П. Шижээд Монгол Улсын хүний
гавьяат эмч цол олгох тухай**

Сумын эмнэлэгт олон жил тогтвор суурьшилтай, үр бүтээлтэй ажиллаж эмнэлгийн үзлэг, үйлчилгээг тогтмол чанартай явуулснаар сүүлийн 15 жил эхийн эндэгдэл гаргалгүй, нялхсын эндэгдэл, халдварт өвчнийг эрс бууруулж хүн амын эрүүл мэндийг хамгаалах үйл хэрэгт оруулсан хувь нэмрийг нь үнэлж Говь-Алтай аймгийн Тонхил сумын хүн эмнэлгийн салбарын эрхлэгч, их эмч Павдайн Шижээд Монгол Улсын хүний гавьяат эмч цол олгосугай.

Монгол Улсын Ерөнхийлөгч

П. ОЧИРБАТ

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН
ЗАРЛИГ**

1996 оны 5 дугаар
сарын 30-ны өдөр

Дугаар 123

Улаанбаатар
хот

**Зарим шүүхийн шүүгчийг
томилгох тухай**

Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн Пандийн Долормааг Архангай аймгийн шүүхийн шүүгчээр, Ядамсүрэнгийн Утаннавчийг Сүхбаатар аймгийн шүүхийн шүүгчээр, Бямбаагийн Унгалагсайхан, Дэнсамбуугийн Цэнгэл нарыг Архангай аймаг дахь ум дундын шүүхийн шүүгчээр, Гэндэнсүрэнгийн Сарангэрэлийг Завхан аймаг дахь сум дундын 2 дугаар шүүхийн шүүгчээр, Сүхээийн Оюунчимэгийг Нийслэлийн Чингэлтэй дүүргийн шүүхийн шүүгчээр тус тус томилсугай.

Монгол Улсын Ерөнхийлөгч

П. ОЧИРБАТ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН
ЗАРЛИГ

1996 оны 6 дугаар
сарын 10-ны өдөр

Дугаар 126

Улаанбаатар
хот

Дээд офицерын албан тушаалын
ангилал, цэргийн цолны зэрэг-
лэлд нэмэлт оруулах тухай

Иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 1, Цагдаагийн байгууллагын тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн заалтыг үндэслэн Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1994 оны 72 дугаар зарлигаар тогтоосон "Дээд офицерын албан тушаалын ангилал, цэргийн цолны зэрэглэл"-д дор дурдсан албан тушаалын ангилал, цэргийн цолны зэрэглэлийг хамааруулсугай. Үүнд:

"17. Монгол Улсын Иргэний
хамгаалалтын газрын
дэд дарга, төв штабын
дарга

хурандаа-хошууч генерал

18. Цагдаагийн ерөнхий
газрын дэд дарга

хурандаа-хошууч генерал"

Монгол Улсын Ерөнхийлөгч

П. ОЧИРБАТ

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ТОГТООЛ**

1996 оны 1 дүгээр
сарын 29-ний өдөр

Дугаар 16

Улланбаатар
хот

Биеийн тамир, спортыг хөгжүүлэх үндсэн чиглэл батлах тухай

Монгол Улсын Засгийн газраас **ТОГТООХ** нь:

1. "Монгол Улсад биеийн тамир, спортыг хөгжүүлэх үндсэн чиглэл"-ийг баталсугай.
2. Биеийн тамир, спортыг хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ авахыг Эрүүл мэндийн сайд П. Нямдаваа, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.

Монгол Улсын Ерөнхий сайд
Эрүүл мэндийн сайд

П. ЖАСРАЙ
П. НИЯМДАВАА

Засгийн газрын 1996 оны 16
дугаар тогтоолын хавсралт

**МОНГОЛ УЛСАД БИЕИЙН ТАМИР, СПОРТЫГ
ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ**

Хүн амын эрүүл мэндийг бэхжүүлэх, хөдөлгөөний хомсдолыг багасгах, ялангуяа өсөөр залуу үсийг эрүүл чийрэг өсгөн төлөвшүүлэх үйлсэд бие бялдрын соёл, биеийн тамир, спортын үзүүлэх нөлөөг нэмэгдүүлж, олимпын наадам, тивийн тоглолт, тив, дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд өрсөлдөх ур чадвартай тамирчин бэлтгэж, биеийн тамир, спортын байгууллагын ажлыг шинэчлэхэд үндсэн чиглэлийн гол зорилго оршино.

Нэг. Нийтийн биеийн тамирын талаар

Хүн амын бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн түвшинг тогтмол үнэлэн судлах тогтолцоог бүрдүүлж, хөдөлгөөний хомсдолоос гаргах, Элдэржуулах, эрүүлжүүлэх хөдөлгөөний жоруудыг шинжлэх ухааны үндэстэй боловсруулан бие бялдрын хөгжлийг сайжруулан чийрэг-

жүүлэх, өвчин эмгэгээс сэргийлэх, эмчлэн эрүүлжүүлэх, бие махбодийн чадавхийг нөхөн сэргээхэд өргөнөөр ашигладаг болно.

Бие бялдарын соёл, биеийн тамир, спортын ач холбогдлыг мэдээллийн төрөл бүрийн хэрэгслээр сурталчилж, биеийн тамир, спортыг хүн амын бүх давхрагын, нэн ялангуяа хүүхэд, залуучуудын өдөр тутмын хэрэгцээ болгоход шаардагдах орчин нөхцөлийг гэр бүл, албан байгууллага, бүх шатны сургуулиудад бий болгох дэс дараатай арга хэмжээ авч, нийтийн биеийн тамир, спортоор тогтмол хичээллэгчдийн тоог нэмэгдүүлнэ.

Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуульд заах биеийн тамирын хичээлийн агуулга, арга зүйг хүүхдийн нас, бие бялдарын хөгжлийн байдал, нутаг дэвсгэрийн онцлогт тохируулан өөрчлөн шинэчилнэ.

Өөрийн хүч хөрөнгө, үүсгэл санаачилгаар биеийн тамирын танхим, талбай барих, спорт клуб, эрүүл мэнд-чийрэгжилтийн төв байгуулж ажиллагсад, тэдний гэр бүлийнхнийг биеийн тамир, спортоор хичээллэх боломж олгож байгаа байгууллага, иргэдийг бүхий л талаар дэмжинэ.

Орон нутгийн захиргаа, албан байгууллага, аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааг нийтийн биеийн тамирын ажлын үзүүлэлтүүд, түүнд хамрагдагсдын болон биеийн тамир, спортоор тогтмол хичээллэгчдийн тоог хэрхэн нэмэгдүүлснийг харгалзан дүгнэх тогтолцоо тогтоон мөрдүүлнэ.

Биеийн тамир, спортоор хичээллэгчдэд эрүүл мэнд, эрүүл ахуйн зөвлөлгөө өгөх, дасгалжилтын зэрэг, дасгал сургуулийн тохиромжийг тогтоох үйлчилгээг өргөжүүлж, холбогдох мэргэжлийн хүмүүсийг бэлтгэх, давтан сургахад анхаарч шаардагдах хэрэгсэл, багаж, эм, урвалжлар хангах нөхцөлийг бүрдүүлнэ.

Хоёр. Спортыг хөгжүүлэх талаар

Хүн амынхаа бие бялдарын онцлог, орон нутгийн уламжлал, байгаль, цаг агаарын онцлогтой уялдуулан үндэсний болон орчин үеийн спортын төрлийг бүрчлэн сонгож хөгжүүлнэ.

Тамирчдын үзүүлж байгаа амжилтыг олон улсын спортын амжилтын түвшинтэй харьцуулан түүнд цаашид хүрэх үе шаттай ангилал боловсруулж мөрдөнө. Олимпын наадам, тивийн тоглолт, тив, дэлхийн аварга шалгаруулах болон олон улсын тэмцээнд оролцох баг, тамирчдыг сонгон шалгаруулах үндэсний нормативыг шинэжлэх ухааны үндэслэл, олон жилийн амжилтын түвшинтэй харьцуулан боловсруулж мөрдөнө. Дэлхийн жишигт хүрэх тамирчдыг бэлтгэх,

сонгон шалгаруулах гол арга зам нь спортын клубийн тогтолцоо, олон нийтийн үүсгэл санаачилга гэж үзэж тэдгээрийг бүх талаар дэмжих механизм бий болгоно.

Тамирчдын залгамж халааг бэлтгэх дотуур байртай спортын сургууль төрөлжсөн сургалттай анги, бүлэг хичээллүүлэх замаар тамирчдыг бэлтгэх сургалт дасгалжуулалтын нэгдсэн системийг бий болгож, программын агуулга, сургалтын арга зүйн шинжлэх ухааны үндэслэлийг дээшлүүлнэ.

Тамирчдын спортын ур чадвар, амжилтыг дээшлүүлэхэд чиглэсэн сургалт, дасгалжуулалт, спортын сэтгэл зүй, эмнэлэг, биологи, үйл оношлолын суурь болон хавсарга судалгаа, шинжилгээний ажлыг явуулж, түүний материаллаг баазыг бэхжүүлнэ.

Олон улс, улсын чанартай уралдаан тэмцээний төлөвлөлтийг боловсронгуй болгож, багш, дасгалжуулагчид, тамирчдын эх оронч хүмүүжил, сахилга, хариуцлагыг дээшлүүлж, уралдаан, тэмцээнд оролцох тамирчдад тавих спортын ур чадварын шаардлагыг өндөржүүлнэ.

Олимпийн хөдөлгөөнийг өөрийн оронд өрнүүлэх үүднээс бүх шатны сургуулиудын хичээлийн хөтөлбөрт олон улсын олимпийн хөдөлгөөний түүхэн замналаар сургалт явуулах, олимпийн музей, академи байгуулах эхлэлийг тавина.

Гурав. Биеийн тамир, спортын удирдлага, зохион байгуулалтыг боловсронгуй болгох талаар

Засгийн газрын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт засныг үндэслэн биеийн тамир, спортыг хөгжүүлэх талаар төрөөс гүйцэтгэх чиг үүргийг Монголын үндэсний олимпийн хороонд (МҮОХ) хариуцуулан гүйцэтгүүлж, үүнтэй холбогдон гарах зардлыг төрөөс санхүүжүүлнэ.

Монголын үндэсний олимпийн хороо нь Засгийн газрын 1994 оны 25, 1995 оны 111 дүгээр тогтоолын дагуу тухайн хүрээний асуудал эрхэлсэн сайдтай гэрээ байгуулан ажиллаж, биеийн тамир, спортыг хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх ажлыг мэргэжлийн удирдлагаар хангаж, төрийн болон Засгийн газрын бус байгууллагуудын идэвхтэй, хамтын ажиллагааг өрнүүлэх замаар үндсэн чиглэлийн биелэлтийг хангуулах үүргийг хүлээж ажиллана.

Биеийн тамир, спортын үйл ажиллагаанд зах зээлийн зохицуулалт, төлөвлөлт, удирдлагын системийг нэвтрүүлж, мэдээлэл солилцооны уян хатан сүлжээ бий болгох үндсэн дээр салбарыг нэгдсэн

удирдлагаар хангах нөхцөлийг бүрдүүлэх, спортын холбоод, биеийн тамир, спортын байгууллагуудын хамтын ажиллагааг өргөтгөх талаар анхаарна.

Олон улсын биеийн тамир, спортын байгууллагуудын үйл ажиллагаанд идэвхтэй оролцож, хоёр талын болон олон талын хамтын ажиллагааг бүх талаар өргөжүүлнэ.

Спортын барилга байгууламж барих, хэрэглэл материал, тоног төхөөрөмж үйлдвэрлэх жижиг оврын үйлдвэр байгуулах төсөл шалгаруулж хэрэгжүүлэх талаар гадаад, дотоодын сонирхсон байгууллагууд, аж ахуйн нэгжтэй хоршин ажиллаж, улмаар спортын хэрэглэл, тоног төхөөрөмжийн дотоодын үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ.

Хөрөнгө оруулалт, төсвийн зарцуулалтыг оновчтой зохион байгуулж үр өгөөжийг дээшлүүлэн, биеийн тамир, спортыг нийт хүн амын хэрэгцээ, сонирхол, орчин үеийн сургалт, дасгалжуулалтын шаардлагад нийцүүлэн хөгжүүлэх нөхцөлийг бий болгохыг чухалчилна.

Биеийн тамир, спортыг ивээн тэтгэгч байгууллагын эгнээг өргөжүүлэх, байнгын ивээн тэтгэгчдийг бий болгох замаар "Олимпын сан"-г арвижуулах, "Спортын бүх нийтийн сан" байгуулах санаачилгыг дэмжин өргөжүүлнэ. Ивээн тэтгэгчдийн үйл ажиллагааг сурталчлах ажлыг өргөжүүлж, тэднийг үйл ажиллагааны нь үр дүнд харгалзан урамшуулна.

Спортын хэрэглэлийн үйлдвэрлэл эрхэлдэг хувийн хэвшлийн аж ахуй, нэгжийг дэмжих, гадаад орнуудын спортын байгууллагатай хамтран уралдаан тэмцээн, аялал жуулчлал зохион байгуулах зэргээр хөрөнгийн эх үүсвэр бий болгоход анхаарлаа хандуулна.

**Дөрөв. Ажиллагчдын нийгмийн асуудал,
боловсон хүчин бэлтгэх талаар**

Тамирчид, багш, дасгалжуулагчийн шагнал, урамшлыг зах зээлийн онцлогтой уялдуулан боловсронгуй болгож байна.

Тамирчид, багш, дасгалжуулагчдын хөдөлмөр хамгааллыг сайжруулах, спортын заал, талбайн соёл, эрүүл ахуйн нөхцөлийг хангахад онцгой анхаарч, тамирчид хөдөлмөрийн чадвараа аддсан тохиолдолд олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай санал боловсруулж эзних журмын дагуу шийдвэрлүүлнэ.

Биеийн тамирын багш, нийтийн биеийн тамирын арга зүйч, дасгалжуулагч зэрэг мэргэжлээр боловсон хүчин бэлтгэнэ.

Олон улсын олимпын хороо, бүс нутгийн байгууллагын дэмжлэг, тусламжаар удирдах ажилтан, дасгалжуулагч, шүүгчдийн мэргэ-

Эдг дээшлүүлэх сургалтыг зохион байгуулж, гадаад орнууд, олим-
пийн академид үндэсний боловсон хүчин сургаж бэлтгэх ажлыг үе
пагтайгаар зохион байгуулна.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1996 оны 2 дугаар
арын 7-ны өдөр

Дугаар 26

Улаанбаатар
хот

“Улсын сайн малчин”, “Улсын тэргүү-
ний тариаланч” шалгаруулах тухай

Хүнс, хөдөө аж ахуйн яамны саналыг үндэслэн Монгол Улсын
асгийн газраас ТОГТООХ нь:

Мал сүргээ үр төлөөр нь өсгөн, малынхаа үүддэрлэг байдал,
шиг шимийг сайжруулж, мал аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэ-
лийг нэмэгдүүлэх талаар амжилт гаргасан, энэ тогтоолын 1 дүгээр
хэсэрт дурдсан малчныг “Улсын сайн малчин”-аар, газар тари-
алангийн үйлдвэрлэлийг үр дүнтэй эрхлэн арвин ургац авч, газрын
шиглалтыг сайжруулах, газар тариалангийн бүтээгдэхүүний үйлд-
вэрлэлийг нэмэгдүүлэх талаар амжилт гаргасан, энэ тогтоолын 2 ду-
гаар хэсэрт дурдсан тариаланчныг “Улсын тэргүүний тари-
аланч”-аар тус тус шалгаруулсугай.

Монгол Улсын Ерөнхий сайд

П. ЖАСРАЙ

Хүнс, хөдөө аж ахуйн сайд

Ц. ӨӨЛД

Засгийн газрын 1996 оны 26 дугаар
тогтоолын 1 дүгээр хэсэрт

УЛСЫН САЙН МАЛЧНААР:

1. Завхан аймгийн Цэцэн-уул сумын Сангийндалай багийн мал-
чин Агьяагийн ЧИМЭД;
2. Говь-алтай аймгийн Дарви сумын 2 дугаар багийн малчин
амсрайн ОСОРХҮҮ;
3. Өвөрхангай аймгийн Хайрхандулаан сумын 5 дугаар багийн
алчин Дашзэвэгийн ЯНГИВ;

4. Хөвсгөл аймгийн Цагаан-уул сумын Хужирт багийн малчин Жагчивын ДОРЖДАГВА;
5. Дундговь аймгийн Гурвансайхан сумын Элгэн багийн малчин Донторын СЭРЖ;
6. Сүхбаатар аймгийн Баяндэлгэр сумын Дэлгэр багийн малчин Цэрэндоржийн ВАНЧИНСУГЭН;
7. Орхон аймгийн Баацагаан сумын 3 дугаар багийн малчин Сангийн ТАМЖАА;
8. Ховд аймгийн Ховд сумын Баруунсалаа багийн малчин Лхамцэрэнгийн ДАМДИНЖАМЦ;
9. Өмнөговь аймгийн Гурвантэс сумын 1 дүгээр багийн малчин Гунгаагийн ОД;
10. Хэнтий аймгийн Өмнөдэлгэр сумын 5 дугаар багийн малчин Гомбын СҮХ-ОЧИР.

Засгийн газрын 1996 оны 26 дугаар
тогтоолын 2 дугаар хавсралт

УЛСЫН ТЭРГҮҮНИЙ ТАРИАЛАНЧААР:

1. Сэлэнгэ аймгийн Шаамар сумын Дэлгэрхааны 1 дүгээр багийн ногоочин Шушаагийн ЦАГААНБУЛАГ;
2. Улаанбаатар хотын "Дэвшил" хувьцаат компанийн ногоочин Суйдааны АМАРЖАРГАЛ;
3. Төв аймгийн Цээл сумын "Залуучууд" хувьцаат компанийн тракторчин-хадланч Хасын БАТЖАРГАЛ;
4. Сэлэнгэ аймгийн Цагааннуур сумын "Товхонхаан" хувьцаат компанийн комбайнч Болдын БАТ-ЭРДЭНЭ;
5. Булган аймгийн Сэлэнгэ сумын "Ингэттолгой" хувьцаат компанийн тракторч Даваасүрэнгийн ОЮУНБАТ.

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ТОГТООЛ**

1996 оны 2 дугаар
сарын 12-ны өдөр

Дугаар 27

Улаанбаатар
хот

**Иргэний хамгаалалтын улсын
хяналтын дүрэм батлах тухай**

Монгол Улсын Засгийн газраас **ТОГТООХ** нь:
"Иргэний хамгаалалтын улсын хяналтын дүрэм"-ийг хавсралтын
босоор баталсугай.

Монгол Улсын Ерөнхий сайд

П. ЖАСРАЙ

Батлан хамгаалахын сайд

Ш. ЖАДАМБАА

Засгийн газрын 1996 оны 27
дугаар тогтоолын хавсралт

**ИРГЭНИЙ ХАМГААЛАЛТЫН УЛСЫН
ХЯНАЛТЫН ДҮРЭМ**

НЭГ. Нийтлэг үндэслэл

1. Иргэний хамгаалалтын улсын хяналтын зорилго нь байгуулла-
гаа, аж ахуйн нэгж, иргэдээс иргэний хамгаалалтын тухай хууль
тогтоомж, тэдгээрийг үндэслэн төрийн захиргааны эрх бүхий бай-
гуудлагаас гаргасан шийдвэрийн биелэлтийг хангуулахад оршино.

2. Хяналтыг улсын иргэний хамгаалалтын газарт мэргэжлийн
ажилтнууд нь хавсран ажиллах үндсэн дээр байгуулагдсан хяналтын
алба, иргэний хамгаалалтын улсын албад болж зохион байгуулагдсан
там, тусгай газарт болон аймаг, нийслэлд дээрх зарчмаар ажиллах
улсын байцаагчид хэрэгжүүлнэ.

3. Иргэний хамгаалалтын улсын хяналтын албаны дарга нь ул-
сын ерөнхий байцаагч байна. Иргэний хамгаалалтын улсын ерөнхий
байцаагчийг батлан хамгаалах асуудал эрхэлсэн сайд томилж, чөлөө-
лөх ба ерөнхий байцаагчийн эрхийг Засгийн газар олгоно.

4. Хяналтын албаны ахлах байцаагч, улсын байцаагчийг ерөнхий
байцаагчийн санал болгосноор батлан хамгаалах асуудал эрхэлсэн
айд томилж, чөлөөлөн байцаагчийн эрх олгоно.

5. Аймаг, нийслэлд ажиллах улсын байцаагчийг аймаг, нийслэлийн Засаг дарга, улсын албанд ажиллах байцаагчийг албаны дарга нар томилж, чөлөөлөх бөгөөд улсын байцаагчийн эрхийг иргэний хамгаалалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга олгоно.

6. Ажил төрлийн онцлогоос шалтгаалан иргэний хамгаалалтын албад болж зохион байгуулагдаагүй зарим яам, тусгай газар иргэний хамгаалалтын улсын байцаагч ажиллуулж болно.

Дээрх яам, тусгай газарт ажиллах иргэний хамгаалалтын улсын байцаагчийг сайд, тусгай газрын дарга нар нь томилж, чөлөөлөх бөгөөд байцаагчийн эрхийг нь иргэний хамгаалалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга олгоно.

7. Иргэний хамгаалалтын улсын ерөнхий байцаагч, улсын ахлах байцаагч, улсын байцаагч /энэ дүрэмд "байцаагч" гэх/ нь тухайн асуудлаар мэргэшсэн байна.

8. Хяналтын алба, улсын байцаагчид нь үйл ажиллагаандаа Монгол Улсын холбогдох хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр болон энэхүү дүрмийг удирдлага болгоно.

9. Улсын байцаагч нь Засгийн газраас загварыг нь баталсан үнэмлэх, хувийн дугаар бүхий тэмдэг болон албан шаардлага, дүгнэлт, акт, торгуулийн хэатэмэл хуудас хэрэглэнэ.

10. Аймаг, нийслэл, бусад байгууллагад ажиллаж байгаа улсын байцаагчдыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, ажлыг нь шалгах, шалгалтын дүнг нэгтгэн дүгнэлт гаргах, шаардлагатай асуудлаар авах арга хэмжээний санал боловсруулж, шийдвэрлүүлэхийг Иргэний хамгаалалтын улсын хяналтын алба хариуцан хэрэгжүүлнэ.

ХОЕР. Иргэний хамгаалалтын улсын хяналт явуулах чиглэл

11. Иргэний хамгаалалтын улсын хяналтыг доорхи чиглэлээр хэрэгжүүлнэ:

а/ иргэний хамгаалалтын тухай хууль тогтоомжид нийцүүлэн, иргэний хамгаалалтын асуудлаар гаргасан дээд шатны иргэний хамгаалалтын даргын шийдвэрийн хэрэгжилт,

б/ хөнөөх хэрэгсэл, гамшиг, ослын шинж байдал, учирч болзошгүй хохирлын хэмжээг тодорхойлох, тэдгээрийн аюулаас хамгаалах, аврах ажил явуулах арга хэмжээний төлөвлөлт, зохион байгуулалт, хэрэгжилт;

в/ хөнөөх хэрэгсэл, гамшиг, ослын хөнөөлийн үед иргэний хамгаалалтын зарлан мэдээллийн дохиог холбоо мэдээллийн бай-

гуудлага өмчийн хэлбэрээс үл хамгаран үнэ төлбөргүй, саадгүй дамжуулах бэлтгэл;

г/ нутаг дэвсгэр, үйлдвэрлэл, үйл ажиллагааны онцлогт тохирсон иргэний хамгаалалтын штаб, алба, мэргэжлийн ангийн зохион байгуулалт, сургалт, тэдгээрийн бэлэн байдал;

д/ хөнөөх хэрэгсэл, гамшиг, ослын аюулаас урьдчилан сэргийлэх, хамгаалах арга ажиллагаанд удирдах албан тушаалтан, ажилтан, иргэдийн сургалтын зохион байгуулалт, хэрэгжилт;

е/ хот, тосгон байгуулах, барилга байгууламж барих, өргөтгөх, шинэчлэх зураг төсөлд тавигдах иргэний хамгаалалтын шаардлагын мөрдөлт;

ж/ өмчийн бүх төрөлд хамрагдах аж ахуйн нэгж, байгууллагын мээхдд байгаа иргэний хамгаалалтын багтаж, хамгаалах хэрэгслийн ашиглалт, хадгалалтын журмын биелэлт;

з/ хөнөөх хэрэгсэл, гамшиг, ослоос үүссэн хөнөөлийн голомтод аврах ажил гүйцэтгэхэд иргэний хамгаалалтын мэргэжлийн ангиас гадна албан тушаалтан, иргэн, шаардлагатай материал, техник, багаж, хэрэгслийг холбогдох хууль тогтоомжийн дагуу татан оролцуулах ажлын бэлтгэл, хэрэгжүүлэлт;

и/ хөнөөх хэрэгсэл, гамшиг, ослын аюулаас урьдчилан сэргийлэх, хамгаалах, учирсан хор уршгийг арилгахад шаарглах хөрөнгийн эх үүсвэр гаргах, материал, техник, багаж, бусад хэрэгслийн нөөц бүрдүүлэх, нөхөн сэлбэх талаар авсан арга хэмжээний биелэлт;

к/ гамшиг, осол тохиолдсон нөхцөлд хөнөөлийн голомтод аврах, хойшдуулишгүй сэргээн босгох ажиллагааг явуулах шийдвэр гаргах болон шаардлагатай байгууллага, аж ахуйн нэгжийг онцгой дэглэмд шилжүүлэх бэлтгэл;

л/ хөнөөх хэрэгсэл, гамшиг, ослын аюулаас урьдчилан сэргийлэх, хамгаалах аврах, учирсан хор уршгийг арилгах зохион байгуулалттай сургалтад иргэдийн оролцсон байдал;

м/ хөнөөлийн голомтод нэрвэгдсэн хүмүүст туслэх, өртөгдсөн эд хөрөнгийг аврах, хамгаалах ажилд оролцох талаар иргэний үүргийн биелэлт;

н/ хөнөөх хэрэгсэл, гамшиг, ослын аюул учирсан нөхцөлд нийтээр дагаж мөрдүүтэхээр тогтоосон журмын биелэлт;

о/ иргэний хамгаалалтын эрх бүхий байгууллага, албан тушаалтны хууль тогтоомжид нийцүүлэн гаргасан шийдвэрийг иргэн сэрхэн биелүүлдэг байгаа байдал.

ГУРАВ. Иргэний хамгаалалтын улсын байцаагчийн үүрэг, эрх

12. Улсын байцаагч нь дор дурдсан үүрэг хүлээнэ:

а/ энэ дүрмийн 11 дүгээр зүйлд заасан чиглэлээр хяналтыг зохион байгуулж явуулах;

б/ илрүүлсэн зөрчлийг таслан зогсоох, арилгах арга хэмжээ авахдаа байгууллага, аж ахуйн нэгж, иргэний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх;

в/ аж ахуйн нэгж, байгууллагын үйлдвэрлэл, технологийн нууцыг чанд хадгалах;

г/ хууль тогтоомжийг чанд сахих, хөндлөнгийн нөлөөнд үл антах, албан үүргээ үнэнчээр гүйцэтгэх;

д/ хийсэн шалгалт, гаргасан дүгнэлт, бичсэн танилцуулга, албан шаардлага, тоо баримтын үндэслэл, нотолгооны үнэн зөвийг бүрэн хариуцах.

13. Байцаагч нь дор дурдсан эрх эдэлнэ:

а/ хөнөөх хэрэгсэл, гамшиг, ослын аюулаас урьдчилан сэргийлэх, хамгаалах, учирсан хор уршгийг арилгахтай холбогдсон асуудлаар хяналт явуулах зорилгоор аж ахуйн нэгж, байгууллагад шаардлагатай үедээ саадгүй нэвтрэх;

б/ хяналт, шалгалтын ажилд шаардлагатай мэдээ, судалгаа, тайлбар, тодорхойлолт, бусад баримт бичгийг холбогдох байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтнаас үнэ төлбөргүй гаргуулан авах, шинжилгээ хийлгэх;

в/ гамшиг, ослын нөхцөл, шалтгаан, тэдгээрт холбогдох гэм буруутай этгээдийг тогтоох зорилгоор иргэдээс тайлбар гаргуулж авах;

г/ гамшиг, осол тохиолдож байгаагүй нь тодорхой болсон ба тохиолдсон үед иргэн, байгууллага, аж ахуйн нэгжийн холбооны болон тээврийн хэрэгслийг дараалал харгалзахгүй ашиглаж хэлсийг зохих журмын дагуу төлөх;

д/ хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд шууд ба шууд бусаар хор хохирол учруулж байгаа буюу учруулж болох нь зохих ёсоор нотлогдсон, түүнчлэн гамшиг, осол аюул гарч болох тохиолдолд холбогдох ажил, үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагааг бүхэлд нь буюу хэсэгчлэн уг зөрчлийг арилгах хүртэл түр зогсоох, шаардлагатай зүйлийг ариутгах, хоргүйжүүлэн цэвэршүүлэх, тухайн барилга байгууламж, машин, тоног төхөөрөмжийн ашиглалтыг зогсоох, холбогдох бүтээгдэхүүнийг худалдах, борлуулахыг хориглох, устгах буюу зохих шаардлагад харшлахгүй бол өөр зориулалтаар ашиглах шийдвэр гаргах, энэ тухай олон нийтэд зарлан мэдээлэх.

Энэ шийдвэрийг биелүүлээгүй тохиолдолд хуульд өөрөөр заагаагүй бол тухайн үйлдвэрлэл, үйлчилгээг бүрмөсөн зогсоох тухай шийдвэр гаргах;

е/ холбогдох байгууллагатай нь тохиролцсон зохих мэргэжлийн хүмүүсийг иргэний хамгаалалтын хяналт шалгалтын ажилд татан оролцуулах, шаардлагатай асуудлыг магадлах зорилгоор лабораторийн буюу магадлан шинжилгээг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх;

ж/ ноцтой гамшиг, осол гарсан, хүний амь нас, эрүүл мэнд хохирсон, их хэмжээний хохирол учирсан, илэрсэн зөрчил нь гэмт хэргийн шинжтэй бол шалгалтын акт, холбогдох баримт бичгийг эрх бүхий байгууллагад шилжүүлэх.

14. Байцаагч нь хууль тогтоомж, дүрэм, журам зөрчсөн, илэрсэн зөрчлийг арилгуулах талаар тавьсан шаардлага биелүүлээгүй гэм буруутай этгээдэд Төрийн хяналт шалгалтын тухай, Иргэний хамгаалалтын тухай, Захиргааны хариуцлагын тухай хуулиуд болон холбогдох бусад хууль тогтоомжийн заалтыг үндэслэн дор дурдсан захиргааны шийтгэл ногдуулна:

а/ энэ дүрмийн 11 дүгээр зүйлийн "а, г, д, е" заалтуудыг зөрчсөн иргэний хамгаалалтын албан тушаалтныг эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол 10000-50000 төгрөгөөр торгох;

б/ энэ дүрмийн 11 дүгээр зүйлийн "в" заалтыг зөрчсөн холбоо мэдээллийн байгууллага, аж ахуйн нэгжийг 50000-75000, албан тушаалтныг 10000-25000, иргэнийг 5000-20000 төгрөгөөр торгох;

в/ 11 дүгээр зүйлийн "д, м, н, о" заалтыг зөрчсөн иргэнийг 30000 хүртэл төгрөгөөр торгох;

г/ улсын ерөнхий болон ахлах байцаагч нар хяналт шалгалтаас зайлсхийсэн албан тушаалтныг 5000-10000, шаардлагатай гэж эсэн баримт бичгийг танилцуулах, түр хугацаагаар хүлээлгэн өгөөс зайлсхийсэн албан тушаалтныг 15000 хүртэл төгрөгөөр торгох;

д/ хяналтын алба, улсын байцаагчийн албан шаардлагыг эсэргүүцсэн, тогтоосон хугацаанд биелүүлээгүй, шаардлагын биелэлтийг аргаж ирүүлээгүй албан тушаалтныг 5000-25000, хянан шалгах үйлжиллагаанд саад учруулсан, гаргах дүгнэлт, шийдвэрт нөлөөлөхийг ролдсон этгээдийг 35000 хүртэл, хяналт шалгалтын холбогдолтой аримт бичгийг гаргаж өгөхөөс үндэслэлгүйгээр татгалзсан, гэмтээн, устгасан, хуурамч бичиг баримт гаргаж өгсөн албан тушаалтныг 0000-50000 төгрөгөөр торгуулах асуудлыг шүүгчид тавьж шийдвэрүүлэх.

ДӨРӨВ. Бусад зүйл

15. Иргэний хамгаалалтын улсын хяналтын алба, байцаагчийн шийдвэрийг байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтан, иргэд, хугацаанд нь биелүүлж, хариуг албан ёсоор өгч байх үүрэгтэй.

16. Зөрчил гаргасан этгээд түүнд ногдуулсан торгууль, нөхөн төлбөрийг тогтоосон хугацаанд нь улсын төсвийн орлогод оруулна.

Торгууль, нөхөн төлбөрийг буруутай тал 15 хоногийн дотор төлөөгүй бол холбогдох хууль, тогтоомжийн дагуу шүүхээр шийдвэрлүүлнэ.

17. Шалгагдсан байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтан, иргэд хяналт шалгалтын явцад хууль тогтоомж зөрчигдсөн, байцаагчийн гаргасан шийдвэр үндэслэлгүй гэж үзвэл гомдлоо хяналт шалгалт хийсэн байгууллагын эрх баригчид шийдвэрийг хүлээн авсан өдрөөс хойш 10 хоногт багтаан гаргана.

Гомдлыг хүлээн авсан байгууллагын эрх баригч түүнийг хүлээн авсан өдрөөс хойш 30 хоногт багтаан хянан шийдвэрлэнэ. Хэрэв энэ шийдвэрийг эс зөвшөөрвөл шүүхэд гомдол гаргаж болно.

18. Иргэний хамгаалалтын улсын байцаагч энэ дүрмээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй болон хууль тогтоомж зөрчсөн бол холбогдох хууль тогтоомжийн дагуу зохих хариуцлага хүлээнэ.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1996 оны 2 дугаар
сарын 23-ны өдөр

Дугаар 38

Улаанбаатар
хот

Журам батлах тухай

"Бага дунд боловсролын тухай Монгол Улсын хууль"-ийн 24 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг, "Дээд боловсролын тухай Монгол Улсын хууль"-ийн 15 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас **ТОГТООХ** нь:

1. "Багшлах эрх, мэргэжлийн зэрэг олгох, хасах тухай журам"-ы хавсралтын ёсоор баталсугай.

2. Ерөнхий боловсролын сургуулийг ойрын таван жилд багтаан мэргэжлийн багшаар хангах арга хэмжээ авахын зэрэгцээгээр бүшатны сургуульд багшилж байгаа багшийн мэргэжил эзэмшээгүй иргэнийг 1996-1998 онд сурган хүмүүжүүлэх боловсрол олгох сургал

гад хамруулах арга хэмжээ авахыг Шинжлэх ухаан, боловсролын
ам /С. ТӨМӨР-ОЧИР/-д даалгасутай.

Монгол Улсын Ерөнхий сайд
Шинжлэх ухаан, боловсролын сайд

П. ЖАСРАЙ
С. ТӨМӨР-ОЧИР

Засгийн газрын 1996 оны 38 дугаар
тогтоолын хавсралт

БАГШЛАХ ЭРХ, МЭРГЭЖЛИЙН ЗЭРЭГ ОЛГОХ, ХАСАХ ТУХАЙ ЖУРАМ

НЭГ. Нийтлэг үндэслэл

1. Энэхүү журмыг хүүхдийн цэцэрлэг, ерөнхий боловсрол, тех-
никийн болон мэргэжлийн сургууль, их, дээд сургууль, коллежийн
агшинд багшлах эрх, мэргэжлийн зэрэг олгох, хасахад дагхж мөр-
өнгө.

2. Хүүхдийн цэцэрлэг, ерөнхий боловсрол, техникийн болон
мэргэжлийн дунд сургуульд зохих диплом буюу бакалаврын зэрэг-
эй; их, дээд сургууль, коллеж /үндсэн мэргэжлийн хичээлийг/-д
агистралас доошгүй зэрэгтэй багшийг ажиллуулна.

ХОЁР. Багшлах эрх олгох, хасах

3. Багш бэлтгэдэг төрийн болон төрийн бус өмчийн их, дээд
сургууль, коллеж /цаашид "багш бэлтгэдэг сургууль" гэнэ/ төгсөгчид
агшлах эрхийн үнэмлэхийг дипломын хавсралт болгож олгоно.

4. Багшаас өөр мэргэжлийн сургууль төгсөгчийг сурган хүмүү-
жүүлэх боловсрол олгох сургалтад хамруулсны дараа багшлах эрх
олгоно.

5. Онцгой аяваас, ур чадвар шаардагдах мэргэжлийг шавь сургал-
зар өвлүүлэн эзэмшүүлэх зорилгоор онцгой аяваас, ур чадвартан
боловсролыг нь харгалзахгүйгээр/-ыг сурган хүмүүжүүлэх боловсрол
олгох сургалтад хамруулсны дараа их, дээд сургууль, коллеж, техни-
кийн болон мэргэжлийн сургуульд багшлах эрх олгож болно.

6. Ерөнхий боловсролын сургуульд багш дутагдсан нөхцөлд багш-
ах сонирхолтой бөгөөд 10 дугаар ангийг онц дүнтэй төгсөгчийг
энгөн шалгаруулж сурган хүмүүжүүлэх боловсрол олгох сургалтад
амруулан багшлах эрх олгосны дараа гэрээгээр багшлуулж болно.

Гэрээнд түүний багшлах хугацааг тусгана. Гэрээний хугацаа дуусмагц багшлах эрх нь хүчингүй болно.

7. "Багшлах эрхийн үнэмлэх"-ийн загварыг боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага батална.

8. Сурган хүмүүжүүлэх боловсрол олгох сургалт нь өдрийн, оройн, эчнээ, экстернат хэлбэртэй байна.

9. Боловсролын түвшин, мэргэжлийн онцлогоос нь шалтгаалан багшийн мэргэжил эзэмшээгүй иргэнд сурган хүмүүжүүлэх боловсрол олгох орой, өдрийн сургалтыг дараахь хугацаагаар явуулна:

а/ их, дээд сургууль, коллеж, техникийн болон мэргэжлийн сургуульд багшлах дээд боловсролтой иргэнд багшлах эрх олгох сургалт 1,5 сар;

б/ техникийн болон мэргэжлийн сургуульд багшлах тусгай дунд боловсролтой иргэнд багшлах эрх олгох сургалт 3 сар;

в/ онцгой авьяас, ур чадвар шаардагдах мэргэжлийг шавилан сургах замаар өвлүүлэн эзэмшүүлэх зорилгоор багшлах бүрэн дунд болон түүнээс доош боловсролтой иргэнд багшлах эрх олгох сургалт 4 сар;

г/ 10 дугаар анги онц дүнтэй төгсөгчдөөс шалгарсан иргэнд багшлах эрх олгох сургалт 6 сар.

10. Сурган хүмүүжүүлэх боловсрол олгох эчнээ сургалтын хугацааг сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөртэй нь уялдуулан боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага тогтооно.

11. Сурган хүмүүжүүлэх боловсрол олгох сургалт явуулах зөвшөөрлийг боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага олгоно.

12. Сурган хүмүүжүүлэх боловсрол олгох сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөрийг тухайн сургуулиас сургалтын хэлбэртэй уялдуулан боловсруулж боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрлийг үндэслэн сургуулийн захирал батална.

13. Боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаас зохих журмын дагуу олгосон зөвшөөрлийг үндэслэн багш бэлтгэдэг их, дээд сургууль, коллеж сурган хүмүүжүүлэх боловсрол олгох сургалтыг зохих төлбөртэйгээр зохион байгуулна. Төлбөрийн жишгийг боловсролын болон санхүүгийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага зөвшилцөн тогтооно.

14. Сурган хүмүүжүүлэх боловсрол олгох сургалтыг суралцагчдын тооноос хамааруулан зохион байгуулах бөгөөд захиалгыг дор дурдсанаар хийнэ:

а/ ерөнхий боловсрол, техникийн болон мэргэжлийн сургуулийн сурган хүмүүжүүлэх зөвлөлийн дүгнэлт, саналыг үндэслэн тухайн сум, дүүргийн Засаг дарга;

б/ их, дээд сургуулийн эрдмийн зөвлөлийн дүгнэлт, саналыг үндэслэн тухайн сургуулийн захирал;

в/ коллежийн сургалт арга зүйн зөвлөлийн дүгнэлт, саналыг үндэслэн тухайн коллежийн захирал.

15. Хүүхдийн цэцэрлэг, ерөнхий боловсрол, техникийн болон мэргэжлийн сургуулийн удирдах зөвлөлийн тодорхойлолт, сумын засаг дарга, дүүргийн Засаг даргын Тамгын газрын дүгнэлт, саналыг үндэслэн аймаг, дүүргийн Засаг дарга, эрдмийн болон сургалт аргын зөвлөлийн дүгнэлт саналыг үндэслэн тухайн их, дээд сургууль, коллежийн захирал дараахь тохиолдолд багшлах эрхийг тус тус эснэ:

а/ түвшин тогтоох шалгалтаар сургалтыг онол-арга зүйн зохих түвшинд явуулах чадваргүй болох нь тогтоогдсон;

б/ төр, засгийн эсрэг үйл ажиллагаа явуулах, төрийн нууцыг алдах, хар тамхи, мансууруулах бодис хэрэглэх, садар самуунд оролцох, хүчирхийлэх зэргээр гэмт хэрэг үйлдсэн, тэдгээрт ралцагчийг албадан оруулж багшийн ёс зүйн хэм хэмжээг ноцтой рчин хууль тогтоомжийг гажуудуулсан;

в/ боловсролын баримт бичгийг санаатайгаар хуурамчаар үлдсэн, түүнчлэн суралцагчийн мэдлэг, чадвар, даллыг буруу гэлсний улмаас хөдөлмөрийн хуулийн дагуу сахилгын шийтгэлийг ит дараалан оногдуулсан боловч дээрх дутагдал давтагдсан;

г/ хариуцлагагүйн улмаас хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажилгааны норм, хэм хэмжээг зөрчиж суралцагчийн бие эрхтэнд ноцй гэмтэл учруулсан.

16. Багшлах эрхийг хасах талаар эрх бүхий байгууллагаас гаргана шийдвэрийг эс зөвшөөрвөл тухайн иргэн гомдлоо шүүхэд гана.

17. Багшийн эрхийг хассан байгууллага шийдвэрээ хүчингүй болс замаар багшлах эрхийг сэргээж болно.

ГУРАВ. Багшийн мэргэжлийн зэрэг олгох, хасах

18. Багшийн мэргэжлийн зэрэг нь түүний оюуны чадаахи, мэргэжлийн түвшин, ур чадвар, бүтээлч сэтгэлгээ, онол, заах аргын дэргийн дээшлэлтийг үнэлэх шалгуур мөн.

19. Багшид энэ журамд заасан болзол, шалгуурыг үндэслэн зөвх багш, тэргүүлэх багш, заах аргач багш гэсэн зэрэг олгоно.

20. Хүүхдийн цэцэрлэг, ерөнхий боловсрол, техникийн болон мэргэжлийн сургуулийн багшид мэргэжлийн зэрэг олгоход дараах болол, шалгуур үзүүлэлтийг үндэс болгоно:

а/ зөвлөх багш:

-сурган хүмүүжүүлэх судалгааны ажил хийх, удирдах, төлөвлөх гүйцэтгэх чадвар сайтай, өөрийн болон бусад сургууль, цэцэрлэгийн багш нарт мэргэжлийн ба арга зүйн зөвлөлгөө өгөх, сургалт явуулах түвшинд хүрсэн, сурах бичиг, гарын авлага, зөвлөмж бичсэн, сурган хүмүүжүүлэх уншлагад улсад шалгарч байсан;

-үйл ажиллагаа, ажлын түвшингийн хувьд үлгэр жишээч, "Тэр гүүлэх багш"-ийн зэрэг аваад 5-аас доошгүй жил ажилласан;

-заадаг хичээлийн хувьд агуулга, арга зүй, үнэлгээний стандарт хангасан буюу сүүлийн хичээлийн жил, улирлынхаас сурагчдын сурлагын амжилт, онц ба сайны эзлэх хувь нь "Магадлан шалгах комисс"-ын мэдлэгийн түвшин тогтоох шалгалтын үнэлгээгээр 10-аас илүү хувиар буураагүй байх;

-уламжлалт олимпиад, уралдаан тэмцээнд багш өөрөө болон бэлтгэсэн шавь нь улсад эхний гурван байрт шалгарсан байх;

-багшийн ёс зүйн хэм хэмжээг сахдаг байх.

б/ тэргүүлэх багш:

-ерөнхий боловсрол, техникийн болон мэргэжлийн сургуулийн багшийн хувьд ажиллах хугацаандаа 3-аас доошгүй багшийг дадлага жуулан "Заах аргач багш" бэлтгэсэн, хамт олондоо ажил мэргэжлээрээ нөлөөлөх чадвартай болсон, арга туршлага нь нийтэд сурталчлагдсан, заах аргын нэгдлийг 3-аас доошгүй жил удирдсан байх.

-цэцэрлэгийн багшийн хувьд нэг багшийг дадлагжуулан "Заах аргач багш"-аар бэлтгэсэн, заах аргын нэгдлийн ажилд тэргүүлэх үүрэгтэйгээр оролцдог байх,

-үйл ажиллагаа, ажлын түвшингийн хувьд тэргүүний болон сайн ажиллаж байгаа багшийн үнэлгээ авсан, "Заах аргач багш"-ийн зэрэг аваад 3-аас доошгүй жил ажилласан байх;

-уламжлалт олимпиад, уралдаан тэмцээнд багш өөрөө болон бэлтгэсэн шавь нар нь сум, дүүрэгтээ эхний гурван байранд шалгардаг байх;

-заадаг хичээлийн агуулга, арга зүй, үнэлгээний стандартыг хангасан буюу сүүлийн хичээлийн жил, улирлынхаас сурагчдын сурлагын амжилт, онц ба сайны эзлэх хувь нь "Магадлан шалгах комисс"-ын үнэлгээгээр 10-аас илүү хувиар буураагүй байх;

-багшийн ёс зүйн хэм хэмжээг сахдаг байх.

в/ заах аргач багш:

-өөрийн гэсэн заах арга эзэмшиж, заах аргын нэгдлийн багш нартаа ажил мэргэжлээрээ нөлөөлөх чадвартай болсон байх;

-үйл ажиллагаа, ажлын түвшингийн хувьд тэргүүний ба сайн түвшинд ажиллаж байгаа багшийн үнэлгээ яваад 3-аас доошгүй жил ажилласан байх;

-заадаг хичээлийн хувьд агуулга, арга зүй, үнэлгээний стандарт хангасан буюу сүүлийн хичээлийн жил, удирлынхаас "Магадлан шалгах комисс"-ын мэдлэгийн түвшин тогтоох шалгалтын үнэлгээгээр сурагчдын сурлагын амжилт, онц ба сайны эзлэх хувь 10-аас дүү хувиар буураагүй байх;

г/уламжлалт олимпиад, уралдаан тэмцээнд багш өөрөө болон бэлтгэсэн шавь нь амжилттай оролцдог байх;

д/багшийн ёс зүйн хэм хэмжээг сахидгай байх.

21. Их, дээд сургууль, коллежийн багшид зэрэг олгоход дараахь болзол, шалгуур үзүүлэлтийг үнэлэс болгоно:

а/ зөвлөх багш:

-их, дээд сургууль, коллежид 15-аас доошгүй жил багшилсан;

-бүтээл нь гадаад, дотоодод хэвлэгдсэн;

-их, дээд сургууль, коллежийн сурах бичиг, гарын аалага, хичээлийн хэрэглэгдэхүүн 2-оос доошгүйг сүүлийн таван жилд хэвлүүлсэн;

-шавь сургалтаар магистраас дээш зэрэгтэй боловсон хүчин бэлтгэсэн;

-судалгаа шинжилгээний үр дүн нь сургалтад, эсвэл үйлдвэртэд нэгтгэсэн нь зохих ёсоор багцагдсан байх;

-магистрант, аспирантын ажлын удирдагч, зөвлөхөөр тогтмол ажилладаг;

-бусдад үлгэр жишээч, тэргүүний багш байх.

б/ тэргүүлэх багш:

-их, дээд сургууль, коллежид 10-аас доошгүй жил багшилсан;

-их, дээд сургууль, коллежийн сурах бичиг, гарын аалага 2-оос доошгүйг сүүлийн таван жилд хэвлүүлсэн;

-шавь сургалтаар магистр бэлтгэсэн;

-магистрант, аспирантын ажлын удирдагч, зөвлөхөөр тогтмол ажилладаг;

-бусдад үлгэр жишээч, тэргүүний багш байх.

в/ заах аргач багш:

-их, дээд сургууль, коллежид 5-аас доошгүй жил багшилсан;

-диплом, бакалавр, магистрын ажлын удирдагч буюу зөвлөхөөр тогтмол ажилладаг;

-тодорхой чиглэлээр судалгаа шинжилгээний ажил хийж үү дүн нь нийтлэгдсэн, эсвэл үйлдвэрлэлд нэвтэрсэн байх;

-оюутны судалгаа шинжилгээний ажил удирддаг, тэдний бүтээл нь сүүлийн 2 жилд улсад болон сургуульдаа байр эзэлсэн;

-их, дээд сургууль, коллежийн заах арга зүйг эзэмшсэн;

-өөрийн хариуцан заадаг хичээлээр кабинет, лаборатори байгуулсан буюу тохижуулсан, энэ талаар эрх бүхий байгууллагаас гэрчилгээ авсан байх;

-сургалтдаа компьютер зэрэг орчин үеийн техник хэрэгсэл ашиглаж тодорхой үр дүнд хүрсэн байх;

-заадаг хичээлээрээ сүүлийн 5 жилд аргачлал, зөвлөмж 2-оос доошгүйг боловсруулан гаргасан, сургалтдаа хэрэглэдэг байх;

-гадаад хэлний мэдлэгийг зохих түвшинд эзэмшсэн байх;

-бусдад үлгэр жишээч, тэргүүний багш байх.

22. Сургалтын онцлог, тавих шаардлагатай нь уялдуулан боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаас тухайн их, дээд сургууль, коллежийн зөвлөх багш, тэргүүлэх багш арга зүйч багшийн мэргэжлийн зэрэг олгоход баримтлах нэмэлт болзол, шалгуурыг тогтоож болно.

23. Энэ журмын 20,21 дүгээр зүйлд заасан болон мөн журмын 21 дугаар зүйлийг үндэслэн боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаас тогтоосон нэмэлт болзол, шалгуурын нөхцөлийг бүрэн хангасан багш мэргэжлийн зэрэг олгох шалгалтаг орж болно.

24. Багшийн мэргэжлийн зэрэг хамгаалуулах шалгалтыг 5 жилд нэг удаа хийнэ.

25. Багшид мэргэжлийн зэрэг олгох, мэргэжлийн зэргийг хамгаалуулах шалгалтыг дараахь байдлаар зохион байгуулна:

а/ хүүхдийн цэцэрлэг, ерөнхий боловсрол, техникийн боловсролын мэргэжлийн сургуулийн багшийн мэргэжлийн зэргийн шалгалтыг аймаг, дүүргийн нийгмийн бодлогын хэлтэс /Боловсролын асуудал хариуцсан алба /-ийн ажилтан боловсролын мэргэжлийн хяналтын албаны улсын байцаагч, боловсролын төвийн ажилтан, тэргүүний багш нарын бүрэлдэхүүнтэйгээр багшийн мэргэжлийн зэрэг олгох хамгаалуулах ажлыг эрхлэн явуулах аймаг дүүргийн Засаг даргын захирамжаар байгуулсан комисс, их, дээд сургууль, коллежийн багшийн мэргэжлийн шалгалтыг боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын шийдвэрээр байгуулсан комисс тус тус авна;

б/ комисс нь багшийн мэргэжлийн зэрэг олгох, хамгаалуулах шалгалт авахдаа сум, дүүргийн мэргэжлийн шалгаруулалтын комисс,

тухайн сургуулийн удирдах зөвлөлтэй хамтран энэхүү журамд заасан болзол, шалгуурыг хангасан эсэхийг харгалзан багшийн ажлын түвшин тогтоосон материал, тухайн сургуулийн сурган хүмүүжүүлэх болон эрдмийн зөвлөл, сургалт арга зүйн зөвлөлөөр хэлэлцэж гаргасан дүгнэлт, саналтай танилцаж, шалгалтыг тестийн хэлбэрээр авч дүнг сургуулийн сурган хүмүүжүүлэх хамт олны хуралд танилцуулан саналыг нэгтгэн энэ тухай тэмдэглэл хөтөлнө;

в/ комиссын шалгалтын дүн, хамт олны хурлын шийдвэрийг үндэслэн тухайн сургуулийн захирал багш нарт мэргэжлийн зэрэг олгох тухай тушаал гаргана;

г/ 50-иаас дээш насны багш нар болон 20-иос дээш жил багшилсан багш мэргэжлийн зэргээ 2 удаа давтан хамгаалсан бол шалгалтаас чөлөөлөгдөж, 5 жил тутам тайлан хамгаалалт хийнэ. Энэ ажлыг сургууль, аймаг, нийслэлийн боловсролын төв хамтран зохион байгуулна.

26. Дараахь тохиолдолд багшийн мэргэжлийн зэргийг хүчингүйд гооцно:

а/ мэргэжлийн ноцтой алдаа гаргасан;

б/ мэргэжлийн зэрэг хамгаалах шалгалтад хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хугацаандаа ороогүй;

в/ мэргэжлийн зэргээ хамгаалж чадаагүй.

Хүндэтгэн үзэх шалтгаанаар зэрэг хамгаалах шалгалтад хугацаандаа ороогүй багшийн мэргэжлийн зэргийг хэвээр үлдээж дахин шалгалтад орж хамгаалах хүртэл нь мэргэжлийн зэргийн нэмэгдэл олгохыг зогсооно.

Мэргэжлийн зэргээ хамгаалж чадаагүй тохиолдолд дараа жил нь мэргэжлийн зэргээ бататгахар хүсэлт гаргаж болно. Хэрэв дахин шалгалтаар зэргээ хамгаалж чадахгүй бол зэргийг нь бууруулах буюу асч болно.

27. Аймаг, нийслэлийн болон боловсролын асуудал хариуцсан өрийн захиргааны төв байгууллагын комиссын үйл ажиллагаа, шалгалтын дүнд боловсролын улсын хяналтын алба хяналт тавина.

28. Аймаг, дүүрэг болон боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага нь багш нарын мэргэжлийн онол, арга үй, эрх зүйн мэдлэгийг шалгах тестийн сантай байх бөгөөд түүнийгээ нууцлан хадгалж байнга баяжуулж байна.

**МОНГОЛ УЛСЫН ДЭЭД
ШҮҮХИЙН ТОГТООЛ**

1996 оны 1 дүгээр
сарын 15-ны өдөр

Дугаар 06

Улаанбаатар
хот

Дээд шүүхийн хуралдааны
дэг батлах тухай

Монгол улсын Дээд шүүхийн хуралдааны үйл ажиллагааг Монгол улсын Үндсэн хууль, хууль тогтоомжийн бусад актад нийцүүлэх зорилгоор Монгол улсын Дээд шүүхээс **ТОГТООХ** нь:

1. "Монгол улсын Дээд шүүхийн хуралдааны дэг"-ийг хавсралтын ёсоор баталсугай.

2. Монгол улсын Дээд шүүхийн хуралдааны дэг батлагдсантай холбогдуулж БНМАУ-ын Дээд шүүхийн Бүгд хурлын 1990 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 91 дүгээр тогтоол болон уг тогтоолоор батлагдсан БНМАУ-ын Дээд шүүхийн Бүгд хурлын дэгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

Ерөнхий шүүгч

Д. ДЭМБЭРЭЛЦЭРЭН

Эрүүгийн хэргийн танхимын
тэргүүн шүүгч

Ч. ГАНБАТ

Монгол Улсын Дээд шүүхийн 1996
оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн
6 дугаар тогтоолоор батлав

**МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН
ХУРАЛДААНЫ ДЭГ**

Нэг. Ерөнхий үндэслэл

1 дүгээр зүйл. Монгол Улсын Дээд шүүхийн хуралдаан нь Монгол Улсын Үндсэн хуульд зааснаар Монгол Улсын Дээд шүүх шүүхийн дээд байгууллага мөн. Улсын Дээд шүүх, ерөнхий шүүгч танхимын тэргүүн шүүгч, шүүгчдээс бүрэлх бөгөөд үйл ажиллагаагаа хуралдааны хэлбэрээр явуулж, хэрэг маргааныг хамтын журмаар хянан хэлэлцэж олонхийн саналаар шийдвэрлэнэ.

2 дугаар зүйл. Дээд шүүхийн хуралдааны зорилт нь Монгол Улсын хуулийг дээдлэн, түүнийг нэг мөр ойлгон хэрэглэх, шүүн таслах ажилдагданы нэгдсэн бодлого боловсруулж хэрэгжүүлэх явдлыг хангах эрх зүйт төрийг төлөвшүүлэх, шүүхийн засаглалыг бэхжүүлж хөгжүүлэхэд тус дөхөм үзүүлэхэд оршино.

3 дугаар зүйл. Дээд шүүхийн хуралдаан асуудлыг хамтын журмаар, ажил хэрэгчээр тал бүрээс нь чөлөөтэй хэлэлцэн Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуулийн заалтад нарийн чанд нийцүүлэн эрх зүйн онолын сэтгэлгээг тусган, үнэнийг тогтоон шийдвэрлэх зарчмыг удирдлага болгоно.

4 дүгээр зүйл. Дээд шүүхийн хуралдааныг товлон зарлах, бэлтгэлийг хангах, асуудлыг хянан хэлэлцэх, санал хураах, шийдвэр гаргах, уг шийдвэрийг биелүүлэх журмыг Монгол Улсын үндсэн хууль, Шүүхийн тухай хууль, Эрүүгийн байцаан шийтгэх хууль, Иргэний сэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль бусад хууль энэ дэгээр гадархайлно.

Хоёр. Дээд шүүхийн хуралдааны бүрэлдэхүүн,
бүрэн эрх

5 дугаар зүйл. Дээд шүүхийн хуралдаанд ерөнхий шүүгч, тэнхимийн тэргүүн шүүгч, шүүгчийн гуравны хоёроос доошгүй нь оролцож байгаа бол хүчинтэйд тооцогдоно.

6 дугаар зүйл. Дээд шүүхийн хуралдаанд Монгол Улсын Ерөнхий прокурор оролцох бөгөөд ерөнхий шүүгчийн урилгаар аймаг, нийслэл, сум бузуу сум дундын, дүүргийн шүүхийн ерөнхий шүүгчид, шүүгчид, иргэдийн төлөөлөгчид, Монгол Улсын шүүхийн ерөнхий өвлөл, шүүгчийн сахилгын болон мэргэшлийн хорооны гишүүд, амгын гэээр, хэлтсийн ажилтнууд, хэлэлцэж буй асуудлыг боловсруулахад оролцсон ажлын хэсгийн гишүүдийг оролцуулж болно. Гүүнчлэн Дээд шүүхийн хуралдаанд улс, олон нийт, хэвлэл мэдээллийн байгууллага, хөдөлмөрийн хамт олон, хөдөлмөрчдийн төлөөлөгчдийг урьж оролцуулж болно. Тэд хуралдааны дотоод журмыг анд сахих үүрэгтэй.

7 дугаар зүйл. Дээд шүүх, Монгол Улсын Үндсэн хуулийн тавугаар зүйл, Шүүхийн тухай хуулийн 24 дүгээр зүйлд заасан дор урсан асуудлыг хэлэлцэж шийдвэрлэх эрхтэй.

1/ Дээд шүүхийн ерөнхий шүүгч, шүүгчийн эсэргүүцэл, Монгол Улсын Ерөнхий прокурорын эсэргүүцэл, дүгнэлтээр бүх шатны гүүхийн таслан шийдвэрлэх тогтоол, шийдвэр, магадлал, тогтоол, гүүгчийн захирамжтай хэргийг хяналтын журмаар хэлэлцэх ийнхүү

хэлэлцэхдээ зөвхөн эсэргүүцэл, дүгнэлтийн үндэслэл, заалтаар хязгаарлахгүйгээр тухайн хэргийг бүхэлд нь хянана;

2/ Монгол Улсын хуулийг нэг мөр ойлгож, зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбарыг хэлэлцэх батлах;

3/ Дээд шүүхийн танхимын шүүн таслах ажиллагааны бодлого, үйл ажиллагааны тухай танхимын тэргүүн шүүгчийн мэдээлэл, шүүн таслах ажиллагаа түүнчлэн Монгол Улсын хууль, хууль, тогтоомжийн бусад акт, Дээд шүүхийн тайлбарыг шүүхийн практикт хэрэгжүүлэх, шүүхийн практик судлах ажлын талаар аймаг, нийслэл, сум буюу сум дундын, дүүргийн шүүхийн ерөнхий шүүгч, шүүгчдийн илтэл сонголыг хэлэлцэх;

4/ Дээд шүүхийн шүүгчийг шүүх танхимд хуваарилж, шүүх танхимын бүрэлдэхүүнийг батлах;

5/ Улс төрийн намуудыг бүртгэх, тэдгээрийн үйл ажиллагааг түр зогсоох, тараах тухай шийдвэрийн талаар гарсан гомдлыг хянан хэлэлцэх;

6/ Дээд шүүхийн ерөнхий шүүгч, Үндсэн хуулийн цэцийн гишүүн Шүүхийн ерөнхий зөвлөлд шүүхээс орох гишүүдийг сонгох, шүүхийн тэргүүн түшээ зэрэг дэв олгох тухай санал гаргах;

7/ Дээд шүүхийн дэргэдэх шүүгчийн сахилгын хороо болон шүүгчдийн мэргэшлийн хороо байгуулах;

8/ Монгол Улсын хуульд заасан бусад бүрэн эрхийг хэрэгжүүлэх.

8 дугаар зүйл. Дээд шүүхэд асуудал оруулж хэлэлцүүлэх эрхийг дор дурдсан байгууллага, албан тушаалтан эдэлнэ:

1/ эрүү, иргэн, захиргааны хэргийг хэлэлцүүлэх эрхийг Монгол Улсын Дээд шүүхийн ерөнхий шүүгч, шүүгчид Монгол Улсын Ерөнхий прокурор, ерөнхий прокурорын орлогч эсэргүүцэл дүгнэлт бичиж;

2/ Монгол Улсын хуулийг тайлбарласан тогтоолын төсөл оруулан хэлэлцүүлэх эрхийг Дээд шүүхийн ерөнхий шүүгч, танхимын тэргүүн шүүгч, шүүгчид тогтоолын төсөл боловсруулж, харин шүүхийн дэргэдэх шүүх судалгааны төв, аймаг, нийслэл, сумын буюу сум дундын, дүүргийн шүүхийн ерөнхий шүүгч, шүүгчид ерөнхий прокурор, бусад байгууллага, албан тушаалтан өөрсдийн боловсруулсан төслийг Дээд шүүхийн аль нэг шүүгчээр уламжлуулан өргөн барьж болно;

3/ Дээд шүүхийн танхим, аймаг, нийслэл сум буюу сум дундын, дүүргийн шүүх, тэдгээрийн ерөнхий шүүгч, шүүгчдийн сонголт, мэдээллийг хэлэлцүүлэх эрхийг Дээд шүүхийн бүрэлдэхүүнд ордог албан тушаалтан;

4/ Дээд шүүхийн шүүгчдийг танхимуудад хуваарилж, танхимын бүрэлдэхүүнийг батлуулах асуудлыг хэлэлцүүлэх эрхийг Дээд шүүхийн ерөнхий шүүгч,

5/ Улс төрийн намуудыг бүртгэх, тэдгээрийн үйл ажиллагааг түр зогсоох, тараах тухай шийдвэрийн талаар гарсан гомдлыг хэлэлцүүлэх эрхийг Монгол Улсын Дээд шүүхийн бүрэлдэхүүнд ордог албан тушаалтан, ерөнхий прокурор;

6/ Дээд шүүхийн ерөнхий шүүгч, Үндсэн хуулийн цэцийн гишүүн, Шүүхийн ерөнхий зөвлөлд шүүхээс орох гишүүдийг сонгох санал гаргах, Дээд шүүхийн дэргэдэх шүүгчийн сахилгын хороо, шүүгчдийн мэргэшлийн хороо байгуулах асуудал оруулах эрхийг Дээд шүүхийн бүрэлдэхүүнд ордог албан тушаалтан;

7/ Бусад асуудлыг хууль тогтоомжил заасан эрх бүхий байууллага, албан тушаалтан.

9 дүгээр зүйл. Энэ дэгийн 8 дугаар зүйлд заасан албан тушаалтан Дээд шүүхэд асуудал оруулан хэлэлцүүлж шийдвэрлүүлэхдээ хууль тогтоомжил заасан үндэстэл, журмыг баримтална.

**Гурав. Дээд шүүхийн хуралдааныг
товлон зарлах, бэлтгэлийг
хангах**

10 дугаар зүйл. Дээд шүүхийн хуралдааныг Дээд шүүхийн ерөнхий шүүгч буюу түүний эзгүйд орлож байгаа танхимын тэргүүн зүүгч товлон зарлаж хуралдуулна. Тэгэхдээ хуралдаан болох газар, ар, өдөр, цаг хэлэлцэх асуудал, түүний илтгэгч, урилгаар оролцогчийг тодорхойлно.

11 дүгээр зүйл. Хуралдаанаар хэлэлцэх асуудлыг Дээд шүүхийн бүрэлдэхүүн болон Ерөнхий прокурорт 3-аас доошгүй хоногийн мнө мэлэгдэж, холбогдох материалуудыг хүргүүлнэ.

12 дугаар зүйл. Дээд шүүхийн хуралдааны бэлтгэл хангах үүргийг ерөнхий шүүгч, асуудал оруулж буй шүүгчид, техник зохион байгуулалтын бэлтгэл хангах үүргийг хуралдааны нарийн бичгийн дарга зориулна.

13 дугаар зүйл. Дээд шүүхийн ерөнхий шүүгч хуралдаанаар тодорхой асуудлаар нэг буюу хэд хэдэн илтгэгчийг асуудлын ач холбогдол, шар хэмжээг харгалзан Дээд шүүхийн шүүгчдээс томилно. Гаардлагатай тохиолдолд асуудлыг бэлтгэх үүрэг бүхий ажлын хэргт Дээд шүүх, бусад байгууллагын төлөөлөгчдийг оролцуулж авна.

14 дүгээр зүйл. Дээд шүүхийн хуралдааны бэлтгэлийг хангах явцад хэлэлцэх асуудалтай холбогдох баримт бичиг, санал дүгнэлт, бусад материалыг нэмж шаардан авч болно.

15 дугаар зүйл. Дээд шүүхийн хуралдааны дэг журмыг сахиулах, оролцогсдын аюулгүй байдлыг хангах зорилгоор шүүхийн хуягийг ажиллуулах буюу цагдаагийн байгууллагын туслалцаа авч болно.

Дөрөв. Дээд шүүхийн хуралдааны ерөнхий журам

16 дугаар зүйл. Дээд шүүхийн хуралдааныг Дээд шүүхийн ерөнхий шүүгч, түүнийг эзгүйд орлож байгаа танхимын тэргүүн шүүгч даргална.

17 дугаар зүйл. Хуралдаан өдрийн 9-13 цагт, 14-18 цагт 2 цаг тутамд 15 минутын завсарлагатайгаар хуралдана. Шаардлагатай бол хуралдааныг 22 цаг хүртэл үргэлжлүүлж болно.

18 дугаар зүйл. Хуралдаанд оролцогчид бие биедээ хүндэтгэлийн үгээр хандан үг хэлэх, санал гаргахдаа даргалагчийн зөвшөөрөл авах, энэ дэгийг сахих, нэг асуудлаар нэг санал гаргах үүрэгтэй. Хуралдаанд оролцогчид бусдын үг хэлж, санал гаргаж байхад асуулт асуух зэргээр таслах, бусдыг доромжлох, гүтгэх, хараалын үг хэрэглэхийг хориглоно. Энэ дэгийг зөрчигчдөд хуралдаан даргалагч анхааруулах, сануулах хуульд заасан арга хэмжээг авч хуралдааны протоколд тэмдэглэнэ.

Тав. Дээд шүүхийн хуралдаанд хэрэг хэлэлцэх журам

19 дүгээр зүйл. Хэргийг дээд шүүхийн ерөнхий шүүгчийн томилсон илтгэгч илтгэнэ. Илтгэгч хэргийн бүх байдал, шүүхийн дүгнэлт, таслан шийдвэрлэх тогтоол, шийдвэр, магадлал, шүүгчийн тогтоол, эсэргүүцэл, дүгнэлт, тэдгээрийн үндэслэлийг цаг хугацааны дарааллаар, тодорхой нотлох баримтыг түшиглэн, хууль тогтоомжийн холбогдох бүх актын заалттай харьцуулан танилцуулна.

20 дугаар зүйл. Дээд шүүхийн ерөнхий шүүгч танхимын тэргүүн шүүгчид, шүүгчид эсэргүүцэл, Ерөнхий прокурор эсэргүүцэл дүгнэлтээ хэрэг хэлэлцэж эхлэхээс өмнө буцаан авах эрхтэй. Илтгэгч тухайн хэргийг илтгэж эхэлснийг хэрэг хэлэлцэж эхэлсэнд тооцно. Эсэргүүцэл дүгнэлтээ буцааж авсан тухайгаа хуралдааны нарийн бичгийн даргад эсвэл хуралдаанд амаар буюу бичгээр мэдэгдэнэ.

21 дүгээр зүйл. Нэгэнт хэрэг хэлэлцэж эхэлсэн бол хуралдаан ердийн журмаар хэлэлцэж тогтоол гаргах бөгөөд хэрэг хэлэлцэх явцад

эсэргүүцлээ буцааж авахгүйгээр харин эсэргүүцэл, дүгнэлтээ дэмжихээс татгалзаж болно.

22 дугаар зүйл. Эсэргүүцэл, дүгнэлтийг буцааж авсан бол түүнийг гаргаагүйд тооцож хэргийг зохих шүүхэд нь хүргүүлэн холбогдох байгууллага, хүмүүст мэдэгдэнэ. Дээд шүүхийн ерөнхий шүүгч, танхимын тэргүүн шүүгчид, шүүгчид, ерөнхий прокурор эсэргүүцэл, дүгнэлтээ буцааж авсан нь хуралдаанд энэ асуудлаар дахин эсэргүүцэл, дүгнэлт бичихэд саад болохгүй.

23 дугаар зүйл. Дээд шүүхийн бүрэлдэхүүн, Монгол улсын ерөнхий прокурор илтгэгчээс хэлэлцэж байгаа хэргийн талаар асуулт тавьж хариулт авч болно.

24 дүгээр зүйл. Шаардлагатай тохиолдолд Дээд шүүхийн хуралдаанд ялтан түүний өмгөөлөгч, хохирогч, зохигчид, тэдний төлөөлөгчид болон бусад хүмүүсийг байлцуулан мэдүүлэг, тайлбарыг сонсож болно. Түүнчлэн нэмж шаардан авсан баримт бичиг, санал дүгнэлт, бусад материалыг судлан хэлэлцэж болно.

25 дугаар зүйл. Хэргийг тал бүрээс нь бүрэн бодитойгоор хэлэлцээний дараа асуулт, хариултыг тасалж Монгол Улсын Ерөнхий прокурор дүгнэлт гаргана.

26 дугаар зүйл. Монгол Улсын Ерөнхий прокурор дүгнэлт гаргасны дараа шийдвэр гаргахын тулд хуульд заасны дагуу Дээд шүүхийн бүрэлдэхүүн зөвлөлдөнө. Зөвлөлдөх үед Дээд шүүхийн бүрэлдэхүүнээс өөр хүн байж болохгүй. Дээд шүүхийн бүрэлдэхүүн зөвлөлдөж шийдвэртэх асуудал нэг бүрээр саналаа илээр гаргана.

Зургаа. Дээд шүүхийн тайлбар, бусад асуудлыг хэлэлцэн батлах журам

27 дугаар зүйл. Монгол Улсын Хуулийг нэг мөр ойлгож, зөв хэргэлэх талаархи тайлбарын төслийн талаар Дээд шүүхийн ерөнхий шүүгчийн томилсон илтгэгч илтгэнэ. Илтгэгчид хуулийн тайлбарыг арга болсон шаардлага, түүний дотор уг хуулийг хэрэглэж байгаа практик, түүний ололт, дутагдал, тайлбарыг боловсруулсан явц, ролцуулсан байгууллага, эрдэмтэн, мэргэжилтэн, тайлбарын ономын үндэслэл зэргийг тусгасан байвал зохино.

28 дугаар зүйл. Тайлбарын төслийн талаар илтгэсний дараа Дээд шүүхийн бүрэлдэхүүн, Монгол улсын ерөнхий прокурор, урилгаар ролцогчид нар нь илтгэгч, Дээд шүүхийн холбогдох танхимын бүрэлдэхүүн, мэргэжилтэн, эрдэмтдээс тайлбарын талаар асуулт тавьж хариулт авч болно.

29 дүгээр зүйл. Тайлбарын төслийн талаар асуулт тавьж дууссан дараа Дээд шүүхийн бүрэлдэхүүн, урилгаар оролцогчид санал гаргана. Тэгэхдээ эхлээд урилгаар оролцогчид, Дараа нь Дээд шүүхийн шүүгчид санал гаргаж үг хэлнэ. Нэг хүн хоёр удаа 10 хүүртэл минут үг хэлж болно.

30 дугаар зүйл. Дээд шүүхийн хуралдаанд оролцогчид үг хэлж санал гаргасны дараа тайлбарын төслийг батлан гаргана. Ийнхүү батлан гаргахын өмнө шаардлагатай бол гарсан саналыг нэгтгэн судалж, төсөлд тусгах үүрэг бүхий найруулгын ажлын хэсгийг Дээд шүүхийн бүрэлдэхүүн, урилгаар оролцогчдын бүрэлдэхүүнтэйгээ байгуулж болно.

31 дүгээр зүйл. Дээд шүүхийн бүрэлдэхүүн тайлбарыг бүхэлд нь буюу зүйл, заалт бүрээр санал хурааж батална.

32 дугаар зүйл. Дээд шүүхийн хуралдаан бусад асуудлыг хэлэлцэхдээ энэ бүлэгт заасан журмыг адилтгэн баримтална. Гэхдээ нэг дөвшүүлэх зэрэг зохион байгуулалтын зарим асуудлаархи санаа хуралтыг нууцаар хурааж болно.

**Долоо. Дээд шүүхийн хуралдаанд санал
хураах, тогтоол гаргах, түүнийг
биелүүлэх журам**

33 дугаар зүйл. Дээд шүүхийн хуралдаан хэлэлцсэн асуудлыг оролцсон шүүгчдийн олонхийн саналаар шийдвэрлэж тогтоосгож гаргана.

34 дүгээр зүйл. Анхан шатны журмаар тухайн хэргийг хэлэлцэж оролцсон Дээд шүүхийн шүүгч уг хэргийг Дээд шүүхийн хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэхэд оролцож болохгүй.

35 дугаар зүйл. Дээд шүүхийн шүүгч санал гаргахдаа гүдгэлтэй эрхгүй. Санал хураахдаа ерөнхий асуудлаас эхэлж тодорхой асуудлаар дуусгана. Тодорхой хэрэг хэлэлцэн шийдвэрлэхдээ эхлээд эсрэг үүцэл, дүгнэлтээр санал хураана. Эхний санал олонхийн санал албал уг асуудлыг хэлэлцэх явцад гарсан саналаар санал хураах шаардлагагүй. Санал хуралтын дүнг тоон харьцаагаар, хэрэв өөр санал гаргаагүй бол "санал нэгтгэжээр" гэж хуралдааны протокол тэмдэглэнэ.

36 дугаар зүйл. Хэрэв цөөнх өөрсдийн саналын үндэслэлийг тайлбарлаж дахин санал хураалгах хүсэлт гаргаж, түүнийг нь олон дөвшөөрвөл тухайн асуудлаар дахин нэг удаа санал хурааж болно.

37 дугаар зүйл. "Зөвлөлдөх тасалдаанд гаргасан саналыг зөвлөлдөх тасалдааны болон байгууллагын нууцад хамааруулан, задруулах"

гүйгээр чанд нууцлана. Санал хуралтын дүнг тухайн асуудал шүүгчдийн олонхийн санал авсан", "олонхийн санал аваагүй" гэсэн хэмжээнд мэдэгдэнэ.

38 дугаар зүйл. Дээд шүүхийн шүүгчдийн санал тэнцвэл олонхийн санал аваагүй гэж үзэж эсэргүүцэл, дүгнэлтийг хэрэгсэхгүй болгож асуудлыг шийдвэрлэгдээгүйд тооцно.

39 дүгээр зүйл. Дээд шүүхийн тогтоолыг илтгэгч хариуцан 3 хоногийн дотор бэлтгэнэ. Тогтоолд хуралдаан даргалагч, илтгэсэн шүүгч гарын үсэг зурж, Монгол Улсын Дээд шүүхийн тамга дарна. Дээд шүүхийн тогтоол нь баталсан үеэс эхлэн хүчин төгөлдөр болно.

40 дүгээр зүйл. Монгол Улсын хуулийг тайлбарласан Дээд шүүхийн тогтоолыг уг актыг хэрэглэж байгаа улс, олон нийтийн бүх байгууллага, тэдгээрийн албан тушаалтан, иргэд заавал биелүүлэх үүрэгтэй. Дээд шүүхийн тогтоолыг хуульд заасан журмын дагуу биелүүлэх бөгөөд биелэлтийг тамгын газрын хяналт шалгалт хариуцсан гүшмэл зохион байгуулан гардан хариуцна. Дээд шүүхийн тогтоолд гүүнийг биелүүлэх байгууллага, албан тушаалтныг тухайлан зааж болно.

41 дүгээр зүйл. Шаардлагатай тохиолдолд Дээд шүүхийн хуралдаанаас эрх зүйн зөрчил, түүний дотор хэрэг бүртгэлт, урьдчилсан өөрдөн байцаалт, шүүн таслах ажиллагааны үед гаргасан зөрчил, үүнийг гаргахад нөлөөлсөн шалтгаан, нөхцөлийг арилгах арга хэмжээ авахуулахар зохих байгууллага албан тушаалтанд энгийн магадлал гаргаж болно. Энгийн магадлал авсан байгууллага, албан тушаалтан түүний мөрөөр нэг сарын дотор тодорхой арга хэмжээ авч, 7 дүнг Дээд шүүхэд мэдэгдэх үүрэгтэй.

42 дугаар зүйл. Дээд шүүхийн хуралдааны явцын талаар тодорхой эмдэглэл хөтөлнө. Тэмдэглэлийг нарийн бичгийн дарга хөтөлж, уралдаан даргалагч гарын үсэг зурж, Дээд шүүхийн тэмдэг дарна. Уралдааны явцыг дүрс болон дуу бичлэгийн хэрэгслэлээр бичиж авсан бол тэмдэглэлийн хамт хадгална.

43 дугаар зүйл. Дээд шүүхийн хуралдааны тэмдэглэлд шүүгч наас хуулийн тайлбарын төслийн талаар гарсан саналыг бичнэ. Харин тодорхой хэргийн талаар гаргасан саналыг бичихгүй. Шүүгчдийн саналыг нууцаар хураасан дүн, саналын хуудсыг Дээд шүүхийн үрэлдэхүүнээс бусад албан тушаалтанд үзүүлэх, хуулбарлахыг хориглоно. Харин тэмдэглэлийн бусад хэсгийг Дээд шүүхийн ерөнхий гүүгч, тухайн хуралдаан даргалагчийн зөвшөөрснөөр хэрэг, маргаам оролцогч талуудад танилцуулж болно.

44 дүгээр зүйл. Шүүгчдийн зөвлөлдөх тасалгааны нууц, нууцаар явагдсан санал хураалтыг задруулсан албан тушаалтанд хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

45 дугаар зүйл. Дээд шүүхийн хуралдааны тухай Монгол Улсын Дээд шүүхийн ерөнхий шүүгч, тухайн хуралдаан даргалагчийн зөвшөөрсөн хэмжээгээр хэлэл мэдээллийн хэрэгслэлээр дамжуулан олон нийтэд мэдээлж байна.

СЭТГҮҮЛИЙН ЗӨВЛӨЛ

Ерөнхий эрхлэгч	Н. Ринчэндорж
Нарийн бичгийн дарга	Сан. Жаргалсайхан
Гишүүд	Т. Баасансүрэн Ч. Бавуу Б. Ганбат Б. Янжигалхам
Техник редактор	С. Итгэлт
Уншиж хянасан	Сан. Жаргалсайхан Б. Янжигалхам

Үйлдвэрт шилжүүлсэн 1996 оны 6-р сарын 28-нд
Өрөлтөд 1996 оны 7-р сарын 1-нд. Хэвлэлтэд
1996 оны 7-р сарын 24-нд. Хэвлэлийн хуудас 5,0
Хэвлэсэн тоо 4200

Манай хаяг: Улаанбаатар-12
Төрийн ордон. Утас 322838

Засгийн газрын хэвлэх үйлдвэр